**“Оюу толгой” ХХК**

Нийгмийн Хариуцлага

Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2015 оны 9 дүгээр сар

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО:

## Агуулга


**1 УДИРТГАЛ......6**

Тойм......6

Хамрах хүрээ......7

Үйл ажиллагааны тодорхойлолт......8

Уурхайн эзэмшил, удирдлага......9

Үйл ажиллагааны байршил......10

**2 ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО......10**

**3 СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ......11**

Мэдээллийн эх сурвалж......11

Засаг захиргаа, хүн ам зүйн үндсэн онцлог......11

Малчдын газар ашиглалт......13

Малчдын эдийн засгийн үйл ажиллагаа, орлого......15

**4 НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ......20**

Нөлөөллийн бүсийг тодорхойлох......21

**5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ......25**

**6 ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ......28**

Нүүлгэн шилжүүлсэн өрхүүд (2004)......28

Нөхөн олговрын гэрээ байгуулсан өрхүүд (2011)......31

**7 ХАНБОГД СУМАНД ҮЗҮҮЛЭХ ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ......37**

Судалгаа, үнэлгээ......44

Өрхийн уулзалт......47

**8. ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ......49**

Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газрын зуучлал/Гурван талт зөвлөл......49

Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговортой холбоотой өргөдөл гомдлын тойм ....................50

**9. ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА ..................................................51**

Эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих ОТ компанийн арга барил ..........................................53

**10. ЦААШИД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .............54**

Ерөнхий тойм ...................................................................................................................54

Дотоод хяналт-шинжилгээ................................................................................................55

Хөндлөнгийн хяналт-шинжилгээ ......................................................................................60

Гүйцэтгэлийн аудит...........................................................................................................65

**11 МЭДЭЭЛЭЛ БА БАРИМТЫН УДИРДЛАГА .............................................................66**

**12 АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ, ХАРИУЦЛАГА.............................................................66**

Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн баг ..........................67

Ханбогд сумын засаг захиргаа ..........................................................................................70

**13 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ТӨСӨВ ....................................................71**

**14. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭД БАРИМТЛАХ ЦААШДЫН ЧИГЛЭЛ...........................72**

**15 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ ......................................................................................77**

**ХАВСРАЛТУУД**

Хавсралт 1: Ашигласан ном зүй болон анхдагч мэдээллийн эх үүсвэрийн тухай товч танилцуулга ..........................................................................................................78

Хавсралт 2: ХУУЛЬ ЭРХЗҮЙН ТОГТОЛЦОО ..........................................................................82

Хавсралт 3: Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөө, нөлөөллийн бүс ..........................................27

Хавсралт 4: Оюу Толгой төслийн нөхөн олговрын багц, 2011..........................................48

Хавсралт 5: МАЛЧИН ӨРХҮҮДИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ (2011)120

Хавсралт 6: МАЛЧИН ӨРХҮҮДИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ (2014)126

Хавсралт 7:..........................................................................................................................133

Хавсралт 8: ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ.............................................................136

Хавсралт 9: ЭМЗЭГТ ӨРХИЙН ДЭМЖЛЭГ .........................................................................137

Хавсралт 10: ....142

## ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Ханбогд сумын хүн ам зүйн хандлага, 2008-2014....11

Хүснэгт 2: Нөлөөлөлд шууд өртөж буй малчин өрхүүд, 2014 он....12

Хүснэгт 3: 2011, 2014 онуудад шууд нөлөөлөлд өртсөн малчдын эдийн засгийн үйл ажиллагааны судалгааны тоо баримт....16

Хүснэгт 4: Ханбогд сумын нийт малын тоо, 2010-2014 он....18

Хүснэгт 5: Ханбогд сумын малчдын орлогын мэдээлэл, 2011, 2013 он, хувиар....20

Хүснэгт 6: Сонгосон өрхүүдийн мал аж ахуйн бус орлогын эх үүсвэр....20

Хүснэгт 7: ОТ-н нөлөөллийн бүсэд байгаа өрхийн тойм мэдээлэл....23

Хүснэгт 8: Эдийн засгийн нөлөөлөлд өртсөн малчдын хөндсөн асуудал, түүнийг бууруулах ОТ-н арга хэмжээний тойм....25

Хүснэгт 9: Эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрыг олгосон байдал, 2011....31

Хүснэгт 10: Нөлөөлөлд өртсөн өрхийн үндсэн тоон мэдээлэл, 2011-2014....35

Хүснэгт 11: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын матриц....54

Хүснэгт 12: Малчин өрхийн хяналт-шинжилгээ....56

Хүснэгт 13: Шууд болон хавсарсан нөлөөлөлд өртсөн өрхүүдийн гүйцэтгэлийн үзүүлэлт....62

Хүснэгт 14: Гүйцэтгэлийн аудитын үеэр авч үзэх Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд....65

Хүснэгт 15: Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлага....67

Хүснэгт 16: Нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын үйл ажиллагааны алхмууд....74

## ЗУРАГ

Зураг 1: ОТ-н үйл ажиллагаа, түүний дагалдах дэд бүтцийн байршил, нөлөөллийн бүс....10

Зураг 2: Оюу Толгой төслөөс хойд зүгт байрлах малчдын нутагладаг бууц, худаг....13

Зураг 3: Оюу Толгой төслөөс өмнө зүгт байрлах малчдын нутагладаг бууц, худаг ............14

Зураг 4: Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын малчин өрхийн тоо ............18

Зураг 5: Нөлөөллийн бүс, өвөлжөө (Хойд) ............22

Зураг 6: Нөлөөллийн бүс, өвөлжөө (Өмнөд) ............22

Зураг 7*: Нөлөөллийн болон нөлөөллийн бус талбай дахь малын эрүүл мэнд* ............39

Зураг 8. Ханбогд, Манлай, Баян-овоо сумдын шууд болон хавсарсан нөлөөлөлд өртсөн өрхүүд төсөл, хөтөлбөрт оролцсон байдал ............45

Зураг 9. Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт иргэд болон нөлөөлөлд өртсөн иргэдийн тоо ............46

Зураг 10. Бүртгэгдсэн гомдлын төрлүүд, шийдвэрлэгдсэн байдал: 2013-2015 ............51

# 1 УДИРТГАЛ

## Тойм

Оюу Толгой ХХК ("ОТ") нь Монгол улсын өмнийн говийн бүсэд ОТ-н зэс, алтны ил уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэр, холбогдох дэд бүтцийн үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд газрын гадарга дээрх уурхайн ул мөрийг аль болох бага байлгах замаар далд уурхайн томоохон бүтээн байгуулалт дээр төвлөрөн уурхайгаа өргөтгөхөөр төлөвлөсөн билээ.

ОТ нь өргөргийн 43°00'45"Х, уртрагийн 106°51'15"З солбицолд, 8,625 га талбайг (га) хамарсан 6709А дугаартай ашиглалтын нэг лицензийн (АЛ)–ийн талбайд үйл ажиллагаагаа эрхэлдэг. Энэхүү АЛ талбай нь Улаанбаатар хотоос урагшаа 550 км, Хятад-Монголын хилээс хойшоо 80 км-т Өмнөговь аймгийн Ханбогд суманд оршино (Зураг 1-ийг үзнэ үү).

Айвенхоу Майнз Лимитэд (одоогийн Туркойз Хилл Ресурс) болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компани Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ (ХОГ)-нд 2009 оны 10 дугаар сард гарын үсэг зурсан. Хөрөнгө оруулалтын гэрээгээр ОТ төслийн үйл ажиллагааг явуулах санхүү, хууль эрх зүйн орчинг тодорхойлж, Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) төслийн 34 хувийг эзэмших болсон бөгөөд нөхцөлийг тухайн үед харилцан тохиролцвол 30 жилийн дараа тус төсөл дахь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлэх боломжтой.

ОТ-н нөөцийн 2003 оны нарийвчилсан үнэлгээний дүнд Уурхайн лицензит талбайгаас арван малчин өрхийг [1] нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон. Үүний дагуу, эдгээр малчин өрхтэй Нүүлгэн шилжүүлэх тухай гэрээ байгуулж, өрхийн тэргүүн, Ханбогд сумын Засаг дарга, Айвенхоу Майнз Лимитедийн Гүйцэтгэх ерөнхий захирал нар тус тус гарын үсэг зурсан. Эдгээр 10 малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох нөхцөл, хэрэгжилт, удирдлагыг тодорхойлсон үндсэн баримт бичиг нь 2004 оны 9-р сарын *"Малчдыг нүүлгэн шилжүүлэх тухай гэрээ" болно.*

Мөн 2011 оноос уурхайн барилга байгууламж, дагалдах дэд бүтцийн барилгын ажлыг бүрэн явуулахын тул биет нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй хэдий ч, 89 Малчин өрхийг эдийн засгийн хувьд нөлөөлөлд орсон гэж тодорхойлсон. Нөлөөлөлд өртсөн 89 Малчин өрхтэй дэд бүтцийг барихтай холбоотой Нөхөн олговрын гэрээний хэлцэл хийж, эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговор олгох нөхцлийг тохиролцож, нөлөөлөлд өртсөн өрхийн тэргүүн, Ханбогд сумын Засаг дарга, ОТ-н Нийгмийн хариуцлагын асуудал хариуцсан Дэд ерөнхийлөгч нар гарын үсэг зурсан болно. Цөөн тооны өрх нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөллийн гэрээнд аль алинд нь хамрагдсан.

Уурхайн үйл ажиллагаа, холбогдох барилга байгууламжийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг (БОННБҮ)-г 2013 онд боловсруулсан. Энэ явцад Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ)-д нэмэлт өөрчлөлт оруулж улмаар БОННБҮ-ний төлөвлөгөөний нэг хэсэг болгосон. Энэхүү 2015 оны 9 дүгээр сард шинэчилсэн НШҮАТ-нд 2004 онд уурхайн лицензит талбайгаас 10

[1] 16 гэр бүлийг хамарна – үүнээс хэд хэдэн өрх нь нийлмэл гэр бүлээс бүрдэнэ

малчин өрхийн нүүлгэн шилжүүлэлт, мөн 2011-2013 онуудад уурхайг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалтын улмаас 89 өрх эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхийн тухайн үеийн байдлын талаар тусгасан. Түүнчлэн, 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нөлөөллийг хянан, үнэлэх, түүнийг бууруулах ажлыг 2015 оноос цаашид хэрхэн үргэлжлүүлэх, далд уурхайн цаашдын өргөтгөлийн явцад үүсч болзошгүй аливаа шинэ нөлөөллийг ОТ-н зүгээс хэрхэн удирдах тухай заасан болно.

**НШҮАТ-ний зорилт**

Энэхүү НШҮАТ нь дараах зорилттой болно. Үүнд:

- ОТ-н бүтээн байгуулалтын үндсэн үе шат дууссантай холбоотой газар эзэмшил, нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөлтэй холбоотой стандартуудыг хянах, шинэчлэн боловсруулах,
- ОТ-н үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөллийг үр дүнг тодорхойлох,
- Нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийн ангилал, тэдгээр нь хэрхэн нөлөөлөлд өртөж буй, ОТ-н үйл ажиллагаанд хэрхэн дасан зохицож буйг харуулах,
- Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргааг дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нүүн шилжсэн, нөхөн олговор авсан малчин өрхийн амьжиргааг сэргээх, сайжруулахад хэр үр дүнтэй байсныг хянах,
- Нүүлгэн шилжсэн, эдийн засгийн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдийн талаар баримталж буй хяналт-шинжилгээний хүрээ, журам, зөвлөлдөх арга хэрэгсэл, үүрэг, хариуцлага, шаардлагыг тодорхойлох,
- Малчдыг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын гэрээг хаах нөхцлийг нүүлгэн шилжүүлсэний дараах нөхцөл байдалд дасан зохицож чадсан байдалтай уялдуулан тодорхойлох,
- Ирээдүйд гарч болох аливаа (бага хэмжээний) нүүлгэн шилжүүлэх шаардлагыг хэрхэн зохицуулахыг тусгах,
- Үйл ажиллагааны үе шат дахь нүүлгэн шилжүүлэлт, нөлөөлөлтэй холбогдуулан нутгийн ард иргэдтэй харилцах , тайлагнах журмыг тодорхойлох зэрэг болно.

## Хамрах хүрээ

ОТ НШҮАТ-г 2015 оны 8-9 дүгээр сард боловсруулсан бөгөөд энэхүү төлөвлөгөө нь 2010 оны 9 дүгээр сард боловсруулсан, 2013 онд шинэчлэн найруулсан НШҮАТ-тай уялдаж байгаа боловч эдгээр хувилбар дээр суурилаагүй болно. Барилга бүтээн байгуулалтын үе шатанд боловсруулсан, шинэчлэн найруулсан НШҮАТ-тай харьцуулахад энэхүү хувилбар хэмжээ, агуулгын хувьд нилээд багассан бөгөөд ОТ-н барилга бүтээн байгуулалтын дараах, үйл ажиллагааны эхэн үе шатны нөхцөл байдлыг тусгасан болно. Дэлгэрэнгүй мэдээлэл авах, тодруулах зүйлийг барилга бүтээн байгуулалтын үе шатанд боловсруулсан, шинэчилсэн НШҮАТ болон бусад холбогдох баримт бичиг (Хавсралт 1-ийн Ном зүйд жагсаасан)-ээс үзэх боломжтой юм. ОТ шинээр томоохон хэмжээний газар ашиглах шаардлагатай болвол, энэ үе шатанд төлөвлөөгүй ч НШҮАТ-ний хамрах хүрээг тэлэх болно.

### Үйл ажиллагааны тодорхойлолт

ОТ-н үйл ажиллагаанд зориулан газрын гадарга дээр барьж байгуулсан бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг НШҮАТ-ийн өмнөх хувилбаруудад тусгасан болно. Хойд Хюго ордыг блокчлон олборлох ирээдүйн далд уурхай, Өмнөд Оюу ордод зэс-алт олборлож буй ил уурхайн бүтээн байгуулалтын ажил, өдөрт 100,000 тонн[2] баяжмал боловсруулах хүдрийн баяжуулах үйлдвэр, дагалдах дэд бүтцийн ажилд БОННБҮ хийсэн.

Өнөөгийн үйл ажиллагаа, холбогдох дэд бүтэц нь дараах томоохон үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- **Уурхайн лицензит талбай:** Энэ талбайд ил уурхай, далд уурхайн талбай, мөн баяжуулах дэд бүтэц, 100,000 тонн/хоног хүчин чадалтай баяжуулах үйлдвэр, хаягдал хадгалах байгууламж (ХХБ), хаягдал чулуулгийн овоолго зэрэг дагалдах боловсруулах дэд бүтэц багтана. Уурхайн лицензит талбайг бүхэлд нь хашаалсан бөгөөд нийт талбайн хэмжээ 8.625 га юм.
- **Гүний хоолойн усны шугам хоолой, эх үүсвэрийн талбай:** хүдэр баяжуулах усаа ОТ-оос зүүн хойно 35-75 км-т сунаж орших Гүний Хоолойн (ГХ) газрын гүний усны сав газрын эх үүсвэрээс авдаг. Усны эх үүсвэрийн талбайн зүүн өмнөд, зүүн хойд хэсэгт гүний худаг гаргаж, ус хангамжийн шугам хоолой доголдсон онцгой нөхцөлд ашиглах нөөцийн санг шугам хоолойн дагуу байгуулсан.
- **Нисэх онгоцны буудал:** Томоврын нисэх онгоц газардах боломжтой олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан хөөрөх, буух зурвастай Ханбумбат нисэх онгоцны буудал нь уурхайн лицензит талбайгаас хойш 13 км-т байрлана. Барилга бүтээн байгуулалтын үе шатанд ашигласан, ойролцоо орших түр нисэх онгоцны буудлыг эргүүлэн малын бэлчээр болгон нөхөн сэргээсэн бөгөөд тус бэлчээрийн талбайг одоогийн байдлаар улирлын чанартай ашиглаж, орон нутгийн малчид, захиргаатай хамтран идэвхтэй хянан удирдаж байна.
- **ОТ-ГС чиглэлийн баяжмал тээвэрлэх автозам:** Бараа, материалыг Монгол-Хятадын хил хүртэл хатуу хучилттай авто замаар тээвэрлэж, БНХАУ-д зэсийн баяжмал нийлүүлж байна. ОТ-н барьсан энэхүү зам нь цаашид Монгол Улсын авто замын сүлжээний нэг хэсэг болох бөгөөд Монгол Улсын Засгийн газар ашиглалт, арчилгаа, засвар үйлчилгээг нь хариуцна.
- **Эрчим хүч, эрчим хүч дамжуулах шугам:** Цахилгаан эрчим хүчийг одоогийн байдлаар Хятадын хойд хэсэг дэх Өвөр Монголын Өөртөө Засах Орноос (ӨМӨЗО) импортлодог бөгөөд үүнд зориулсан цахилгаан дамжуулах шугамыг ОТ болон БНХАУ-тай хилийн хооронд, мөн зүүн хойшоо Ханбогд сум руу 42 км зайд татсан. Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөлийн дагуу үйл ажиллагааны дөрөв дэх жилээс Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цахилгаан станцаас эрчим хүч авах ёстой бөгөөд Оюу Толгой компани нь өөрөө цахилгаан станц барьж, ажиллуулах шаардлагагүй.
- **Ажилчдын орон сууц:** Барилгын үеийн ажилчдад зориулсан кэмпийн орон сууцанд 2011 оны сүүлчээр оргил ачааллын үед 14,800 ажилчид байрлаж байсан. Эдгээр орон сууцыг аажмаар буулгахын сацуу одоо байгаа болон цаашдын далд уурхайн бүтээн байгуулалтад ажиллах ажилчиддаа хангалттай орон сууц авч үлдэж байгаа. Үйл ажиллагааны үе шатны 3,500 ажилчид

[2] Энэ нь дундаж хүчин чадал бөгөөд засвар үйлчилгээний зогсолт болон бусад зогсолтыг харгалзан баяжуулах үйлдвэрийн дээд хүчин чадал нь өдөрт 110,000 тонн хүдэр болно.

уурхайн лицензит талбай дахь кэмпэд байрлаж буй бөгөөд эдгээр нь хотоос онгоцоор ирж, буцдаг ажилчид, мөн ихэвчлэн уурхайгаас зүүн хойшоо 42 км-т орших Ханбогд сумаас өдөр тутам ирж, буцдаг орон нутгийн ажилчид байна. Уурхайн лицензит талбайн гадна ажилчдын суурин байдаггүй.

Далд уурхайн өргөтгөлийн ажилд зориулж өнөөгийн үйл ажиллагаа, дэд бүтэц барилга байгууламжийн “газрын гадаргүй дэх ул мөр буюу талбайг”их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагагүй. Одоогийн байдлаар уурхайг 27 жилийн турш ашиглана гэж тооцоолж буй боловч Оюу Толгойд нөөц үүнээс их байх магадлалтай тул энэ нь *зөвхөн* техник эдийн засгийн үндэслэл дэх нөөцөд тулгуурлаж тооцсон уурхайн ашиглалтын хугацаа. Тус хугацаанаас хойш уурхайг нийтдээ 60 жил ашиглах магадлалтай.

## Уурхайн эзэмшил, удирдлага

”Оюу толгой” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь:

- Туркойз Хилл Ресурс – 66%
- Монголын Улсын Засгийн газар (34%) юм.

Рио тинто нь Туркойз Хилл Ресурсын 51% хувьцааг эзэмшиж Оюу Толгойн үйл ажиллагааг хариуцдаг юм.

### Үйл ажиллагааны байршил

*Зураг 1-д Төслийн байршил болон төслийн нөлөөллийн бүсийг харууллаа.*

**Зураг 1: ОТ-н үйл ажиллагаа, түүний дагалдах дэд бүтцийн байршил, нөлөөллийн бүс**




## 2 ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

Нүүлгэн шилжүүлэлт, нөлөөллийн талаарх хууль эрх зүйн тогтолцооны дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 2-д оруулсан болно.

# 3 СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Мэдээллийн эх сурвалж

Газар чөлөөлөх, холбогдох үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн ОТ-н байгаа бүс нутаг, айл өрхүүдийн нийгмийн асуудлыг тодорхойлж, хянах зорилгоор Оюу Толгой өнгөрсөн арван жилийн турш нарийвчилсан судалгаа хийлгэж, ОТ-н нөлөөллийн бүсийн иргэдтэй өргөн хүрээтэй хэлэлцүүлэг хийсэн. Үндсэн мэдээллийн эх сурвалжийн хураангуйг Хавсралт 1-д үзүүлэв.

## Засаг захиргаа, хүн ам зүйн үндсэн онцлог

ОТ-н бүх байгууламж, дагалдах дэд бүтэц нь Ханбогд сумын нутагт оршдог. ОТ уурхайн лицензит талбай, ихэнх дэд бүтцийн зурвас газар (ОТ-ГС зам, цахилгаан дамжуулах шугам), Ханбумбат нисэх онгоцны буудлын зарим хэсэг нь Жавхлант багийн нутагт оршино. Ханбумбат нисэх онгоцны буудлын өөр хэсэг нь Гавилууд багийн нутаг руу тэлсэн байдаг. Гүний хоолой сав газрын ус хангамж, дэд бүтэц нь Баян багийн нутагт байрладаг бөгөөд Хятадын хил хүртэлх ОТ-ГС зам нь Номгон багийн нутгаар дайрч өнгөрнө.

Ханбогд сум 2014 онд 5,057 хүн амтай байсны 1,359 нь хөдөөний малчид, 3,698 нь сумын төвийн[3] оршин суугчид байсан аж. Сумын нийт хүн амын ойролцоогоор 40% нь нүүдлийн малчид гэж бүртгүүлсэн бол 18% нь малтай хэдий ч суурин байдлаар сумын төвд байнга оршин суудаг мал бүхий иргэд байна.

**Хүснэгт 1: Ханбогд сумын хүн ам зүйн хандлага, 2008-2014**

| Ханбогд сумын хүн ам 2014 он **Гол үзүүлэлтүүд** | **2008** | **2009** | **2010** | **2011** | **2012** | **2013** | **2014** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүн амын тоо | 3,041 | 3,154 | 3,522 | 3,948 | 4,300 | 4,712 | 5,057 |
| Хүн амын өсөлт, % | 2,3% | 3,8% | 11,6% | 12.1% | 8.9% | 9.5% | 7.3% |
| Эрэгтэй | 1,474 | 1,562 | 1,753 | 1,988 | 2,162 | 2,373 | 2,538 |
| Эмэгтэй | 1,567 | 1,594 | 1,769 | 1,960 | 2,138 | 2,339 | 2,519 |
| Өрх | 918 | 967 | 1,112 | 1,330 | 1,450 | 1,590 | 1,639 |
| Малчин өрх | 496 | 494 | 480 | 478 | 385 | 367 | 364 |
| Хөдөөгийн хүн ам | Байхгүй | 1,793 | 2,067 | 1,675 | 1,408 | 1395 | 1,359 |
| Сумын төвийн оршин | Байхгүй | 1,363 | 1,455 | 2273 | 2892 | 3,317 | 3,698 |
| Өрхийн ам бүлийн дундаж хэмжээ | 3,3 | 3,2 | 3,2 | 3 | 3 | 3 | 3.1 |

*Эх сурвалж: Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс, 2014*

[3] Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн байдал, , Статистикийн бюллетень, 2014 он

Албан ёсны статистик тоо баримтыг хэдийгээр цуглуулж, баталгаажуулсан ч бодит амьдрал дээр ямар нэг байдлаар зөрдөг. Сүүлийн долоон жилд явуулсан нийгэм-эдийн засгийн олон судалгаа, малчидтай зөвлөлдсөн байдлаас харахад Ханбогд сумын малчдын ахуй амьдралын хэв шинж, өөрчлөгдсөн байна. Сумын иргэдтэй хийсэн ярилцлага[4], ОТ компаниас тэдний гэрт нь очиж уулзсан байдлаас харахад ялангуяа залуучуудын дунд "хотожсон" үйлчилгээг илүү таашааж байна. Сайн чанарын суудлын автомашинууд элбэг болж, Ханбогд сумын алс өнцөг булан бүрт хэдэн цагийн дотор хүрч очдог болсон тул өнөөдөр олон айл өрх сумын төвд, мөн уламжлалт нүүдлийн гэрт амьдрах аль алиныг нь хослуулж байна. Тухайн өрхийн насанд хүрсэн зарим гишүүд, түүний дотор эхчүүд эсвэл ойрын төрөл садан болох хүмүүс сумын төвд монгол гэр, 1-2 өрөө энгийн тоосгон байшинд хүүхдүүдтэйгээ суудаг бол бусад насанд хүрсэн гишүүд хөдөө орон нутагтаа малаа хариулж үлддэг байна. Хоёр гэрийн хооронд ойр ойрхон, ихэвчлэн өдөр тутам явна. Энэхүү "хөдөлгөөнт байдлын нөлөө" нь малчин өрхүүд хүүхдүүдээ улсын дотуур байранд байрлуулахгүйгээр сургуульд сургах, шүдний болон өөр эмнэлгийн үйлчилгээ авах, хүнс, бусад бараагаа өдөр тутам худалдан авах зэрэгт нэлээд ахиц гаргасан. Тэр ч байтугай, зарим айл өрх малчид хөлслөн малаа хариулуулж, өөрсдөө сумын төвдөө байнгын суурьшдаг болжээ. "Хөлсний малчид" нь ихэвчлэн эдийн засгийн боломж муутай, Монгол улсын бусад сум, орон нутгаас ирсэн, Ханбогд суманд бүртгэлгүй иргэд байдаг бөгөөд маш бага цалин хөлс авдаг. Өрхийн түвшний анхан шатны нарийвчилсан тоо мэдээлэл байхгүйгээс энэхүү нөлөөг тоогоор илэрхийлэх боломжгүй юм.

2011 онд Ханбогдын малчин өрхийн гуравны нэг хараахан хүрэхгүй хувийг нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөллийн аль аль хэлбэрээр ОТ-н нөлөөлөлд шууд орсон гэж ангилжээ. Эдгээр өрхийн зарим нь нийлмэл өрхүүд байдаг. 2004, 2011 онд судалгаанд хамрагдсан 101 өрхийн ихэнхид нь эхнэр, нөхөр байсан бол 2014 он гэхэд ганц бие эрэгтэй өрх толгойлсон гурав, ганц бие эмэгтэй өрх толгойлсон найман айл өрх байсан. Ганц бие эмэгтэйчүүдийн ихэнх нь ахимаг насны, ихэвчлэн өөр гэр бүлийн хамтаар амьдарч байсан бол ганц бие эрэгтэйчүүд нь залуу, ихэвчлэн ганцаараа амьдардаг байв. Ханбогд дахь хүн амыг ерөнхийд нь авч үзвэл нөлөөлөлд орсон малчин иргэдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа тэнцвэртэй байсан5.

**Зураг 1: ОТ-н үйл ажиллагаа, түүний дагалдах дэд бүтцийн байршил, нөлөөллийн бүс**

Шууд нөлөөнд автсан малчин өрхийн хүн ам зүйл гол үзүүлэлтүүдийг доор харууллаа.

**Хүснэгт 2: Нөлөөлөлд шууд өртөж буй малчин өрхүүд, 2014 он**

| Үзүүлэлт | Тоо |
|---|---|
| Өрхийн тоо | 89 |
| Эдгээр өрхийн доторх гэр бүлийн тоо | 101 |
| Судалгаанд хамрагдсан хүний тоо | 331 |

[4] "Малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх тухай 2004 оны гэрээний хэрэгжилтийн аудит", "ХБ сумын хүн ам, орон сууцны тооллого", "Зах зээлийн товч үнэлгээ", "ОТ-н НШҮАТ-ний жил тутмын хяналт шинжилгээний судалгаа" г.м.

[5] Ханбогд сумын ЗДТГ –ын статистик, төрийн сан хариуцсан мэргэжилтэн , ОТ –н 2011 оны судалгаа

| | |
|---|---|
| Өрхийн ам бүлийн дундаж тоо | 3,7 |
| Ганц бие өрх толгойлсон гэр бүлийн тоо | 11 |
| Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй | 8 |

*Эх сурвалж: Зах зээлийн товч үнэлгээ, 2014 он, Бодлого судлалын төв (БСТ)*

## Малчдын газар ашиглалт

Ерөнхий тодорхойлолт, тоон мэдээллийн хандлагад хийсэн дүн шинжилгээ, тайлбарыг дараах хэсэгт орууллаа. Хэдийгээр асуудлууд нүүлгэн шилжүүлсэн, нөлөөлөлд өртсөн өрхүүдэд хамаарч байгаа боловч ерөнхий агуулгын дүн шинжилгээ нь Ханбогд сум дахь НШҮАТ-ний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, нөлөөллийг тодорхойлох, бууруулах, нөхөн олговрын гэрээний зорилтыг хангах, гэрээг хаах, мөн нийт сумын хэмжээнд НШҮАТ(шууд бус нөлөөнд өртсөн айл өрх гэх мэт) гарах хоёрдогч нөлөөллийг авч үзэхэд дараагийн үе шатанд нэн чухал юм.

ОТ-н барилга, бүтээн байгуулалтын үеийн малчид газар ашиглаж байсан хэв маягийн талаар өмнөх НШҮАТ-ийн баримт бичгүүдэд дэлгэрэнгүй тусгасан тул энд гагцхүү нөөц баялгийн ашиглалт, хандлагыг сүүлийн үеийн холбогдох тоо баримтаар шинэчлэн харуулсан болно. Тухайн үеийн малчдын нутагладаг бууц, худгийн тархац, нягтаршлыг харуулсан газрын зургийг 2 ба 3-р зурагт харуулав. Хэдийгээр ийнхүү “хөдөлгөөнт байдал” нь газар ашиглалт, айл өрхийн ахуй амьдралын хэв маягт нөлөөлсөн ч эдгээр малчдын нутагладаг бууц, худаг ихэнхдээ нэг байршилдаа хэвээр байна.

Малчид ихэвчлэн баг дотроо 3-35 км-ийн зайтай газарт улирлын чанартай болон өдөр тутам малаа бэлчээж нүүдэллэсээр байна. Гэхдээ зарим малчид ялангуяа гантай үед зэргэлдээх баг, сумдад малаа хариулах нь бий. 2013-14 онуудад хэд хэдэн малчид улирлын шинжтэй хур бороо багатай, ховор үед түүнээс илүү хол зайд малаа тууж бэлчээж байсан. 2015 онд хур бороо сайтай байсан тул дээрх нүүдэл хэвийн байдалдаа орсон.

Сүүлийн жилүүдэд өвөлжөөний загвар, барилгын материал нь өөрчлөгдөж байна. Уламжлал ёсоор малчид чулуун материал ашиглан өвөлжөө, малын хашаагаа барьж байсан бол сүүлийн үед ОТ болон бусад эх үүсвэрээс модон хайрцаг, дугуй зэрэг өөр төрлийн материалууд авч ашиглаж байна. Малчид малын хашаа хороо, агуулахын зориулалтаар жижиг барилгуудыг хагас дээвэрлэх, тусгаарлагч хана хийх зэрэг төрөл бүрийн материал хэрэглэх боломжтой өөр бусад шинэлэг санааг нэвтрүүлж байна. Түүнчлэн, малчид уламжлалт дан ганц гэр бус, суурин барилга буюу тоосгон байшин барьж эхэлж, олон иргэд Ханбогд сумын төвд оршин амьдарч үл хөдлөх хөрөнгө эзэмших болсон.

**Зураг 2: Оюу Толгой төслөөс хойд зүгт байрлах малчдын нутагладаг бууц, худаг**




Жич: Газрын зургийг НШҮАТ-д хамрагдах айл өрхийг тодорхойлох үед 2011 онд боловсруулсан бөгөөд өнөөгийн хяналт шинжилгээний үе шатанд ГМС-ийн арга хэрэгсэлээр шинэчилж байна.

**Зураг 3: Оюу Толгой төслөөс өмнө зүгт байрлах малчдын нутагладаг бууц, худаг**




Жич: Газрын зургийг НШҮАТ-д тохирох өрхүүдийг тодорхойлох үед 2011 онд боловсруулсан бөгөөд өнөөгийн хяналт шинжилгээний үе шатанд ГМС-ийн арга хэрэгсэлээр шинэчилж байна.

## Малчдын эдийн засгийн үйл ажиллагаа, орлого

Дийлэнхи малчдын хувьд орлогын цорын ганц эх үүсвэр нь мал аж ахуй хэвээр байгаа хэдий ч мал аж ахуйгаас гадна дэлгүүр ажиллуулах, улирлын чанартай цалинтай ажил хөдөлмөр эрхлэх зэрэг арилжааны үйл ажиллагаанаас нэмэлт орлого олдог малчдын тоо олширсон болно. Нөхөн олговрын ажлын хэсгийн удирдамжийн дагуу ОТ-оос 2011 онд явуулсан судалгаагаар нөлөөлөлд өртсөн 177 малчдын 66% нь малчин (эсхүл малчны гэр бүл) байж мал аж ахуйгаас амьжиргааны орлогоо бүрдүүлдэг гэсэн бол 25% нь мал аж ахуйгаас бусад салбарт ажилладаг байна (Хүснэгт 3). Мал аж ахуйгаас гадна өөр ажил хийж буй хүмүүст хувиараа хөдөлмөр эрхэлдэг, цэрэг, нягтлан бодогч, эмч, гал сөнөөгч болон ОТ-д хоол, хүнсний үйлчилгээ хханган нийлүүлдэг СиАйЭс компанийн ажилчид багтаж байна. Уг судалгаагаар 16 хүн (буюу 9%) ажилгүй гэж бүртгэгджээ.

Дээрх судалгааг 2014 онд явуулсан бөгөөд судалгаанд нөлөөлөлд өртсөн 253 малчдыг хамруулсан бөгөөд мөн адил 66% нь мал аж ахуйгаар амьжиргаагаа голлон залгуулдаг гэж хариулсан байна. Гэхдээ судалгаанд хамрагдагсадын нэг нь ч ажилгүй гэж хариулаагүй бөгөөд мал аж ахуйн бус салбарт ажиллаж буй хүмүүсийн хувь 34 хүртэл өсчээ. (Ханбогдод 2014 онд төрөөс ажилгүйдлийн тэтгэмж авдаг хүний тоо 15[6] байсан бөгөөд

[6] Ажилгүй олон хүн төрөөс тэтгэмж авдаггүй болохыг анхаарна уу.

тэдний дунд шууд нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүн байхгүй байсныг анхаарна уу). Хэдийгээр энэ чиглэлийн статистикийн олдоц муу боловч эдгээр судалгааны тоон мэдээллээс харахад судалгаанд хамрагдсан малчин хүн амын амьжиргаа сайжирсан байна.

**Хүснэгт 3: 2011, 2014 онуудад шууд нөлөөлөлд өртсөн малчдын эдийн засгийн үйл ажиллагааны судалгааны тоо баримт**

| **Эдийн засгийн үйл ажиллагаа** | **2011 оны Тоо/хүн** | **2011 оны Хувь** | **2014 оны Тоо/хүн**** | **2015 оны Хувь**** |
|---|---|---|---|---|
| Зөвхөн мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн тоо болон % | 132 | 66% | 166 | 66% |
| Мал аж ахуйгаас бусад салбарт/ эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийн тоо болон % | 45 | 25% | 87 | 34% |
| Ажилгүй* | 16 | 9% | 0 | 0 |
| **Судалгаанд хамрагдсан нийт хүмүүс** | 177 | 100% | 253 | 100% |

*Эх сурвалж: Нөлөөлөлд өртсөн болзошгүй малчин өрхийн судалгаа, ОТ, (2011 он)*

*# 18-65 настай, эдийн засгийн идэвхтэй хүмүүс (сурдаггүй, тэтгэвэрт гараагүй)*

** Судалгааны явцад өөрсдийгөө ажилгүй хэмээн мэдэгдсэн 18-65 насны ажилгүйчүүдийн тоо*

*** Зах зээлийн товч судалгаа, БСТ, 2014*

***Мал аж ахуйн бүтээгдэхүүн***

Ханбогд сумд гол төлөв ямаа, тэмээ, хонь (Хүснэгт 4) малладаг. 2014 онд Ханбогд сумын нийт малын 51% нь ноолуурын чиглэлийн ямаа, 25% нь хонь, 16% нь тэмээ байсан бол үлдсэн хувь нь адуу (5%), үхэр (3%) байв. 2010-2014 оны хугацаанд бүх төрлийн малын тоо толгой тогтвортой өссөн бөгөөд 91,000-аас 136,000 тоо толгой болж сүүлийн 5 жилд нийт 50%-иар өсчээ. Ийнхүү малын тоо тогтвортой өсөх болсон нь 2009-2010 оны хахир өвөл, зудны үеэр олон тооны мал хорогдсон боловч сүүлийн жилүүдэд эргээд сэргэхтэй холбоотой юм. Тухайн малын төрлөөс хамаарч малын үнэ цэнэ, бэлчээрт үзүүлэх нөлөөлөл зэрэг нь өөр өөр байдаг тул нийт малын тоогоор бэлчээрийн даац, нөлөөллийг тооцох нь хангалтгүй учир тодорхой тооцооллын тоо толгойд шилжүүлэх [7] нь зүйтэй юм.

“Өндөр үнэ цэнэтэй” тэмээ, адуу, , ноолуурын чиглэлийн ямаа зэрэг өндөр орлого бүхий малаас хамааралтай дээрх өсөлт нь хөрөнгө хуримтлалын хандлагыг мөн харуулж байна. 2012 онд Ханбогдын тэмээний тоо толгой 20,000 давсан нь Монгол улс дахь бусад сумдтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болсон бөгөөд орон нутгийнхний хувьд ихээхэн бахархах зүйл болсон юм. ОТ-д ажилладаг малчидтай ярилцахад айл өрхүүд илүү гарсан мөнгөөрөө мал худалдан авч, бусад гэр бүлийн гишүүд эсвэл хөлсний хүнээр хариулуулах болсон байна. “Идэвхтэй малчид” хэмээн өөрсдийгөө тодорхойлдог, тоо нь буурсаар буй айлуудыг (Хүснэгт 1) оролцуулсан дүн шинжилгээний тоон үр дүн, мэдээллээс харахад Ханбогд сумын нийт хүн амын амьжиргааны түвшин тогтвортой өсч байна. Үндсэндээ “Малчин айл” хэмээн өөрсдийгөө тодорхойлж буй айл өрхийн тоо 2010-2014 оны хооронд 480-аас 364 болтлоо буурсан (24 хувиар буурсан, Зураг 4-ийг харна уу) бол Ханбогд сумын малын тоо толгой огцом өссөн байна. Бэлчээр нутгаар явах тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэн, ган зуд болсон, мөн малын тоо толгой зарим жилд огцом өссөн нь бэлчээр доройтуулах үндсэн шалтгаан болж байна. Энэхүү хандлага малчин өрх гэсэн тодорхойлолтыг өөрчлөхөд мөн хүргэсэн. “Малчин өрх” гэж орлогын цорын ганц эсвэл гол эх үүсвэр нь мал аж ахуй болох айл өрхүүдийг хамруулахын зэрэгцээ хэдийгээр мал аж ахуйгаас бусад орлогын эх үүсвэртэй боловч малаа хамаатан садан эсвэл хөлсний малчнаар харуулдаг “мал бүхий өрх”-ийг тодорхойлно Ер нь малчид ихэвчлэн олон тооны мал авч, тэдгээрийг өөрсдөө хариулахгүйгээр эзэмших хүсэл эрмэлзэл оршин тогтож байгаа нь Монголын уламжлалт мал аж ахуйгаа эртнээс бахдаж ирсэн, уламжлалт мал аж ахуйгаа хадгалан үлдээх хүслийг илтгэж байна.

Ханбогд суманд малчин айлын тоо буурч буй үзүүлэлт зэргэлдээх Баян-Овоо, Манлай зэрэг сумдад ажиглагдаагүй нь ОТ-той холбоотой “хуримтлал үүсэх нөлөө”-г харуулж байна. Үүний эсрэгээр, цаг уурын нөхцөл, өрхийн байршилд ихээхэн өөрчлөгдсөн боловч малын тоо толгойн өссөөр байгаа нь ОТ-н зүгээс бэлчээрт нөлөө үзүүлсэн байсан ч уурхай байгуулагдахаас өмнөх үетэй харьцуулахад Ханбогдын нийт бэлчээрийн даац одоогоор хангалттай болохыг харуулж байна. Гэвч одоогийн малын тоо толгой тогтворгүй өсч буйтай холбоотойгоор энэхүү байдал нийтдээ тогтвортой байх талтай.

2013-2014 онуудад нийт малын тоо толгой, ялангуяа ямааны тоо толгойн өсөлтөд буурах хандлага ажигладаагүй болно. Мал бүхий өрхүүд үүнээс илүү орлоготой эх үүсвэр хараахан олоогүйгээс тоо толгойг нь өсгөхийг илүүд үзсээр байна. Энэхүү

[7] Энэхүү малын тоо толгой шилжүүлэх нэгжийг 1 бод мал = 1 үхэр, 1 морь, 0.69 тэмээ, 6 хонь, 8 ямаа гэж ойлгоно.

хандлагыг тогтмол хянах шаардлагатай бөгөөд өсөлт хэт нэмэгдэхтэй уялдсан арга хэмжээ (төрийн удирдамжийн дагуу ч байж болно)-г хөндлөнгөөс авч хэрэгжүүлэх боломжтой юм.

**Хүснэгт 4: Ханбогд сумын нийт малын тоо, 2010-2014 он**

| ***Он*** | **Тэмээ** | **Адуу** | **Үхэр** | **Хонь** | **Ямаа** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|
| 2010 | 17,527 | 4,475 | 2,250 | 25,665 | 41,167 | 91,084 |
| 2011 | 18,962 | 5,172 | 2,666 | 30,766 | 54,577 | 112,143 |
| 2012 | 20,389 | 5,878 | 2,982 | 33,615 | 60,427 | 123,291 |
| 2013 | 21,222 | 6,403 | 3,304 | 34,596 | 60,478 | 126,003 |
| 2014 | 22,655 | 6,561 | 3,486 | 34,048 | 69,717 | 136,467 |
| **Өсөлтийн хувь** | **29%** | 47% | 55% | 33% | 69% | 50% |

*Эх сурвалж: Өмнөговийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд, Статистикийн бюллетень, 2014 он*

**Зураг 4: Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын малчин өрхийн тоо**




Эх сурвалж: *Өмнөговийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд, Статистикийн бюллетень*

***Хүн ам ба малын усны эх үүсвэр***

Ус бол бэлчээрт нэн чухал байгалийн нөөц бөгөөд улирлын чанартай нүүдэллэж буудаг газруудад гол үүрэг гүйцэтгэдэг. Гадаргын усны байнгын, найдвартай эх үүсвэр байхгүй. Малчин айл ерөнхийдөө 5-7 м-ийн гүнтэй уламжлалт, гар аргаар гаргасан худгаас ундны болон мал услах усаа татаж ашигладаг бол зарим нь төрөөс, эсвэл ОТ-оос өрөмдөн гаргасан гүний худгийг ашиглаж байна. Ханбогд суманд байрлах худгуудыг хүн, малын аль аль нь ашиглаж байна. Ханбогд сумын ихэнх малчид хот айл, саахалт айлуудтайгаа худгаа

хамтран ашигладаг бөгөөд тэдгээр нь ихэнхидээ төрөл садангийн хүмүүс байдаг.

Түр урсгалтай булаг шанд, гар худаг нь үе үе буух хур тунадас болон хайрган тунадас дах уст давхаргаас тэжээгддэг. Малчдын хувьд малаа услахаар дундажаар 2.5 км зам туулдаг, бог мал өдөр тутам 3-5 км8-т бэлчиж, идээшилдэг. Цас, түр зуурын эх үүсвэрийн ус байхгүй үед мал усалгаа, хүн амын унд ахуйн хэрэглээнд худаг нэн чухал хүчин зүйл болдог. 2007 онд Ханбогд сумын малчдын дунд *Усны ойлголтын талаарх судалгаа* (280 малчин өрх) явуулж, усны чанар, хүртээмжийн талаар асуухад судалгаанд хамрагдсан малчдын 60% нь ерөнхийдөө усны хүртээмж сайн гэсэн боловч усны хэрэглээний оргил үе болох халуун зун, намрын улиралд заримдаа хомсдолтой байдаг гэжээ.[9] Түүнчлэн, Оюу толгой төсөлтэй зөвлөлдөх үеэр гарсан санал хүсэлтийг авч үзвэл ердийн үеийнхтэй харьцуулахад өнгөрсөн хэдэн жилд зарим газарт усны түвшин, худгийн усны ундарга буурч, улмаар нутгийн бэлчээрийн өвс ургамлын гарц багассан байна. Энэ нь цаг агаарын нөхцөл байдлаас хамаарах магадлал өндөр байдаг хэдий ч зарим малчид үүнийг ОТ-той холбогдуулан үзэж байна.

***Өрхийн орлого, эх үүсвэр***

2008 онд явуулсан *Өмнөговь аймгийн суурь судалгаагаар* Ханбогдын оршин суугчдын[10] өрхийн сарын дундаж орлого 575,000 төгрөг (380 ам.доллар)[11] байсан нь аймгийн дундаж 523,000 төгрөгөөс (350 ам.доллар) бага зэрэг ахиу байна. 2014 онд нөлөөлөлд өртсөн 89 өрхийн дунд явуулсан Зах зээлийн товч судалгаагаар Ханбогд сумын нэг гэр бүлийн дундаж орлого сард 1,8 сая төгрөг байсан.

Ханбогд суманд уул уурхайн салбарт ажиллаж буй иргэд сард дунджаар 267,000 төгрөгийн орлого олж байгаа нь мал аж ахуй эрхэлж буй иргэдийн орлогоос (132,000 төгрөг/сар) хоёр дахин их байна. Тэтгэврийн хүмүүс хамгийн бага орлоготой бол, нэг буюу түүнээс дээш тооны гишүүн нь цалин, хөлстэй ажил эрхэлдэг өрх хамгийн их орлоготойд тооцогдож байна. Эдгээр айл өрх мөн олон тооны малтай байдагийг тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ тоо баримтыг өрхийн судалгаанаас буюу судалгаанд хамрагдсан малчдын хэлсэнээр бүртгэж авсан учраас зарим орлогоо нэрлээгүй, багасгаж хэлсэн байх талтай юм.

Малчдын нийт орлогын дунджаар 46% ноолуур, 25% цалин, тэтгэвэр, 20% ноос, 6% мах, 3%-ийг сүү тус тус бүрдүүлдэг байна.

8 ОТ Төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа (тухайн боть), 2009
9 ОТ Төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа (тухайн боть ), 2009
10 Уг мэдээнд Ханбогд сумын төвийн иргэд, малчид хамрагдсан
11 Валютын ханшийг 2008 оны ханш буюу 1 ам.доллар=1,500 төгрөгөөр тооцсон.

**Хүснэгт 5: Ханбогд сумын малчдын орлогын мэдээлэл, 2011, 2013 он, хувиар**

| Орлогын эх үүсвэр, төрлөөр | 2011 | 2013 |
|---|---|---|
| Ноолуур | 46% | 47% |
| Ноос | 20% | 17% |
| Сүү | 3% | 2% |
| Мах | 6% | 7% |
| Бусад (цалин, тэтгэвэр) | 25% | 27% |

*Эх сурвалж: ОТ-н Малчин өрхийн судалгаа, 2011, 2013 он, n=72*

2014 онд явуулсан Зах зээлийн товч судалгаагаар нөлөөлөлд өртсөн 89 өрхийн 13 нь мал аж ахуйн бус бизнес эрхэлдэг болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь өрхийн нийт орлогын 10-90%-ийг бүрдүүлдэг ажээ (Хүснэгт 6).

**Хүснэгт 6: Сонгосон өрхүүдийн мал аж ахуйн бус орлогын эх үүсвэр**

| Код | Бизнесийн төрөл | Аж ахуйн нэгжийн нэр | Өрхийн орлогод эзлэх хувь, % |
|---|---|---|---|
| 1 | Дэлгүүр | Дэлгүүр | 90 |
| 2 | Гэрийн эсгий үйлдвэрлэл | Гурван тоосго ХХК | 55 |
| 3 | Дэлгүүр | Нэхий ХХК | 10 |
| 4 | Хүнсний дэлгүүр, блокны үйлдвэр | Далайн дуулга ХХК | 43 |
| 5 | Дэлгүүр | Эрдэнэ-Од ХХК | 71 |
| 6 | Хуучин түүхий эд авах | Хаан оорцог хоршоо | 31 |
| 7 | Дэлгүүр | Гэр бүлийн бизнес | 47 |
| 8 | ОТ-н хог хаягдал тээвэрлэх | Жавхлант говь ХХК | 19 |
| 9 | Ингэний сүү боловсруулах | Амин говь ХХК | 25 |
| 10 | Номын сан, ном | Гэр бүлийн бизнес | 25 |
| 11 | Оёдол, эсгүүр | Гэр бүлийн бизнес | 90 |
| 12 | Машины сэлбэгийн дэлгүүр | Гэр бүлийн бизнес | 47 |
| 13 | Ногоо тариалан | Гэр бүлийн бизнес | 10 |

*Эх сурвалж: ОТ-н Малчин өрхийн судалгаа, 2014 он*

Малчид мал хэмээх хөрөнгөтэй тул жижиг бизнес эхлүүлэх хөрөнгө босгох чадвартай (малаа зараад хөрөнгө босгох) бөгөөд зарим нь зам дагуу дэлгүүрт бараа зарж, цайны газар (Жавхлант багийн засварын газруудад байдагтай адил) ажиллуулдаг. Ханбогд сумын олон иргэд Гашуунсухайтын боомтоор хилийн наймаа хийх эсхүл Хятад руу хил гарч барилгын материал, бараа худалдаж аваад, Монголд буцаж ирээд борлуулна.

# 4 НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ

ОТ-н айл өрхөд үзүүлэх нөлөөлөл нь тэдний байршил, мэргэжлийн чиглэл, өрхийн тогтвортой байдлаас хамаарч янз бүр байдаг. 2004 онд Уурхайн лицензит талбайгаас нүүлгэн шилжүүлэх нөлөөнд шууд өртсөн, 2011-2013 онуудад дагалдах дэд бүтцийн

барилга бүтээн байгуулалтын үеэр бэлчээр шахагдсан, багасах нөлөөнд өртсөн өрхүүдийн талаар өмнөх НШҮАТ-д тусгасан. Харин энэхүү шинэчлэсэн НШҮАТ-д хэрэв хоёрдогч нөлөө илэрсэн тохиолдолд хэрхэх, мөн Ханбогд сумын бүх иргэд, малчдын амьжиргааг дэмжих, нөхөн олговроос өөр бусад дэмжлэг үзүүлэх, хяналт шинжилгээ хийхэд анхаарлаа хандуулсан болно. Ийнхүү дэмжлэгийн хамрах хүрээг өргөжүүлсэн нь нэг талаараа ОТ-н зүгээс тогтвортой бэлчээрийн менежментийн хөтөлбөрөөр дамжуулан Ханбогд сумын бүх малчдад туслах анхны үүрэг амлалтыг биелүүлэх, нөгөө талаараа нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын гэрээний хүрээнд нөхөн олговор авсан, аваагүй хэмээн иргэдийг хооронд нь “талцуулж”, иргэдийн дунд сөргөлдөөн үүсгэх эрсдэл байгаа талаар сумын удирдлагын зүгээс сэтгэл зовниж байгаагаа илэрхийлснийг мөн авч үзсэн юм. Мөн энэ нь нүүж шилжээгүй ч “нөлөөлөлд өртсөн өрхүүд” хэмээн бүртгэгдэх сонирхолтой малчдаас ирүүлсэн санал, гомдолтой уялдаж байна. Үүний хариу арга хэмжээ нь нийтийг хамарсан орон нутгийн тогтвортой харилцаа, дэмжлэг үзүүлэхэд голлон анхаарах болно.

## Нөлөөллийн бүсийг тодорхойлох

Шууд нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй харилцах, тэдгээрийг удирдан зохицуулах ажил хийгдэж байна. Уурхайн лицензийн талбайд урьд нь өвөлжөөтэй байсан арван малчин өрхийг тодруулснаар 2004 онд нүүлгэн шилжүүлсэн бөгөөд энэ ажил дуусгавар болсон (нүүлгэн шилжүүлсэн өрхийн тоог зарим тохиолдолд 11 гэх бөгөөд энэ насан хүрсэн хүүхдүүдтэй нэг айл нь хоёр өрхөөр бүртгүүлэхийг хүссэн). Наян есөн өрх (нүүлгэн шилжүүлсэн зарим өрх орно) Ханбумбат нисэх онгоцны буудал, Гүний хоолойн усны эх үүсвэрийн талбай, ОТ болон Хятадын хил дээрх Гашуунсухайтын боомт хүртлэх авто зам, цахилгааны шугамын барилгын ажилтай холбоотой газрын нөлөөллөөс үүдэн 2011 онд эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговор авах эрхтэй болсон.

Уурхайн цогцолбор, дагалдах барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглахад ОТ-д нийтдээ 10,500 га газар шаардлагатай байсан. Мөн түр нисэх буудал, уурхайн цогцолбороос гаднах ажилчдын кэмп/суурин барих, шороон орд ухах, усны шугам хоолой болон цахилгаан дамжуулах шугамын зурвасын дагуу хөрс хуулах зэрэг барилга бүтээн байгуулалтын үе шатанд газар түр хөндөж байсан.

Дээр дурдсанаар ОТ төслийн нийт "эзлэх талбай"-н хувьд компани газар ашиглах шаардлага, нөлөөлөлд өртсөн талуудын хоорондын харилцааг ангилах зорилгоор хэд хэдэн "нөлөөллийн бүс"-ийг тодорхойлж, зураглал хийсэн. Ханбогд сумаас бүрдүүлсэн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэсэг эдгээр бүсийн байршил, хамрах хүрээг харилцан тохирч, амьжиргааг дэмжих, бусад тусламжийн багц, түүнийг авах эрх бүхий өрхүүдийг тодорхойлсон болно.

Оюу Толгой төслийн бүрэлдэхүүн тус бүрийн нөлөөллийн бүсийг *Хүснэгт 7*-д тайлбарлаж, *Зураг 5*, *Зураг 6*-д тус тус үзүүлэв. Бүсийн тодорхойлолт, нөлөөллийн төрлийг Хавсралт 3-т зааж, Хүснэгт 10-д тоймлон харуулав.

**Зураг 5: Нөлөөллийн бүс, өвөлжөө (Хойд)**

CAD Ref: g1830_S_F001_01.dgn




**Зураг 6: Нөлөөллийн бүс, өвөлжөө (Өмнөд)**




*Тайлбар: Масштабын улмаас зөвхөн ерөнхий дүр зургийг харуулав. Дэд бүтцийн хажууд эсвэл түүнтэй маш ойр байгаа зарим өвөлжөө нь бодит байдал дээрээ хэдэн зуун метр эсвэл 1км-ээс хол зайд байдаг.*

Нөлөөллийн бүс бүрт дэх газар чөлөөлсөн, ашигласан, нөлөөлөлд өртсөн өрхийг доорх *Хүснэгт 7*-д харуулав. Нийт 10 өрхийг **нүүлгэн шилжүүлж,** 89 өрхөд нөхөн олговор олгосон.

**Хүснэгт 7: ОТ-н нөлөөллийн бүсэд байгаа өрхийн тойм мэдээлэл**

| Нөлөөллийн ангилал # | Нүүлгэн шилжүүлсэн | ОТ-н үйл ажиллагааны улмаас эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхүүд |
|---|---|---|
| А. Уурхайн лицензит талбай (УЛТ, Хориотой бүс) | А1. Уурхайн лицензит талбай дах өвөлжөө нь нөлөөлөлд өртсөн **10 өрх** (16 малчин гэр бүл, 61 хүнийг) –ийг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн. | Д1 Ангилалд хамрагдсан |

| | | |
|---|---|---|
| Б. Нисэх онгоцны буудлын талбай | Хамаарахгүй . | Б1. Нисэх онгоцны буудлаас 5 км-т өвөлжөөтэй 8 өрх зуслангийн бэлчээрийнхээ хэсгийг алдсан эсвэл хэмжээ нь буурсан<br>Б2. Нисэх онгоцны буудлаас 5-10 км-т өвөлжөөтэй **14 өрх** зуслангийн бэлчээрийнхээ хэсгийг алдсан эсвэл хэмжээ нь буурсан |
| В. ОТ-ГС замын зурвас газар | Хамаарахгүй | В1. Оюу толгой-Гашуун Сухайт чиглэлийн замын аль нэг талд 500 м-ийн дотор өвөлжөөтэй **4 өрх** бэлчээрээсээ түр хугацаанд холдож, бэлчээр, усваасаа хуваагдаж замын барилгын нөлөөнд өртсөн.<br>В2. Оюу толгой-Гашуун Сухайт чиглэлийн замын аль нэг талд 500 м, 6.5 км-т өвөлжөөтэй **15 өрхийн** оторлох, нүүдэллэх чиглэл, мал маллагаанд нь барилгын ажил, замын ажил түр зуур нөлөөлсөн. |
| Г. Гүний хоолойн усны шугам хоолой, БНХАУ-аас татах цахилгаан дамжуулах шугам | Хамаарахгүй | Г1. 1-р үе шатны Усны шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамын хоёр талд 1 км, 2-р үе шатны усны шугам хоолойгоос 3 км-ийн дотор байрлах өвөлжөөтэй **12 өрх**ийн бэлчээрийг шугам хоолойн суваг шуудуугаар хуваах, нутаг сэлгэх нүүдэл, мал маллагаанд барилгын ажил нөлөөлсөн.<br>Г2. 1-р үе шатны Усны шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамын хоёр талд 1-2 км, 2-р үе шатны усны шугам хоолойгоос 3-7 км-ийн дотор байрлах өвөлжөөтэй **11 өрх**ийн нутаг сэлгэх нүүдэл, мал маллагаанд нь барилгын ажил нөлөөлсөн. |
| Д. Нүүлгэн шилжүүлэх, нөлөөлөлд өртөж хоёрдогч, хавсарсан нөлөөлөлд орж, нийтийн бэлчээр нутгаа алдсаны улмаас малын бэлчээр нь бүхэлдээ багассан (шууд бус нөлөөлөлд орсон) | Хамаарахгүй | Д1. Энэ нь нөлөөлөлд өртсөн малчид Ханбогд сумын "бусад" бэлчээрийн талбайд "шахаж орж ирсэнээс" үүдэн гарсан хоёрдогч, хавсарсан нөлөөтэй холбоотой ангилал юм. ОТ-н Уурхайн лицензит талбай, дагалдах дэд бүтцийн талбайгаас хамааран шууд алдсан бэлчээрийн хэмжээ нь 8,625-10,500 га (Ханбогд сумын нийт бэлчээрийн 1,5%)-ийн хооронд байна. Бэлчээрийн хил хязгаар, хоёрдогч, хавсарсан нөлөөнд өртсөн малчдыг шууд тодорхойлох боломжгүй тул энэхүү нөлөөлөлд олон тооны малчид өртөж байгаа. Иймээс, малчдын амьжиргаанд чиглэсэн урт хугацааны хамтын стратеги, төлөвлөгөөгөөр шийдвэрлэх нь зүйтэй юм. |

| | | |
|---|---|---|
| Е.Бусад* (Бүх нөлөөллийн бүс) | Хамаарахгүй | Е1. Цагаан хадны ачааны автомашины Зогсоолын хуримтлагдсан нөлөөллийн улмаас нөлөөллийн бүс дэр өвөлжөөгөө ашиглахаа больсон **4 өрх** (эзэнгүй өвөлжөө эзэмшигчид)**.**<br>Е2. Сумын төвд оршин суудаг боловч дээрх нөлөөллийн бүсийн нэгэнд өвөлжөөтэй, барилгын ажлын үе шатанд нь хашаа хороо руугаа очиход тоосжилт, дуу чимээ нөлөөлөлд өртөж болзошгүй **21 өрх** (эзэнгүй өвөлжөө эзэмшигчид). |
| **Нийт** | **10 өрх** | **89 өрх** |

# 5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг барилга бүтээн байгуулалтын үе шатны НШҮАТ-нд дэлгэрэнгүй тусгасан. 2011 оны Эдийн засгийн нөлөөллийн үр нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээг доор тусгав.

Зам, нисэх онгоцны буудлын барилгын нөлөөлөл, түүнийг хянан удирдах талаар 2005-2011 онд хийсэн ерөнхий болон сэдэвчилсэн зөвлөлдөх уулзалт, багийн иргэдийн нийтийн хурал дээр малчдын хөндсөн, сэтгэл зовоосон эн тэргүүний томоохон асуудал нь ус, бэлчээр хүрэлцээгүй болсон тухай байсан. ОТ-ГС замын дагуух нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй хийсэн зорилтот уулзалтаас харахад удаах сэтгэл зовоосон асуудлуудад замын тоосжилт, малаа услах худгийн хүртээмж, замын аюулгүй байдал, мал болон зэрлэг ан амьтдын хоорондох харилцаа, барилгын ажилтай холбоотой авто хөдөлгөөн зэрэг хамрагдаж байв. Цахилгаан дамжуулах шугам, Гүний хоолойн усны эх үүсвэрийн шугам хоолойн зурвас газарт нутаглах малчин өрхүүдийн хөндсөн асуудлуудад мөн барилгын ажлын тоос, бэлчээрийн хүртээмж, усан хангамжид учирч болзошгүй нөлөөлөл зэрэг багтаж байв. Малчидтай хийсэн зөвлөгөөний үеэр хөндсөн гол асуудлууд, түүнийг бууруулах ОТ-н арга хэмжээг Хүснэгт 8-д тоймлон харуулав.

**Хүснэгт 8: Эдийн засгийн нөлөөлөлд өртсөн малчдын хөндсөн асуудал, түүнийг бууруулах ОТ-н арга хэмжээний тойм**

| Асуудал | Товч тодорхойлолт | ОТ-н авах арга хэмжээ, хариу |
|---|---|---|
| Ажлын байр ба бизнесийн хөгжил | Малчид зөвхөн уурхайн цогцолборт бус, хөдөлмөр эрхлэх өөр бусад боломж боломж бололцоотой байх хүсэлтэй байна | Орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ уламжлалт мал аж ахуйгаа давхар эрхлэх боломж бүхий, тухайн хүний ур чадварт тохирсон байнгын ажлын байр санал болгож байна.<br>2012 оны тавдугаар сарын байдлаар ОТ-ГС зам дагуу болон нисэх онгоцны буудал орчим нутаглаж буй 69 малчдыг ОТ-д “Замын арчилгааны ажилтан (ЗАА)”-аар ажилд авсан. Энэ нь ОТ-н хагас цагийн, |

| Асуудал | Товч тодорхойлолт | ОТ-н авах арга хэмжээ, хариу |
|---|---|---|
| | | хугацаатай гэрээтэй орон тоо юм. ОТ нь 2013 оноос нөхөн олговрын гэрээтэй өрхийн ЗАА-уудад ОТ-д тогтвортой урт хугацааны орон тоо дээр ажиллуулах, тэтгэврийн насны ахмадуудыг тэтгэвэртээ гарах зэрэг боломжийг бүрдүүлсэн юм. Үүний дүнд 7 ЗАА-ыг тогтвортой ажлын байр, 6 ажилтан үндсэн цалингаа нэг удаагийн тэтгэмж хэлбэрээр авсан зэрэг болно. |
| Малчдын амьжиргааг дээшлүүлэх | Малчид бэлчээрийн доройтол, амьдрал ахуй, орлогын эх үүсвэрээ урт хугацаанд хадгалж үлдэх талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн, олон хүмүүс шууд ажлын байрнаас илүүтэйгээр бизнесийн боломж бололцоо хүсч буйгаа илэрхийлсэн юм. | Малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хүрээнд, шууд нөлөөлөлд өртөж буй малчин өрхүүдэд зориулж жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийн хөгжүүлэх тусгайлсан төлөвлөгөө боловсруулсан.<br><br>Мал аж ахуйн бус аргаар амьжиргаагаа дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор малчдад зориулж бизнес эрхлэх суурь мэдлэг болон технологийн сургалтуудыг зохион байгуулсан. |
| Бэлчээрээ алдах, бэлчээр хуваагдах, мал маллагааны хэв маяг алдагдах | Малчид зуны бэлчээрээ ашиглах болоолцоо хязгаарлагдмал болсоныг нөхөн олговор олгох замаар нөлөөллийг бууруулах арга хэмжээ авахыг, тэр дундаа хүүхдийн боловсрол, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийн талаар дэмжлэг туслалцаа авах хүсэлт тавьсаар байна. | Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ малчдын мал аж ахуйг эрхлэх болон бусад дэмжлэгт анхаарч байна.<br><br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор суманд 14 малчдын хоршоо, орон нутгийн бэлчээр ашиглагчдын бүлгийг байгуулсан.<br><br>Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь бүлэг тус бүрт дэмжлэг үзүүлсэн. ОТ-ын зүгээс бүлэг тус бүрт “эргэлтийн сан”-гийн анхны хөрөнгө оруулалтыг хийсэн.<br><br>ОТ нь усны шугам хоолойн трассын дагуу ан амьтны гарцын байршлыг малчдын оролцоотой тогтоож, найман гарц байгуулж, тухайн газруудыг цэвэрлэж, “зогс” тэмдэглэгээг байрлуулсан. Уг трассын дагуу барилгын ажил үргэлжилсэн тул шугам хоолойн бусад хэсгүүдэд нэмж ан амьтны найман гарц байгуулсан.<br><br>Малчид ОТ-ГС зам дагуу 10 байршилд ан амьтны |

| **Асуудал** | **Товч тодорхойлолт** | **ОТ-н авах арга хэмжээ, хариу** |
|---|---|---|
| | | гарц байгуулах хүсэлт тавьсанаар ОТ замын барилгын үеэр эдгээрийг барьсан.<br><br>ОТ-н гэрээт компанийн аргачлалын дагуу малчид бэлчээрийн хяналт шинжилгээнд оролцож эхэлсэн. |
| Агаарын чанар | Нисэх онгоцны буудал, автозам, цахилгаан дамжуулах шугам, ГХ-н усны эх үүсвэр, шугам хоолойн барилгын ажил, ашиглалтаас гарах тоосжилт нэмэгдэж буйд санаа зовниж байна. | Малчид ойрхон амьдардаг нутагт газар шорооны ажил хийж буй талбайд барилгын ажлын үеэр усны машинаар өдөр бүр ус шүршиж байна. Барилгын ажил оргил цэгтээ хүрэхийн хэрээр Оюу толгой компани усны машин нэмж, ус шүрших газруудын тоо, ус шүрших давтамжийг нь нэмэгдүүлсэн.Барилгын ажилтай холбоотой (жишээ нь барилгын үйл ажиллагаа, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн гэх мэт) тоосжилтыг хянах үүрэг амлалтаа биелүүлэхээр ОТ Агаарын чанарын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. |
| Төслийн мэдээллийн ил тод байдал | Орон нутгийн иргэд төслийн талаар шинэ мэдээ, мэдээлэл авч, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахад бүрэн дүүрэн оролцох хүсэлтэй. | ОТ төслийн шинэ мэдээ, мэдээлэл, орон нутагт үзүүлэх дэмжлэг, түншлэлийн талаарх мэдээллийг ОТ-н цахим хуудас, хэвлэл, ДЗ, УБ дах мэдээллийн төв, ОТ-н оффисоос болон бусад орон нутгийн оффисоос авч болно. ОТ 2015 онд ХБ суманд Иргэдийн хөгжлийн төв байгуулсан.<br><br>Орон нутаг ба төслийн хоорондох харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Орон нутгийн зөвлөх бүлгүүдийг 2010 онд сум бүрт байгуулсан хэдий ч санасан хэмжээнд ажиллаагүй. Хамтын ажиллагааны гэрээний дагуу төрөл бүрийн чиглэлээр Ажлын хэсгийг илүү оновчтой зохион байгуулалтад оруулж, өргөн хүрээтэй дэмжих боломжтой болгосон.<br><br>Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ болон бусад туслалцаа үзүүлэх үүднээс 2011 оны эхээр Нөхөн олговорын ажлын хэсгийг байгуулсан. |

| Асуудал | Товч тодорхойлолт | ОТ-н авах арга хэмжээ, хариу |
|---|---|---|
| | | ОТ-ийн Орон нутгийн харилцааны ажилтнууд (ОНХА) нөлөөлөлд шууд өртсөн өрхүүдийг хуваарилан хариуцаж байгаа (ОНХА тус бүрт 12 өрх ногдохоор) бөгөөд ОНХА очиж уулзах, өөр бусад уулзалт хийснээр эдгээр айлуудтай тогтмол холбоо харилцаатай байна.<br><br>ОТ болон орон нутгийн мэдээ багтаасан Орон нутгийн сонинг ОТ эрхлэн гаргадаг бөгөөд одоогоор 110 мянга орчим хэвлэлтийгаймгийн хэмжээн дэх бүх оролцогч талууддаа тараасан. |

ОТ-н барилга бүтээн байгуулалтын үе шатны НШҮАТ нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 5 (2006)-ын дагуу тэргүүн туршлага дээр үндэслэн хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нөлөөллөөс аль зайлсхийх, хамгийн бага түвшинд тогтоох,
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Ямар нэгэн тогтоогдон нөлөөлөл үлдсэн бол нөхөн олговрыг олгох зэрэг орно.

Барилга бүтээн байгуулалтын үе шатны НШҮАТ-нд дээрх арга барил, үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан. 2011 оны Эдийн засгийн нөлөөллийн хувьд, ерөнхий нөхцөл болон нөхөн олговор, түүнд хамрагдах өрхийн матрицыг Ханбогд сумын Засаг даргын байгуулсан Нөхөн олговрын ажлын хэсэг баталсан билээ. Хувь хүний нууцлалыг хангасан, тухайн өрхийн шаардлагад нийцүүлэн тохиролцсон Нөхөн олговрын гэрээг нөхөн олговор авах эрхийн матрицын дагуу нөлөөлөлд өртсөн бүх 89 өрхтэй байгуулсан. Нөхөн олговор авах эрхийн матрицыг Хавсралт IV-д тоймлон харуулсан. Одоогоор хэрэгжүүлж буй хяналт шинжилгээ, үнэлгээ, гэрээнд заасан нөхөн олговор зэргийг бүртгэхэд үүнийг ашигладаг бөгөөд ирээдүйд гарах аливаа нөлөөлөл, нөхөн олговорын үйл ажиллагаанд ч мөн ашиглана.

# 6 ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2004 оны Нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны Эдийн засгийн нөлөөллийг дараах хэсэгт тус тусад нь авч үзсэн болно. 2004 оны нүүлгэн шилжүүлэлт 10 жил үргэлжилж, 2011 оны нөлөөллийн ажил нэлээд ахицтай явж байгаа тул ОТ-н НШҮАТ нь эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрх, газар авах үйл ажиллагааны хоёрдогч нөлөө, Ханбогд сумын малчдын ерөнхий нөхцөл байдал зэрэгт түлхүү анхаарсан.

## Нүүлгэн шилжүүлсэн өрхүүд (2004)

ОТ Уурхайн лицензит талбайгаас 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдтэй 2010 оны 10-р сард хэлэлцүүлэг хийж, тэдний дунд явцын талаарх судалгаа явуулсан.

Нийт 15[12] гэр бүл судалгаанд хамрагдсан. Судалгаагаар 2004 оны үеийн (нүүлгэн шилжүүлэлтээс өмнө) эд хөрөнгө, орлого болоод 2010 онд тухайн өрхийн нөхцөл байдлыг авч үзсэн болно. Түүнчлэн, шинэ амьдрах орчиндоо хүмүүс хэр сэтгэл хангалуун байгааг нь тодорхойлох хэд хэдэн асуулт тавьсан.

Өрхүүдийн өгсөн хариултаас харахад, нүүлгэн шилжүүлэлтийн дараа амьдрах орчин, амьдралын чанар нь янз бүрээр сайжирсан байна. Үндсэн эерэг үр дүнг дурдвал:

- Бүх айл өрхийн ахуй амьдралын түвшин, орлого, малын чанар, бэлчээрийн хүртээмж нь наад зах нь сайжирсан, эсхүл нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх байдлаас дээрдсэн гэж мэдээлсэн.
- Арван гурван гэр бүл 2004 оноос хойш малын тоо толгойгоо өсгөсний дотор зарим нь хоёр, гурав дахин нэмэгдүүлсэн байна. Хоёр өрх сумын төв рүү нүүж, эдийн засгийн бусад үйл ажиллагаа эрхэлсэн тул малын тоо нь буурсан гэжээ.
- Долоон өрх Ханбогд сумын төвд голчлон суурьшихаар шийдсэн хэдий ч бүгд хөдөө орон нутаг дахь гэр, мал аж ахуйгаа хадгалж үлдэн хамаатан садан болон бусад малчдаар малаа хариулуулж байна.
- Удаан эдэлгээт өргөн хэрэглээний бараа аажмаар хуримтлагдаж эхэлсэн. Гар утасны тоо 2004 онд 2 байсанаас 2010 онд 16 болж өссөн. Бусад худалдан авсан хэрэгслүүдэд зурагт, тавган антенн багтах бөгөөд 2004 онд ердөө 5 айл тавган антенн, 8 айл зурагттай байсан бол 2010 онд 15 айлаас 13 нь зурагт, тавган антенннтай болжээ. 2004 оноос хойш 15 өрхийн хувьд машин хоёроор, мотоцикл нэгээр нэмэгдсэн байна.

Үүний эсрэгээр, гурван айл худгийн засвар, үйлчилгээний асуудлаас үүдэн усны хүртээмж буурсан гэж хариулжээ.

Ахуй амьдралын түвшингээ тухайн өрх өөрөө тодорхойлсноор зургаан өрх нүүлгэн шилжүүлэлтээс өмнөх үеийнхээс ахуй амьдралын түвшин нь сайжирсан гэж дүгнэсэн бол үлдсэн ес нь хэвэндээ байгаа гэж хариулжээ. Нүүлгэн шилжүүлэлтээс хойш ахуй амьдрал нь доройтсон гэж мэдээлсэн айл өрх байхгүй.

Энэ чиглэлийн судалгааг 2011 онд зохион байгуулсан бөгөөд энэ удаад 4 өрхийг ажилгүйдэл, нас, бусад хөгжлийн бэрхшээлээс үүдэн эмзэг бүлэгт хамрагдаж, нэмэлт дэмжлэг, туслалцаа хэрэгтэй гэж тодорхойлсон байна. Эдгээр өрх бүртэй үргэлжлүүлэн зөвлөлдөж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрны тогтвортой байдлыг сайжруулах өөр бусад арга замыг эрэлхийлэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хэрэгжилтийн аудитыг (Хавсралт VII) 2014 онд зохион байгуулж, 2004 оныхтой харьцуулахад нүүлгэн шилжүүлсэн өрхүүдийн амьжиргаа, ахуй амьдралын түвшин буцаж сэргэсэн, ихэнх тохиолдолд сайжирсан, мөн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийг зөв зохистой хэрэгжүүлж, зорилтуудаа ерөнхийд нь биелүүлсэн гэсэн дүгнэлтэд хүрсэн. Ханбогд сумын хэмжээнд хийж буй бэлчээр, ус, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх уурхайн нөлөөллийн хяналт шинжилгээний хүрээнд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдтэй тогтмол уулзаж, мэдээлэл солилцох ажлаа үргэлжлүүлэх саналыг энэхүү аудитаар ОТ-д дэвшүүлсэн.

[12] Нас барсаны улмаас нэг гэр бүл хасагдаж, тухайн өрх нэг гишүүнтэй айл болсон тул 2010 оны судалгаанд ердөө 15 айл хамрагдсан.

Аудитаар дараах үндсэн дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлтээс өмнө, өрхийн нэг гишүүнд ногдох малын тоонд тулгуурлан тооцоход арван өрхийн тав нь ядуу болон нэн ядуу байсан.
- Олон хүүхэдтэй өрхийн боловсролд зарцуулах мөнгө нь бэлэн мөнгөний томоохон зардал болдог тул, уг салбарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх нь эн тэргүүний асуудал байсан.
- Өрх тусгаарлаж буй гэр бүл, орон нутагтаа, өөр бусад газарт хөдөлмөр эрхлэх боломж нээгдэж, өрхийн шинж байдал хурдацтайгаар өөрчлөгдөж байгаагаас гэр бүлийн бүтэц, орлого “задарч, тархай бутархай болсноос”, 2004, 2014 оны ерөнхий нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэхэд бэрхшээлтэй болсон.
- Нас баралт, гэмтэл бэртэл, гэр бүл салалт, цалинтай ажил зэрэг айл өрх бүрийн нөхцөл байдал нь нүүлгэн шилжүүлэлтийн дараах арван жилийн хугацаанд өрхүүдэд томоохон өөрчлөлт гарч байгааг илтгэж байна.
- Нээлттэй хэлэлцүүлгээр зарим өрхийн тэргүүн нар нүүлгэн шилжүүлэлт хийсэн, түүний дараагаар ОТ-той ажилласан зарим талуудад сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлж байсан. Мал амьтан шинэ байршилд дасан зохицохгүй байгаа талаар ихэнхи оролцогчид тэмдэглэсэн.
- ОТ-н бүтээн байгуулалтын урьдчилан таамагласан хэмжээ, түүнээс амьдрал ахуйд нь үүсч болох саад бэрхшээлийн талаар хангалттай мэдээлэл өгөөгүй гэж олон өрх мэдээлсэн.
- Зарим өрх 2004-2005 онуудад орон нутгийн удирдлагаас тэднийг “загнаж” нүүлгэсэн хэмээж, нөхөн олговрын багц, шинэ өвөлжөөний газар сонгоход оролцсон хэдий ч энэ нь тухайн үед тэдний хувьд цоо шинэ үйл явц байсан тул үр шимийг нь бүрэн хүртэж чадаагүй гэжээ.
- Дэмжлэг туслалцаа, нүүлгэн шилжүүлэлтийн бусад нөхцөлд хүсэлт гаргах талаар буруу ойлголттой байсны улмаас зарим айл нүүснээр авах ёстой байсан туслалцаагаа бүрэн дүүрэн авч чадаагүй.
- Арван өрхийн ес нь ОТ-оос олгосон барилга, хашаа хороонд сэтгэл ханамжтай байсан. Гэвч зарим нь эдгээрийг буулгаад, өөр зүйл барьсан.
- Орлуулж барьсан гар худгууд ажиллагаатай, ашигласан хэвээр байгаа. Малчдын хүсэлтээр барьсан хэд хэдэн гүний худгуудын шахуурга нь нэг бол эвдэрч, нэг бол хулгайд алдагдсан тул ашиглагдаагүй байна.
- 2004-2005 онд өрхүүдэд хэрэгжүүлсэн малжуулах төсөл нь ерөнхийдөө сайн үр дүнтэй байж, малын, ялангуяа, ямааны тоо толгой, чанар хэмжигдэхүйц өсч, сайжирсан.
- Малын хувьд нэмэгдсэн хандлага ажиглагдахын сацуу, малчид малаа төрөлжүүлсэний үр дүнд цаашид өрхийн амьжиргаа сайжирч болохыг ойлгож эхэлсэн. Энэ тал дээрх ОТ-н хичээл зүтгэлийг үнэлж, ихээхэн сайшаадаг.
- Сургалтын дэмжлэгт хамрагдахад тавигдах шалгуур (дүнгийн босго онооны талаар болон гадаадад боловсрол эзэмших боломжийг хязгаарласан зэрэг)-ын

талаар зарим малчид эргэлзээж байгаа хэдий ч дунд сургуульд суралцах дэмжлэг, дээд боловсролын тэтгэлгийг маш сайнаар хүлээж авч, зөв зохистой хэрэгжүүлсэн.

- Ажлын байранд тавигдах  ерөнхий  шаардлага, хэм журмын талаар ойлголт бага, улмаар түүнийг зөрчсөнөөр (ихэвчлэн согтууруулах ундаатай холбоотой) хөдөлмөр эрхлэх олон боломжийг алдсан. Ажилд орохын өмнөх сургалтыг өргөжүүлсэн бол 2004-2005 онуудад ажилд орсон  хүмүүсийн хувьд арилгаж болох байсан.
- Нөхөн олговор авах матрицын дагуу нөхөн олговорыг олгож дууссан. Харин зарим суралцагсад сургуулиа төгсөөгүй байгаа тул боловсролын дэмжлэг үргэлжилсээр байгаа.
- Ерөнхийдөө 2004 оны нүүлгэн шилжүүлэх хөтөлбөр зорилгодоо хүрсэн. Арван өрхийн тав нь 2004 онтой харьцуулахад ахуй амьдралаа,  Ханбогд дахь одоогийн дундаж байдлаас ахуй амьдралаа сайжруулсан бол, дөрөв нь ахуй амьдралаа бүрэн сэргээж, нэг нь хэсэгчлэн сэргээснээр, эмзэг бүлэгт хамрагдсан.

Хувь хүний хувьд болон бүлэг малчдын  өмнө тулгарч буй бэрхшээл, өнгөрсөн арван жилийн сургамжийг нэгд нэгэнгүй бататгахад 2014 оны аудитын шалгалт үр дүнтэй байсан. Үгээр сүүлийн 5-6 жилд НШҮАТ-н дахь ОТ-ийн зүгээс дэмжлэгээр хэрэгжиж буй олон ажил үр дүнтэй байсныг, арван жилийн өмнө эхлүүлсэн бол илүү үр дүнтэй байж болох байсаныг батлан харуулсан юм. Удахгүй 2004 оны нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрийг албан ёсоор “хаах” ажил эхлэнэ. Үлдсэн нэг эмзэг бүлгийн өрхийн асуудлыг шийдвэрлэх ажлыг ОТ-н Эмзэг бүлгийн өрхөд туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Хавсралт XI)-нд тусган хэрэгжүүлнэ. Тухайн гэр бүлийн нөхцөл байдлаас шалтгаалж олгох боломжгүй боловсролын үлдэгдэл эрхийг өөр нөхөн олговор, тэтгэмжийн хэлбэрээр тохиролцож олгох нь зүйтэй  юм.

### Нөхөн олговрын гэрээ байгуулсан өрхүүд (2011)

Нөхөн олговрын гэрээ байгуулсан буюу эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхүүд 2011 оноос хяналт-шинжилгээ, менежментийн хөтөлбөрт идэвхтэй хамрагдаж байгаа. Ихэнх нь гэрээний дагуу бүх эрхээ эдэлж, бусад нь тодорхой нэг хэсгийг нь үргэлжлүүлэн авч байгаа болон боловсролын дэмжлэгийн хувьд хүүхдүүдээ дунд сургуулийн насанд хүрэх, эсхүл дээд боловсролын сургуульд орохыг хүлээж байгаа малчид байна.  Өрх тус бүрээр тохирсон гэрээнд заасан нөхөн олговорын эрхээс гадна, хавсарсан  нөлөөллийн нөхөн олговор, нийтлэгдэмжлэгийн хүрээнд ОТ-оос Ханбогд сумын нийт  малчдад зориулсан МАА-г дэмжих хөтөлбөрт эдгээр  өрхүүд хамрагдах эрхтэй юм. Эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрыг 2015 оны байдлаар олгосон явцыг Хүснэгт 9-д тоймлон харуулж, тодорхой нөхөн олговор, нөхөн олговорт хамрагдах шалгуурыг энэ хэсэгт мөн тусгав. Малчин өрхөд олгосон  нийтлэг тэтгэмж, хавсарсан нөлөөллийн нөхөн олговрын хөтөлбөрийн талаар дараах  Хүснэгтэд тусгасан болно.

**Хүснэгт 9:  Эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрыг олгосон байдал, 2011**

| Нөхөн олговрын төрөл | Нөхөн олговор авсан хүний тоо | Гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|
| Нэг өрхөд нэг ажлын байр | 89 | 100 | Шаардлага хангасан өрхүүдээс нэр дэвшсэн хүнд нэг ажлын байр олгосон. Одоогоор ОТ-д 80 хүнийг ЗАА-наар ажиллуулж байна. |
| Сургуулийн насны хүүхдүүдэд үзүүлэх сурагчийн дэмжлэг | 50 | 100 | Гэрээнд сургуулийн насны хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх тодорхой хэмжээний мөнгөн дүнг тусгасан. Зарим өрхүүд энэ дэмжлэгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр авсан бол зарим нь жил бүр тодорхой хэмжээний мөнгөн дүн хүлээн авч байна. 2015 онд тохиролцсон мөнгөн дүнг бүгдийг төлж дууссан. |
| Бэлчээрийн тогтвортой менежмент | 89 | 100 | Гэрээнд бэлчээрийн менежментийн тусламж болгож 35,000 төгрөгийг тусгасан бөгөөд үүний төлбөрийг бүгдийг барагдуулсан болно. |
| Дээд боловсролын тэтгэлэг (оюутны тэтгэлэг) | 26 | 100 | Шаардлага хангасан оюутнууд тэтгэлэг авсан. |
| Эдийн засаг, бизнесийн дэмжлэг (шууд, шууд бус нөлөөлөлд өртсөн малчдад) | 89 | Байхгүй * | Энэхүү хөтөлбөрийг нөхөн олговрын гэрээнээс үл хамааран төлөвлөсөн. Энэ нь ерөнхийдөө нөлөөлөлд шууд өртсөн өрхийг бусад амьжиргаа дээшлүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаанд, ОТ-оос санаачилсан орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, оролцогч талуудтай харилцах болон бусад үйл ажиллагаанд хамруулахад чиглэсэн болно. |
| Богино хугацааны сургалт | 20 | 100 | Дууссан. |

* Орон нутагтай тодорхой зорилт тохиролцоогүй учир гүйцэтгэлийн хувь байхгүй.

Сургуулийн насны хүүхдүүдэд үзүүлэх сурагчийн дэмжлэг Бэлчээр, мал аж ахуйд барилгын ажлын улмаас үзүүлэх түр зуурын нөлөөлөл, бэлчээрээ тодорхой хэмжээгээр алдсаныг нөхөх материаллаг хэлбэрийг сургуулийн хүүхдүүдэд зориулсан сурагчийн дэмжлэгийг малчин айл өрхүүд илүүд үзсэн. Ийнхүү туслахдаа, тохиролцсоны дагуу хичээлийн хэрэглэл, хэрэгсэл, дүрэмт хувцас худалдан авахад зориулан тогтсон мөнгөн тэтгэмж олгож ирсэн. Шалгуурыг хангасан өрх тус бүрээс дунд сургуулийн сурагчид 5 жилийн турш энэ дэмжлэгийг олгож байна. Тухайн үед болон ирээдүйд сургуулийн насны хүүхэдгүй байх өрхүүд дүйцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглахаар тохиролцож авсан болно. Боловсролын дэмжлэгийн төлбөрийг шаардлага хангасан малчин өрхөд нэрлэсэн банкны дансаар шилжүүлсэн. 2014 оны эцэст нийт нөлөөлөлд өртсөн 89 өрхүүдийн 50 нь дунд боловсролын дэмжлэг авч, 16 айлын 27 сурагч уг хөтөлбөрийн дагуу сургуульдаа одоогоор суралцсаар байна.

*Дээд боловсролын тэтгэлэг*

Шаардлага хангасан нэг малчин айлаас нэг оюутанг Монгол улсын дээд сургуульд тэтгэлгээр сургаж байна. Тэтгэлэгийг хэмжээг тухайн их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээтэй уялдуулан тооцож, тухайн оюутан сурлагын амжилт үзүүлсэн бол сургалтын төлбөр, замын зардал, хоолны зардлыг суралцах нийт хугацаанд олгоно. “Оюуны өргөө” орон нутгийн ТББ нь энэхүү тэтгэлгийн хөтөлбөрийг хариуцдаг. 2014 оны эцсийн байдлаар, нөхөн олговор авсан өрхүүдээс долоон оюутан дээд боловсролын тэтгэлгийн хөтөлбөрт хамрагдаад байна.

*Богино хугацааны сургалт*

Мэргэжил олгох сургалтыг амьжиргаагаа дээшлүүлэхэд туслах арга зам хэмээн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүд тодорхойлсон. Үүний дагуу Монгол улсад 45 хоног хүртэлх хугацаатай нэг сургалтын төлбөрийг төлөх, түүний төлбөрийг мөнгөн дүнгээр тохирч, шаардлага хангасан өрхүүдэд богино хугацааны, мэргэжил олгох сургалтыг санал болгосон. Жишээ нь, 2014 онд таван малчид жолооны болон худалдааны богино хугацааны сургалтанд хамрагдаж, зохих гэрчилгээ, үнэмлэлхээ авсан болно.

*Ажлын байр*

Нөлөөлөлд өртсөн малчин өрхийн шаардлага хангасан гишүүдэд ОТ-д ажиллах боломжийг олгосон билээ. Нөлөөллийн гэрээтэй өрхийн нэг гишүүнд түр ажлын байрыг санал болгосон.

Хэлэлцүүлгийн үеэр нөлөөлөлд өртсөн малчдын ихэнх нь заавал уул уурхайн холбогдолтой ажил буюу Оюу толгойн уурхайн цогцолборт гэж заалгүйгээр цалинтай хөдөлмөр эрхлэхийг сонирхож буйгаа илэрхийлсэн. Улмаар, малчид Оюу толгойн нисэх буудлын эргэн тойронд, уурхайн цогцолбороос Хятад улсын хил хүртэлх, Ханбогд сумын төв хүртэлх зам дагуу байгаль орчны хяналт-шинжилгээ хийх, хог хаягдал цэвэрлэх, уурхайн цогцолборын гадна ажиллах боломж байгааг ОТ-н зүгээс тодорхойлсон. Энэ ажил нь Ханбогд сумын ард иргэдийн хувьд үр өгөөжтэй бөгөөд Өмнөговь аймгийн бусад замтай харьцуулахад зам дагуу хог хаягдал байдаггүй. “Зам арчилгааны ажилчид” гэх ажлын байр нь мэргэжлийн ажил биш юм. Энэ нь малчдын чадварт тохирсон ажлын байр бөгөөд хэрэв өөрөө хүсвэл ердийн сургалтанд хамрагдаж, өөр ажлын байранд шилжих боломжтой.

Энэхүү ажилд бүрэн биш хагас цагаар ажилладаг нь малчин бусад ажил үүргээ алдагдуулалгүй байх боломжтой юм. ОТ-н Орон нутгийн харилцааны ажилтан долоо хоног

тутам ажлын гүйцэтгэлийн шалгаж, бүртгэл тооцоог хөтөлнө. Цагийн хөлс нь уурхайд ажиллаж буй бусад мэргэжлийн бус ажилчдынхтай ижилхэн тул, газар нутаг, малдаа ойр байхын хажуугаар орлого олох боломжтой гэж малчид сэтгэл хангалуун байдаг. 2011 оноос эдийн засгийн нөлөөлөлд өртсөн 69 хүн ийм байдлаар хөдөлмөр эрхэлж байна.

2014 оны эцсээр 51 хүн ЗАА-ны үүргийг гүйцэтгэж байснаас зургаа нь уурхайн цогцолборт тогтвортой ажлын байранд шилжиж, 29 нь байгаль орчны болон бусад хяналт-шинжилгээний туслах ажилтнаар ажиллаж, тав нь тэтгэвэртээ гарсан байна. Ирэх жилүүдэд ОТ шилжин ажиллах хүсэлт гаргасан ажилчдад ОТ ойрын хэдэн жилд ерөнхий сургалт, ажлын байр санал болгож, үлдсэн өндөр настай хүмүүсийг “тэтгэвэрт” гаргана.

*Амьжиргааг дэмжих нэмэлт арга хэмжээ*

Өрх тус бүрийн нөхөн олговроос гадна эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүдийг 7-р хэсэгт тодорхойлсон нийтлэг тэтгэмж, хавсарсан нөлөөллийн хөтөлбөрт хамрагдахыг санал болгосон. 2014 оны эцсийн байдлаар үүнд дараах арга хэмжээ хамаарч байсан. Тухайлбал:

- Бэлчээрийн менежментийн хөтөлбөрийн дагуу байгуулагдсан хоёр хоршоонд 56 хүн бүртгүүлсэн,
- Зургаан малчин Соёлын дурсгалт газрын хяналт-шинжилгээнд оролцсон,
- 43 малчин Оролцоонд суурилсан байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт оролцсон,
- Гурван малчин Орон нутгийн бизнес, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан зэрэг болно.

*2014 оны эцсийн байдлаар*

2014 оны ОТ-н Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн судалгаагаар 81 өрх (87%) нөхөн олговроо бүрэн авсан, зургаа (7%) нь нөхөн олговрын багцаа хэсэгчлэн авч байгаа, үлдсэн хувь нь

**Хүснэгт 10: Нөлөөлөлд өртсөн өрхийн үндсэн тоон мэдээлэл, 2011-2014**

| Үзүүлэлт | 2011 оны судалгаа n=101 Хуримтлагдсан нийт | 2014 оны судалгаа n= 93 Хуримтлагдсан нийт | Ердийн өсөлт/бууралт, % “0” нь алдааны хязгаар дотор байгааг илтгэнэ |
|---|---|---|---|
| Судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн тоо | 393 | 353 | 0 |
| 0-17 насны хүүхдүүд | 121 | 116 | 0 |
| 55 ба түүнээс дээш насны ахмад настнууд | 26 | 25 | 0 |
| Ажилгүй хүмүүс | 70 | 29 | -55% |
| Их дээд сургуулийн оюутнууд, МСҮТ орно | 25 | 21 | 0 |
| Сургуульд сурч буй хүүхдүүд | 73 | 88 | +30% |
| Цэцэрлэгт хүмүүжиж буй хүүхдүүд | 5 | 6 | 0 |
| Гэртээ хүмүүжиж буй хүүхдүүд | 25 | 18 | 0 |
| Малын нийт тоо толгой | 19,519 | 21,640 | +20% |
| Тэмээ | 4,061 | 4,495 | +20% |
| Адуу | 917 | 963 | +14% |
| Үхэр | 229 | 275 | +28% |
| Хонь | 5,145 | 6,029 | +27% |
| Ямаа | 9,161 | 9,878 | +17% |
| Ашиглаж буй худаг | 83 | 104 | +19% |
| Жилийн нийт орлого | 410,982 мянган төгрөг | 821,964 мянган төгрөг | +100% |

нөхөн олговроо авсан, аваагүйгээ “мэдэхгүй” гэж хариулсан байна. Ихэнх өрхийн гишүүд хүлээн авсан нөхөн олговортоо сэтгэл хангалуун байснаа илэрхийлсэн бөгөөд амьжиргаанд нь эерэг нөлөө үзүүлсэн болохыг онцолсон. Гэхдээ хэд хэдэн малчид нөхөн олговрын багцад ерөнхийд нь сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлсэн байна.

Нөлөөлөлд өртсөн өрхийн ахуй амьдралын нөхцөлийн тоон үзүүлэлтээс харахад, судалгаанд хамрагдагсдын тоо жилээс жилд өөр өөр байгаагаас хуримтлагдсан нийт болон дундаж үзүүлэлтийн хандлагын дүн шинжилгээ ялгаатай үр дүнтэй байх, мөн судалгаанд амьжиргаа нь дээшлээгүй өрхүүдийг тодорхойлоогүйгээс үл хамаарч, (Хавсралт V ба VI) хэд хэдэн тоон үзүүлэлтэд хуримтлагдсан болон дундаж байдлаар сайжирсан үзүүлэлт гарсан байна. Хэдий тийм ч 2011 болон 2014 оны судалгааны үр

дүнгийн харьцуулалт нь зөвшөөрөгдөх алдааны хязгаар дотор байгаа бөгөөд ОТ-н Орон нутгийн харилцааны ажилтнууд дундажаас доогуур түвшин дэх өрхийг тодорхойлж, онцгой анхаарал хандуулахад уг тоон мэдээллийг ашигладаг болно.

Судалгаанаас авч, Хавсралт V ба VI-д тооцоолсон хуримтлагдсан тоон үзүүлэлтийг дараах Хүснэгт 10-т тоймлон харуулав.

Хамгийн онцлох тоон үзүүлэлт нь нөлөөлөлд өртсөн өрхүүд дэх ажилгүйчүүдийн тоо 2011 онд 70 байснаас 2014 онд 29 хүртэл буурсан үзүүлэлт байна. Үүнийг *өрхийн орлогод цалин/тэтгэврийн эзлэх хувь* гэсэн баганаас (Хавсралт VI) харж болох бөгөөд мөн 2011 онд мал аж ахуйн бус орлоготой өрхүүд ердөө гуравны нэгийг бүрдүүлж байсантай харьцуулахад нөлөөлөлд өртсөн бараг бүх өрх 2014 онд энэхүү эх үүсвэрээс орлогынхоо 40-100%-ийг бүрдүүлж байгааг харж болно. Нийт малын тоо толгой, жилийн нийт орлого ижил хандлагаар өссөн нь орлого ашиг сайн байсныг илтгэж байна.

# 7 ХАНБОГД СУМАНД ҮЗҮҮЛЭХ ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ

Үйл ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор ОТ компани малчдад үзүүлэх тусламж дэмжлэгээ эргэн авч үзсэн байна. 2004 онд тодорхойлсон 10 өрхөд үзүүлэх тусламж дэмжлэг амжилттай хэрэгжиж шат дараатайгаар хаагдсан, мөн 2011 онд эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрын гэрээ байгуулсан 89 өрхөд үзүүлэх тусламж дэмжлэг ирэх жилүүдэд шат дараатайгарр хаагдах тул ОТ компани одоогоор Ханбогд сумын малчин ард иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх нийтлэг хөтөлбөрүүддээ голлон анхаарч ажиллах болно.

Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан бөгөөд одоогоор эмзэг өрхүүдийг зорилтот бүлгийн хэлбэрээр тусгайлан тусалж дэмжинэ. ОТ компани нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчдад үзүүлэх тусламж дэмжлэгээ хавсарсан зэргийн нөлөөлөлд өртсөн нь бусад (шууд бус нөлөөлөлд өртсөн) малчдад үзүүлэх нийтлэг тусламж дэмжлэгтэй хамтгатгаж байгаа ба тэр дундаа тээврийн хэрэгслийн тоо ихэссэн, тоосжилт нэмэгдсэн, малын тоо толгой өссөнөөс малын бэлчээрийн дүр зураг өөрчлөгдсөн зэргээс үүдэлтэй хавсарсан нөлөөлөлд анхаарлаа голлон хандуулах болно.

ОТ компани Ханбогд сумын малчдыг дэмжих нийтлэг хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, тухай бүр шинэчлэж ирсэн. Эдгээр хөтөлбөрууд нь ОТ компаниас Ханбогд сумын иргэдэд үзүүлж буй нөлөөллийг тэнцвэртэйгээр бууруулах зорилготой бөгөөд ОТ компанийн тусламж дэмжлэгийн үндсэн суурь болсоор байна. Энэ нь цаашлаад “нөхөн олговорт хамрагдсан”, “нөхөн олговорт хамрагдаагүй” хэмээх хуваагдлыг үгүй болгох зорилготой нийцэж байгаа юм. Нөгөө талаар малчдыг дэмжих хөтөлбөрүүд нь Ханбогд суманд үзүүлэх нийгмийн тусламж дэмжлэгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болж байна.

*Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөр, Малчин өрхийн амьжиргааг сайжруулах хөтөлбөр зэрэг нь* сумын хэмжээнд үзүүлэх хавсарсан нөлөөллийг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүд юм.

Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр (МӨАДХ)

Барилга угсралтын үе шатанд орон нутгийн иргэд тодорхой газраар чөлөөтэй зорчих явдал хязгаарласныг шийдвэрлэх, орон нутгийн нийт малчдын ахуй амьдралыгдээшлүүлэх зорилгоор *Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийг* (БТМХ) боловсруулсан. Нөхөн олговор авах эрх үүссэн буюу нөхөн олговор авсан өрхүүдийг оролцуулан сумын бүх малчид хөтөлбөрт оролцох боломжтой юм. Уг хөтөлбөрийн зорилтот бүлэг нь цаг улирлын нөлөөн дор амьдрах хөдөөний малчин өрхүүд байна. Уг хөтөлбөр нь бэлчээрийн тогтвортой менежмент гэхээсээ илүү малчдын амьжиргаанд чиглэсэн учраас хөтөлбөрийг “Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр (МӨАДХ)” хэмээн нэрлэсэн.

МӨАДХ-ийн хэрэгжилтийг малчид, сумын засаг захиргаа, биологийн олон янз байдал хариуцсан мэргэжилтнүүд хариуцах ба тухайн мэргэжилтнүүд зэрлэг ан амьтан, малын

харилцан шүтэлцээ , ашиг сонирхлыг тогтвортой тэнцвэржүүлэхийг анхаарч ажиллана. Энэ талаарх аливаа шинэ зааварчилгааг Хамтын ажиллагааны гэрээний дагуу Гурван талт зөвлөл, Харилцааны хороотой зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлно. Одоогийн байдлаар уг хөтөлбөр нь дараах үндсэн асуудлыг хамарна. Үүнд:

(1) *Бэлчээрийн хяналт шинжилгээ:* Компани нь өнөөгийн байдлаар бэлчээр, ургамлын хяналт шинжилгээг 70 цэгт явуулж байна (Ханбогд, Манлай, Баян-овоо сумд). Бэлчээрийн хяналт шинжилгээ нь оролцоонд тулгуурласан ба Нутаг түншлэлийн удирдамжийн дагуу боловсруулсан бөгөөд 2014 оны 8 дугаар сард хээрийн судалгааг эхлүүлсэн. Судалгааны багт малчид, ТББ, мэргэжлийн судлаачид багтсан. Судалгааны ажлын зорилго нь бэлчээрийн доройтол, улирлын чанартай нөхөн сэргээгдэх байдлын хэмжээ, үндсэн шалтгааныг тоон үзүүлэлтээр харуулах явдал байв. Одоогоор тодорхой үр дүн гараагүй.

(2) *Малчдын хоршоог хөгжүүлэх:* Монголын бэлчээрийн менежментийн холбоо (МБМХ) нь 2011 онд ОТ компанитай хийсэн гэрээнийхээ дагуу Ханбогд суманд Малчдын хоршоог байгуулах талаар зөвлөж эхэлсэн. МБМХ нь бэлчээрийн менежментийн хөтөлбөр, малчдын бизнесийг хөгжүүлэх зэрэг санаачлагуудыг хэрэгжүүлэх талаар арвин их туршлагатай, үндэсний байгууллага юм.

2013 оноос эхлэн Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвөөс (МХСМТ) Хоршоодын хөгжлийн талаар малчдад сургалт явуулж ирсэн. Өнөөдрийн байдлаар Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад нийт арван найман хоршоо байгуулагдаад байгаа ба тэдгээр нь нийт 893 гишүүдтэй, 71 сая төгрөгийн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. 2014 онд 19 хоршооны гишүүн малчид Монгол улсын хойд аймгуудад амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа хоршоод болон мал маллагааны тоног төхөөрөмж үйлдвэрлэгч үндэсний байгууллагуудаар зочилсон.

Малчдын хоршоод нь ОТ компанийн санхүүжилт, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвийн дэмжлэгтэйгээр өөрсдийн уламжлалт бэлчээрийн газарт тусгайлан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Эдгээр төлөвлөгөөнд бэлчээрийн менежментийг сайжруулах арга алхамуудыг тодорхойлохыг зорьсон бөгөөд тэдгээрийг орон нутгийн удирдлагаар батлуулах юм. Түүнчлэн хоршоод дараах үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Худаг гаргах, сэргээн засах,
- Бэлчээрийг нөхөн сэргээх, ургамалжуулах хөтөлбөрүүд,
- Мал эмнэлэг, вакцинжуулалт, угаалга ариутгалыг сайжруулах,
- Малын эрүүл мэндийн сургалт,
- Малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, амьжиргааны эх үүсвэрийг бүрдүүлэх,
- Малын нэмэлт тэжээл худалдан авч, хаврын улиралд малчдад хуваарилахад шаардлагатай эргэлтийн санг бий болгох зэрэг ажлууд хамаарна.

(3) *Малчдын худаг.* Ханбогд суманд ойролцоогоор 314 худаг байдаг бөгөөд тэдгээрийн

ихэнхи нь гар худаг юм. 2012-2014 онд Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдад ОТ компани жилд дунджаар 20-30 худгийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлсэн. Энэхүү ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлсэн бөгөөд худгийг эксковаторын тусламжтайгаар ухаж, дараа нь бетон доторлогоо суулгасан. Угсарсан хоолойг тойруулан хайрга чигжих, таглаа, туслах төхөөрөмжийг суурилуулахад малчид хамтран оролцсон. Гүйцэтгэгч компани түүнчлэн 5 малчныг худаг сэргээн засварлах ажилд дадлагажуулсан. Сэргээн засварласан худгуудын байршил нь тухайн газар нутгийг хамарсан бөгөөд Малчдын хоршоодын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдаатай байна. Худаг сэргээн засварлах ажлыг Харилцааны хороо, Гурван талт зөвлөлийн хяналттайгаар тууштай үргэлжлүүлэх зорилготой байна.

2013, 2014 онуудад Ханбогд суманд хур тунадас бага, алаг цоог орсон бөгөөд үүний улмаас усны сав газарт хэд хэдэн худаг ширгэсэн. Иймээс ОТ компани уурхайн талбайд ойрхон байрших, усны хомсдолд орсон малчдад түр хугацаанд ус түгээсэн. Түүнчлэн компанийн санаачлагаар Ханбумбат нисэх буудлын ойролцоо орших Эхэн Халив хэмээх газар, Уурхайн лицензийн талбайн гаднах хэд хэдэн байршилд 5 ширхэг усан сан байгуулж, шаардлагатай үед нь усаар дүүргэж байсан ба ингэснээр таван мянга гаруй мал сүрэг, шууд болон хавсарсан байдлаар нөлөөлөлд өртсөн нийт 11 айл өрхийг усаар хангасан. Эхэн халивт шинээр худаг ухсан учраас 2015 онд хур тунадас ихтэй жил болбол ус түгээх шаардлагагүй боловч хуурайшилтай жил болбол усны түвшин буурч, улмаар ус түгээх ажлыг дахин эхлүүлэх шаардлагатай болно.

(4) *Малын эрүүл мэнд:* 2014 онд ОТ компани Ханбогд, Баян-овоо, Манлай сумдад малын эрүүл мэндийн үзлэг хийж, халдварт өвчин тээж буй эсэхийг тогтоох зорилгоор “Бизнесийн амжилтын түлхүүр” байгууллагатай гэрээ байгуулсан. Нийт 90 өрхийн малд (нийт 38753 мал) түүврийн аргаар үзлэг хийхдээ 103 малаас 207 дээж авч лабораторийн нарийвчилсан шинжилгээнд явуулсан. Ханбогд сумын хувьд шууд нөлөөлөлд өртсөн нийт өрхүүдийн 40 хувь нь судалгаанд хамрагдсан. Судалгааны урьдчилсан үр дүнгээр бүтээн байгуулалтын дэд бүтцийн эргэн тойронд бэлчиж буй мал болон Баян-овоо, Манлай сумдад бэлчиж буй малын эрүүл мэнд онцын ялгаагүй байгааг тогтоосон. Доорх 7-р зурагт нөлөөллийн бүсээс түүвэрлэн үзлэг хийсэн малын эрүүл мэнд болон нөлөөллийн бус талбайгаас түүвэрлэн үзлэг хийсэн малын эрүүл мэндийн зөрүүг харуулав.

**Зураг 7*: Нөлөөллийн болон нөлөөллийн бус талбай дахь малын эрүүл мэнд***




Уг судалгааны  дүнгээр малын эрүүл мэнд хангалтгүй байгаа үндсэн шалтгаануудын нэг нь сумын хэмжээнд мал эмнэлгийн чадавхи сул байгаатай холбоотой гэж гарсан. Уг судалгаагаар (i) орон нутгийн мал эмнэлгийн чадавхийг нэмэгдүүлэх, (ii) бэлчээрийн менежмент, малын тэжээлийн менежментийг сайжруулах талаар малчдад ойлголт өгөх, (iii) орон нутгийн мал эмнэлгийн санаачлагуудыг аймаг болон үндэсний хэмжээний хөтөлбөрүүдтэй уялдуулах зөвлөмж гаргасан. Уг судалгааны зөвлөмжийн дагуу судлаачид Өмнөговь аймгийн 15 сумдын нийт 26 мал эмнэлэгт сургалт явуулж, мал эмнэлгийн үйлчилгээ, Говийн бүс дэх мал эмнэлгийн тулгамдсан асуудлын талаар 49 оролцогчдод сургалт семинар явуулсан.

(5) *Хаврын малын тэжээл: ОТ компани* сүүлийн гурван жилд Ханбогд (110 тонн), Манлай (75 тонн), Баян-овоо (65тонн) сумдад малын тоотой нь уялдуулан нэмэлт тэжээл ханган нийлүүлсэн. Өрхийн түвшинд тэжээлийг орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажиллаж, малчдын хоршоодын тусламжтайгаар ханган нийлүүлдэг.

(6) *ОТ уурхайн хашаанд мал түр бэлчээрлүүлэх журам:* ОТ компанийн уурхайн лицензийн талбайн хөндөгдөөгүй хэсгүүдэд мал бэлчих асуудлыг зохицуулах үүднээс ОТ компани, орон нутгийн малчид журам боловсруулсан ба энэ асуудлыг Жавхлант багийн засаг даргаар дамжуулан зохицуулдаг юм. Ингэснээр уурхайн лицензийн талбайд 4000 орчим га газарт мал бэлчих боломжийг нээж улмаар хавсарсан  нөлөөллийг бууруулах ач холбогдолтой юм. Уг журамд тухайн жилд уурхайн лицензийн талбайд харилцан тохиролцсон хугацаанд мал бэлчээх боломжтой өрхүүдийн шалгуурыг  тодорхойлсон. 2014 онд уг талбайд 3 өрх малаа бэлчээж, 703 толгой малаа усалж байсан бөгөөд тэдгээрийн нэг нь нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрх байсан. Уг журмыг мөрдүүлснээр мөн “хяналтын талбай”-д бэлчээрийн менежментийг туршиж, шууд ажиглалт хийх боломж олгож байгаа юм. Уурхайн хашаан доторхи бэлчээрийн талбай нь хүн амьтан орохгүй удсан учраас нэлээд сайжирсан ба энэ нь бэлчээрийн даац хэтэрсэн, тээврийн хэрэгсэл хяналтгүй ашигласантай холбоотойгоор бэлчээр доройтсон байх талтайг харуулж байгаа юм. Энэхүү талбайд Бэлчээрийн тогтвортой менежмент,

Иргэдийн оролцоотой Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд бэлчээрийг тогтвортой ашиглах туршилт хийж, хяналт шинжилгээ явуулах боломжтой болсон.

(7) *Бэлчээрийн менежментийн хөтөлбөр хариуцсан ажилтан: 2012* онд ОТ компаниас Бэлчээрийн менежментийн хөтөлбөр хариуцсан ажилтныг сонгон шалгаруулж авсан бөгөөд тэрээр дараах үүрэгтэй:

- Зөвлөхүүд, гэрээлэгчид, холбогдох орон нутгийн иргэдтэй хамтран Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах,
- Бэлчээрийн менежмент, малчин өрхийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх талаар малчдын хоршоодын санаачлагыг дэмжих,
- Орон нутгийн малчидтай хамтран бэлчээрийн зураглалыг гаргах, малчдын уламжлалт бэлчээр ашиглалтын хэв маягийг судлах ажлыг зохион байгуулах,
- Бэлчээрийн менежментийн асуудлаар холбогдох орон нутгийн бүлгүүд, нутгийн захиргааны байгууллагуудтай зөвлөлдөх,
- ТБМХ-ийн үйл ажиллагааг баримтжуулах, мэдээллийн санг удирдах,
- Бэлчээрийн хөтөлбөр, арга хандлагыг зохицуулахад ОТ компанийн Байгаль орчны хэлтсийн Биологийн олон янз байдал хариуцсан багтай хамтран ажиллах зэрэг болно.

(8) *Малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөр:* Бэлчээрийн нөлөөлөл нь орон нутгийн иргэдэд нийтэд нь хамааралтай байдаг бөгөөд малчдын амьжиргааг дээшлүүлэхийн тулд уламжлалт мал маллагаанаас бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай учраас ОТ компани нөлөөлөлд өртсөн өрхүүд, Ханбогд сумын засаг захиргаатай хамтран Малчдын амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг (МАДХ) боловсруулсан. Ханбогд сумын малчид дараах нөхөн олговор, амьжиргааг дээшлүүлэх арга алхмуудыг дэмжиж буйгаа илэрхийлсэн:

- Ажлын байр бий болгох,
- Боловсролын дэмжлэг,
- Малчдыг сургах, ур чадвар эзэмшүүлэх,
- Бизнесийг хөгжүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Бэлчээрийг сайжруулах, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх болон
- Худаг гаргах, сэргээн засварлах зэрэг болно.

МАДХ-ийг 2011 онд малчидтай харилцан тохиролцсон бөгөөд энэхүү хөтөлбөрийг Орон нутгийн бизнес, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөртэй (ОТБЭЗХХ) нэгтгэж байна (дараагийн хэсгээс харна уу).

(9) *Ажилд бэлтгэх сургалт:* ОТ компани эсхүл гүйцэтгэгч компанид ажилд орох сонирхолтой, нөлөөлөлд өртсөн хүмүүст ажилд бэлтгэх шат дараалсан сургалтыг санал болгодог. Энэхүү хөтөлбөрийг 2011 онд хэрэгжүүлж, 2012 онд хүрээг нь тэлсэн. Анхны сургалтыг 2011 оны 8 дугаар сард 120 сурагчдад зургаан сарын хугацаатай явуулсан бөгөөд сургалтын дараагийн шатны модульд хамрагдсан нийт 114 сурагчдаас 79 хувь нь эмэгтэй сурагчид байсан болно.

Ажилд бэлтгэх сургалтыг дэмжих зорилгоор ОТ компани 2012 онд Ханбогд суманд Техникийн сургалтын төв (ТСТ) байгуулсан. Уг сургалтын төв нь бүрэн үйл ажиллагаа явуулж эхлэхэд орон нутгийн иргэд, малчид Ханбогд сумаас холдолгүйгээр төрөл бүрийн сургалтад хамрагдах боломжтой болохоороо давуу талтай юм. Учир нь нийслэл хотод байршилтай төрийн мэдлийн Техник, мэргэжлийн сургалтын хөтөлбөрт элсэхийн тулд дунд сургуулийн боловсролтой байх шаардлагатай болдог (уг шаардлагыг ихэнхи малчид хангаж чаддаггүй).

Уг ТСТ нь хоцрогдол арилгах болон бусад сургалт явуулж байгаа ба ингэснээр малчид мэргэжлийн сургалтад хамрагдах боломжтой болно. Дээрх ТСТ-ийг түшиглэн, ОТ компани болон НҮБ-ийн Хүн амын сантай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Ханбогд сумын Залуучуудын хөгжлийн төвийг байгуулан үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлж байгаа нь үүний тод жишээ юм.

“Залчуудын хөгжлийн төв” төсөл нь дараах асуудалд төвлөрдөг:

- Залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ:
    - Залуучууд бие биедээ харилцан тусалж, зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ нэтврүүлэх санаачлагууд,
    - НҮБ-ын ХАС-ийн залуусын эрүүл мэнд, боловсролын сүлжээг дэмжих. “Y-Peer” сүлжээ нь залуучуудад чиглэсэн, залуучууд бие биедээ харилцан тусалж, зөвлөгөө өгөх сүлжээ бөгөөд Монгол улс даяар үйл ажиллагаа явуулдаг,
- Жендерийн хүчирхийллээс хамгаалах хүрээнд:
    - Ханбогд сумын залуучуудад чиглэсэн, жендерийн хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
- Амьдрах ухаанд сургах, нийгмийн чиг баримжаатай байгууллагуудад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд:
    - Залуучуудын хөгжлийн төв байгуулах, холбогдох үйлчилгээг бий болгох,
    - Залуу малчдын хоршоо байгуулах,
    - Залуус болон залуу малчдад зориулсан жижиг хэмжээний тусламж үзүүлэх төсөл,
    - Үйл ажиллагаагаа эхлүүлж буй нийгмийн чиг баримжаатай байгууллагуудыг санхүүжүүлэх зэрэг болно,

2014 онд нөлөөлөлд өртсөн 13 малчин жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх сургалтад хамрагдсан бөгөөд үүнд нарийн боов, зайдас хийх, жижиглэн худалдаа, тэмээний сүү боловсруулах сургалт багтсан болно. ОТ компани Ханбогд сумын иргэдэд зориулж ажилд бэлтгэх сургалтыг тууштай явуулсаар ирсэн ба 2014 онд сургалтад хамрагдсан нийт 24 оролцогчдын 12 нь нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүд байсан. Мэргэжлийн сургалтад хамрагдах боломжтой бүх малчин өрхийн гишүүд мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа ба МСҮТ-ийг бүрэн ашиглалтад орох үед тэднийг тэргүүн ээлжинд сургалтад хамруулах төлөвлөгөөтэй байна.

(10) *Орон нутгийн бизнесийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх*

ОТ компани нь Ханбогд сумын нийгмийн бүлгүүд, тэр дундаа малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнес, эдийн засгийн хөгжлийн хэд хэдэн төсөл, хөтөлбөрийг дэмжин ажилладаг. Эдгээр төслийн ихэнхи нь малчдын бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх зорилготой байдаг. Төслүүдийг малчдын хоршоодоор дамжуулан хэрэгжүүлж байгаа ба одоогоор Ханбогд суманд 8 хоршоо бүртгэгдээд байна. Тухайлбал 2015 онд л гэхэд дэмжлэг бүхий хэд хэдэн хоршоод нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэх санал боловсруулсан ба тэдгээрээс 5-7 саналыг эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой гэж үнэлсэн. Үүнд: тэмээний сүү боловсруулах, эсгий урлал, малын ферм байгуулах, бетонон блок үйлдвэрлэх, мал эмнэлэг, гутлын үйлдвэр зэргийг дурдаж болно. Амжилттай хэрэгжиж байгаа зарим бизнесийн төслүүдээс дурдвал:

*Торомны ноос:* 2015 онд ОТ компани торомны  ноос бэлтгэх  туршилтын төсөл хэрэгжүүлж малчдад тусламж үзүүлсэн. Уг төсөлд “Баян-Эрдэнэ” хоршооны 80 гаруй малчид оролцож, ноос ноолуурын улиралд 500 гаруй кг торомны ноос бэлтгэсэн. Малчид ноосыг ялгаж, гэрчилгээ авснаар, илүү үнээр борлуулж чадсан.

*Тэмээ ноослох:* ОТ компани орон нутгийн удирдлагуудын тусламжтайгаар цахилгаан машинаар тэмээ ноослох  төсөл санаачлан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд бага хэмжээний судалгаа явуулж, сургагч багш бэлтгэх сургалтыг орон нутагт, Австрали улсад тус тус явуулсан. 2015 онд Ханбогд сумын хоршоо дээрх санаачлагыг үргэлжлүүлж, олон тэмээ ноослох  ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү туршилтын төсөл болон туршилтыг өргөжүүлэх ажлыг Өмнөговь аймгийн Хөдөө аж ахуйн газраас идэвхитэй дэмжиж ажилласан.

*Цагаан идээ боловсруулах:* Ингэний  сүү боловсруулах, цагаан идээ үйлдвэрлэх нь Ханбогд сумын малчин өрхүүдийн гол бизнес болж байна. Малчид хэд хэдэн төрлийн цагаан идээ дагнан үйлдвэрлэж эхлээд байгаа бөгөөд үүнд хоормог, тараг, зайрмаг, ээдэм зэрэг бүтээгдэхүүнийг дурдаж болно. Энэ зорилгоор үйлдвэрлэгч нарт бичил зээл олгож, бүтээгдэхүүнийг нь Улаанбаатар хотод борлуулж байна.

*Малын эрүүл мэндийг сайжруулах төсөл:* Малын эрүүл мэндийн судалгаанд тулгуурлан малчдын гурван хоршоод малын эрүүл мэндийг сайжруулах төсөл санаачилж, малыг халдваргүйжүүлэх, зохих багаж, төхөөрөмж ашиглан угаалга ариутгал хийх зэрэг ажил хийж байна. Энэхүү төсөлд хоршоодыг мал эмнэлгийн үндсэн багаж төхөөрөмж, эмээр хангах зардлыг багтаасан болно.

*Оёдлын үйлдвэр:* “Өлзий Мөнх Овоо” ХХК нь оёдлын үйлчилгээ үзүүлдэг, нөлөөлөлд өртсөн өрхийн бизнес юм. Уг компани хоёр ажилтантайгаар ажлаа эхэлж өнөөдрийн байдлаар 6 ажилтантай болж үйл ажиллагааны цар хүрээгээ тэлсэн бөгөөд ОТ компани банкнаас зээл авахад нь тусламж үзүүлсэн. Энэхүү үйлдвэр нь ажлын хувцас оёж эхэлсэн ба бүтээгдэхүүнээ ОТ болон бусад уул уурхайн компаниудад нийлүүлдэг. Өнөөдрийн байдлаар уг компани үйл ажиллагаагаа төрөлжүүлж, цэвэрлэгээ, автобусны

үйлчилгээ үзүүлж эхлээд байна.

*Ногоо тарих:* 2013 онд ОТ компани Ханбогд сумын ногоо тарьж орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой иргэдийн дунд хүнсний ногоо тариалах төсөл санаачилсан. Энэхүү төслийн хүрээнд ажилгүй эмэгтэйчүүд, настайчууд, эмзэг бүлгийн иргэд, нөлөөлөлд өртсөн иргэдийг онцгойлон анхаарч хүлэмж, усалгааны систем, худаг, ногооны үр, хашаа зэрэг үндсэн хэрэгцээт зүйлсээр хангасан. Түүнчлэн хөрс боловсруулах, хүнсний ногооны үрсэлгээ хийх, хадгалалт, савалгаа зэрэг тусгайлсан технологийн сургалт (15 модуль) зохион байгуулсан. Энэ хүрээнд хүнсний ногоо худалдаалах зорилго бүхий Зах зээлийн өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохиож байгаа бөгөөд ногоочид энэ өдөр бүтээгдэхүүнээ борлуулж, санал бодлоо солилцож, бүс нутаг болон улсын хэмжээний зах зээлийн сүлжээ үүсгэж ажилладаг.

*Эсгий үйлдвэрлэл:* Сургалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн ОТ компаниас “Цагаан Алт” компанийн эсгий, эсгий урлалын 10 өдрийн сургалтыг дэмжиж ажилласан. Энэхүү сургалтыг бага орлоготой иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн бөгөөд уг сургалтад Ханбогд сумын 10 эмэгтэй хамрагдсан ба тэдгээрийн 5 нь нөлөөлөлд өртсөн өрхийн, 2 нь эмзэг бүлгийн, 3 нь ажилгүй иргэд юм. Сургалтын үеэр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ орон нутгийн зах дээр борлуулсан. Сумын захиргаатай хамтран ОТ компани дөнгөж үүд хаалгаа нээгээд буй Ханбогд сумын Иргэдийн хөгжлийн төвд эмэгтэйчүүдийн бүлгийн дунд эсгий урлалыг хөгжүүлэхэд дэмжлэг болгон тоног төхөөрөмж ханган нийлүүлсэн.

*Зайдас үйлдвэрлэл:* “Төрлийн Мянган Тайж” хоршоо 2013 оноос эхлэн зайдас үйлдвэрлэж байгаа ба ОТ компани тууштай дэмжлэг үзүүлсээр ирсэн. Уг компани саяхан Улаанбаатарт байршилтай “Фүүд Комплекс” зайдасны үйлдвэртэй Технологи дамжуулах гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу дээрх хоршоонд технологийн сургалт явуулж, орон нутгийн зах зээлд шинэ нэр төрлийн зайдас нэвтрүүлсэн.

## Судалгаа, үнэлгээ

ОТ компанийн 2015 оны өрхийн судалгааны хүрээнд ОТ компанийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй малчдад зориулсан хөтөлбөрүүдийн оролцоо, сэтгэл ханамжийг тандан судалсан. Ханбогд, Манлай, Баян-овоо сумдын зуу, зуун иргэдтэй хамтран ажилласны дотор нүүлгэн шилжүүлэлтэд орсон 55 өрхийн гишүүд ОТ компанийн зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон тухайгаа мэдээлсэн (Зураг 9). Хамтын ажиллагааг ихэнхи хүмүүс “сайн” гэж үзсэн бол хоршоодын хөтөлбөрийг үнэлэх судалгаанд хамрагдсан, хоршооны гишүүн нийт 45 хүний 60 хувь сэтгэл ханамж “дунд” гэдгээ илэрхийлсэн. Хоршоодын үйл ажиллагааг хангалтгүй гэж үзсэн шалтгаан нь хоршоодын үйл ажиллагаа дөнгөж эхэлж байгаа тул иргэдэд хүрч амжаагүй бөгөөд ОТ компанийн зохион байгуулсан Бэлчээр ашиглагчдын бүлгүүдтэй харьцуулахад төдийлөн үр дүнтэй байж чадаагүй гэж үнэлсэн байна. Хоршооны цар хүрээ тэлэх, орлого нэмэгдүүлэх, төрөөс татаас өгөх зэрэг ажлуудын үр дүн гартал нэлээд хугацаа шаардагдах тул ОТ

компани төслүүдийн явцыг нухацтай хянаж, төсөл хөтөлбөрүүддээ шаардлагатай бол зохих өөрчлөлтийг оруулж ажиллана.

Харин судалгаанд оролцогчдын 34 нь бизнесийг дэмжих үйл ажиллагаанаас чухал мэдлэг, мэдээллийг олж авсан гэж үзсэн ба ихэнхи нь дээрх үйл ажиллагаанд "сайн" гэсэн үнэлгээ өгсөн. Судалгаанд оролцогсдын 20 нь тэмээний ноос бэлдэх, тэмээ хайчлах буюу ноослох болон ЭМААБО-ны сургалтад хамрагдаж, соёлын өвийг дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон гэж тэмдэглэсэн. Харин 10 оролцогч ногоо тарих, тоосны хяналт шинжилгээ, хайлаас модны хяналт шинжилгээ, аялал жуулчлалын холбогдолтой үйл ажиллагаанд оролцсон гэж тэмдэглэсэн.

Хэдийгээр Ханбогд сумын иргэд төсөл, хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцсон ч орон нутгийн бусад иргэдтэй харьцуулбал нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхийн оролцооны түвшин харьцангуй бага байсан.

**Зураг 8. Ханбогд, Манлай, Баян-овоо сумдын шууд болон хавсарсан нөлөөлөлд өртсөн өрхүүд төсөл, хөтөлбөрт оролцсон байдал**




| № | Program | Total | KB number | RAP number |
|---|---|---|---|---|
| 1 | Elm tree monitoring | 7 | 6 | 1 |
| 2 | Cultural Heritage | 10 | 0 | 10 |
| 3 | Dust Monitoring | 14 | 9 | 5 |
| 4 | Fauna monitoring | 19 | 17 | 2 |
| 5 | Eco tourism | 25 | 24 | 1 |
| 6 | Pasture/vegetation monitoring | 35 | 33 | 2 |
| 7 | Well measurement | 36 | 13 | 23 |
| 8 | Camel Wool training | 64 | 50 | 14 |
| 9 | HSES сургалтууд | 71 | 57 | 14 |
| 10 | HSES training | 102 | 93 | 9 |
| 11 | Animal Health | 167 | 147 | 20 |
| 12 | Donation | 215 | 175 | 40 |
| 13 | The Used items from OT site | 286 | 249 | 37 |
| 14 | БАХ байгуулсан | 399 | 392 | 7 |
| 15 | Member of Cooperative | 427 | 382 | 45 |
| 16 | Business development program | 479 | 445 | 34 |
| 17 | Meeting/other engagements | | 97 | 55 |

*Эх сурвалж: Нийгмийн харилцааны хэлтсийн судалгааны үр дүн, 2015*

**Зураг 9. Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт иргэд болон нөлөөлөлд өртсөн иргэдийн тоо**




*Эх сурвалж: ОТ компанийн Нийгмийн харилцааны хэлтсийн судалгааны үр дүн, 2015*

**ОТ компани болон шууд нөлөөлөлд өртсөн малчин иргэдийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал**

Оюу толгой компани нь төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад сонирхогч талуудтай тогтоосон харилцаа холбоо, тэднийг татан оролцуулах үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор *Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөг* боловсруулсан. Оюу толгой компани газар чөлөөлөх, нөхөн олговор олгох, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр нөлөөлөлд өртсөн малчид, ард иргэдтэй дараах арга замаар хамтран ажилладаг. Үүнд:

- Оюу толгой компанийн Орон нутгийн харилцааны ажилтан айл өрхүүдээр явж уулзалт хийх
- Бэлчээр ТББ, малчдын хоршоодоор дамжуулан ажиллах,
- Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгуулагдсан Харилцааны хороо, Гурван талт зөвлөлийн уулзалт цуглаан орно.

Нөлөөлөлд өртсөн айл өрхийг татан оролцуулах арга замуудыг дор тоймлон тайлбарласан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг *Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд* тусгасан.

## Өрхийн уулзалт

ОТ компанийн Орон нутгийн харилцааны ажилтнууд (ОНХА) нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй харилцаа холбоо тогтоох, мөн тэдгээрийн аж байдлыг хянах зорилгоор өрхүүдээр явж уулзалт хийдэг. Уурхайн талбай эсвэл сумын төвөөс хол амьдардаг малчин өрхийн хувьд тэдний гэрээр зочилж уулзаж зөвлөлдөх нь тохиромжтой байдаг бөгөөд зөвхөн зөвлөж ярилцах онцгой шаардлага гарсан тохиолдолд бус, энгийн үед ч гэсэн малчдын гэрээр зочлох нь сайн харилцаатай байхад нэн чухал юм. Айл өрх бүртэй сард дор хаяж нэг удаа, хэрэв зөвлөлдөх  тодорхой асуудал байгаа бол үүнээс  олон удаа ч  уулздаг.

ОНХА бүр ойролцоогоор 8-12 нөлөөлөлд өртсөн малчин өрхийг хариуцдаг бөгөөд тэдэнтэй тогтмол харилцаатай байх үүрэг хүлээдэг. Бүх ОНХА өөрийн хариуцсан айл өрхүүдтэй хийсэн хэлэлцүүлгийн бүртгэл хөтөлж, хэлэлцүүлгийн явц, мөн тэдгээртэй холбоотой үүссэн аливаа асуудлыг Орон нутгийн харилцааны ахлах мэргэжилтэнд мэдээлэх үүрэгтэй.

Нөхөн олговор олгох, амьжиргааг сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих гол арга нь өрхүүдийн гэрээр явж уулзалт хийх юм. Мөн хувь хүн болон айл өрхүүдтэй нууц мэдээллийн талаар ярилцах шаардлагатай бол тусгайлан очиж уулздаг.

### *Малчдын хоршоод*

Малчдын хоршоодыг байгуулахын гол зорилго нь төрийн бодлоготой уялдуулан Малчдын хоршоодыг дэмжих, бэлчээрийн менежмент болон бэлчээр хамгаалах чиглэлээр өөр өөр хот айлын малчдын бүлгүүдийг татан оролцуулахад оршино. Малчдын хоршоод нь ОТ компанийн өмнө нь байгуулж байсан Бэлчээр ашиглагчдын бүлгийг орлох бололцоотой нэгж юм. 2014 оны эцэс гэхэд нийт 14 хоршоо Ханбогд суманд байгуулагдсан бөгөөд МХСМТ-ийн мэргэжилтнүүд Малчдын хоршоодод бэлчээрийн менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь дэмжлэг үзүүлж байна.

*Хамтын ажиллагааны гэрээний  Харилцааны хороо, Гурван талт зөвлөл*

ОТ компани, Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-овоо, Даланзадгад сумдын хооронд 2015 оны 4 дүгээр сард байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний гол заалтуудын нэг нь шууд нөлөөлөлд өртсөн өрхүүд болон малчдын амьжиргааг дэмжих асуудал байдаг. Монгол улсын засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, мөн 2012 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Хамтын ажиллагааны

гэрээ байгуулсан юм.

ОТ компанийн олон талт оролцоог хангах зорилгоор ОТ компанийн Нийгмийн харилцааны хэлтсийн ерөнхий менежерээр ахлуулсан Хамтын ажиллагааны гэрээний ажлын хэсэг байгуулсан бөгөөд Нийгмийн харилцааны хэлтэс, Хуулийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс, ЭМААБО-ны хэлтэс, Хангамж, Хүний нөөцийн хэлтсийн төлөөллүүдийг багтаасан. Ажлын хэсгийн үндсэн зорилго нь орон нутгийн удирдлага, орон нутгийн төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлж болох хамтын удирдлагын бүтцийг харилцан тохиролцох асуудал бөгөөд ингэснээр ОТ компанийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг хамтдаа тодорхойлох боломжийг бүрдүүлнэ. Хамтын ажиллагааны гэрээг http://ot.mn/en/communities/cooperation-agreement холбоосоор үзэх боломжтой.

Энэхүү гэрээгээр эдийн засгийн нийтлэг хөгжил, нийгмийн дэд бүтэц, соёлын өвийг сурталчлах, байгаль орчныг хамгаалах зэргээр уурхайн ашиглалтын хугацаанд ОТ компани, түүний түншлэгч орон нутгийн иргэд, байгууллагууд хэрхэн хамтран ажиллах талаар тодорхойлсон байдаг. Түншлэгч орон нутгийн иргэд, байгууллагуудын хүсэлтээр ОТ компанийн зүгээс анхаарал хандуулах тодорхой асуудлууд, ОТ компани, гүйцэтгэгч компанийн ажилчдын зүгээс орон нутгийн малчид, ард иргэд, байгаль орчинтой хэрхэн харьцахыг тодорхойлсон “тухайлсан” хөтөлбөрүүдийг дээрх Гэрээнд мөн хавсаргаж өгсөн.

Түншлэгч орон нутгийн иргэд, байгууллагуудын тодорхойлсон “тухайлсан” сэдвүүдэд дараах асуудлууд хамаарна. Үүнд:

- Усны менежмент
- Байгаль орчны менежмент,
- Уламжлалт мал маллагаа, бэлчээрийн менежмент,
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал,
- Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт боловсрол, ажил эрхлэлт),
- Орон нутгийн бизнес, худалдан авалтын сүлжээг хөгжүүлэх,
- Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд хамаарна.

Өнөөдрийг хүртэл ОТ компани орон нутгийн төсөл, хөтөлбөртэй холбоотой шийдвэр гаргахдаа албан ёсны ямар нэгэн журам баримталдаггүй байсан бол цаашдаа орон нутгийн харилцаа болон тухайлсан төсөл, хөтөлбөрүүдэд зориулах зардалтай холбоотой аливаа шийдвэрийг хамтарсан хороо албан ёсоор хуралдаж, хэлэлцэн баталж байх журамтай болсон. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг Харилцааны хороо хянаж ажиллах бол ОТ компани болон орон нутгийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг дээр дурдсан тухайлсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянан ажиллана.

Тухайлсан төсөл, хөтөлбөрүүдээс Усны менежмент, Байгаль орчны менежмент, Уламжлалт мал маллагаа, бэлчээрийн менежментийн төсөл, хөтөлбөрүүд Ханбогд сумын иргэдийн анхаарлыг онцгойлон татаж байгаа учраас тэдгээрийг нэг ажлын хэсэгт даалган өгсөн. Энэхүү ажлын хэсгийг “Гурван талт зөвлөл” гэх бөгөөд уг зөвлөлд орон нутгийн засаг захиргаа, малчид болон компани гэсэн гурван талын төлөөлөл багтсан болно. Гурван талт

зөвлөл байгуулах Харилцан ойлголцлын санамж бичиг, зөвлөлийн батлагдсан дүрмийг талууд хүлээн авсан ба хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээрийг олон нийтэд танилцуулах боломжтой, мөн ойрын хугацаанд холбогдох цахим хуудсанд байршуулахаар төлөвлөж байна.

Гурван талт зөвлөлийг байгуулахдаа ОУСК-ийн Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газарт ирүүлсэн албан ёсны хоёр өргөдөл гомдлыг шийдвэрлэх зорилгоор зохион байгуулсан хоёр талын яриа хэлэлцээний үр дүнг үндэслэсэн. Уг өргөдөл гомдолд ОТ компанийн 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрын хөтөлбөрүүд нь тогтвортой амьжиргааг дэмжиж чадаагүй, уламжлалт амьжиргааны хэв маяг, үр хойчид уламжлах соёлын элементийг эвдсэний нөхөн олговор хангалтгүй гэж буруутгасан байдаг (8-р хэсэг). Сумын түвшний Нөхөн олговор хариуцсан ажлын хэсгийг татан буулгасан тул цаашдаа Гурван талт зөвлөл нь нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрын асуудалтай холбоотой зөвлөх үүргийг хүлээн авч, сумын хэмжээний шууд бус нөлөөллийг бууруулах, ОТ компанийн малчдыг дэмжих ерөнхий хөтөлбөрүүдийг хариуцан ажиллахаар болсон.

# 8. ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

2014 онд ОТ компани БОННҮ-г нийтэд танилцуулах журам, орон нутагтай зөвлөлдөх хэлэлцүүлгийн үеэр хүлээн авсан саналуудыг үндэслэн гомдол, маргааныг барагдуулах журмаа шинэчилсэн. Энэхүү шинэчилсэн хувилбар нь орон нутгийн иргэд, бусад талууд санал гаргах, асуулт асуух, гомдол мэдүүлэх процессыг ойлгомжтой, хялбар болгосон ба шууд шийдвэрлэх боломжгүй гомдлыг дараачийн шатанд шилжүүлэх процессыг тодорхой зааж өгсөн. Шаардлагатай тохиолдолд гомдол, маргааныг гуравдагч талын зуучлалаар дамжуулан шийдвэрлэх боломжтой.

Дээрх гомдол, маргаан шийдвэрлэх үйл явцыг орон нутгийн харилцаа, олон талт хамтын ажиллагааг бүртгэх, хянах, удирдах менежментийн системийн хүрээнд зохицуулна.

ОТ компани нь цахим хуудас, утас, и-мэйл, мессежээр ирсэн болон ОТ компанийн ажиллагсдад (түүнчлэн ОТ-н гүйцэтгэгч компанийн ажилчидад) биечлэн хандсан аливаа олон нийтийн мэдээлэл, харилцааг Орон нутгийн иргэд, оролцогч талуудын харилцааг бүртгэх системдээ (ОНИОТХБС) бүртгэн авдаг. ОНИОТХБС-ийн зохицуулагч нь орон нутгийн иргэдээс мэдээлэл харилцааг хүлээн авах, бүртгэх, мэдээлэх, хяналт шинжилгээ хэрэгжүүлэх  үүрэгтэй.

Гомдол, маргааныг шийдвэрлэх журмын үйл явцыг Хавсралт VIII-д оруулав.

### Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газрын зуучлал/Гурван талт зөвлөл

2012 оны сүүл, 2013 оны эхээр хэсэг малчид ОУСК-ийн Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газарт албан ёсны хоёр өргөдөл гаргасан (ОУСК-ийн гомдол шийдвэрлэх журамд хувийн мэдээллийг хамгаалах заалт байдаг учраас ямар дугаартай болох нь мэдэгдээгүй) ба уг өргөдөлд ОУСК нь ОТ төслийг санхүүжүүлэх, тэр дундаа ОТ компанийн нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийг хангалттай гэж үзэх нь ОУСК өөрийн гаргасан стандартаа зөрчиж буй хэрэг хэмээн мэдүүлсэн байна. Түүнээс хойш ОТ компани дээрх хоёр өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газар, Малчдын төлөөлөгчдийн баг бүрэлдэхүүн ( “ОТ Хяналт” ТББ, “Говийн газар шороо” ТББ-уудын тусламжтай малчдын төлөөлөгчид, гомдол гаргагчид) хамтран ажиллаж байна.

Дээрх өргөдөл гомдолд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдад олгосон нөхөн олговрын хэмжээ хангалтгүй байсан гэж үзсэн. Уг өргөдөлтэй холбоотой талууд  уулзалт тогтмол зохион байгуулсан ба 2014 оны 12-р сарын 16-ны өдрийн хурлаар Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газраас дээр дурдсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу уг асуудлыг Гурван талт зөвлөлд шилжүүлэх нөхцөл хангагдсан гэдгийг баталгаажуулсан. Малчдын төлөөлөгчдийн баг бүрэлдэхүүн, Ханбогд сумын удирдлагууд, ОТ компани албан ёсоор Гурван талт зөвлөлийг байгуулж, өргөдөл гомдол дээр ажиллах, мөн ОТ компани болон малчдын хоорондох бусад асуудлаар сар  бүр уулзаж байхаар тохиролцсон (7-р хэсэг). Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газар нь эхний үе шатны үйл ажиллагааг хянаж ажиллах ба талууд асуудлыг шийдвэрлэх замаар хамтран ажиллаж байна гэж үзвэл тухайн өргөдөл гомдлыг эцэслэх юм.

Гурван талт зөвлөлийн баталсан ойрын үед авах арга хэмжээ нь малчин өрхүүд, Ундай голд үзүүлэх нөлөөлөлд хараат бусаар хамтын хяналт шинжилгээ хийх асуудлыг удирдан чиглүүлэх явдал юм. Энэ зорилгоор Олон талт  шинжээчдийн  баг (ОТШБ)-ийн судалгааны хамрах хүрээг баталж, уг судалгааг явуулах тендерийг зарлаад байгаа (Хавсралт X). Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний хувьд энэхүү судалгаагаар малчдын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх мэдээллийн санг нэмэгдүүлэх боломжтой ба уг мэдээллийг ашиглан нүүлгэн шилжүүлэлтийн гэрээг үнэлэх боломжтой.

## Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговортой холбоотой өргөдөл гомдлын тойм

2004 оны Нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны Эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговортой холбоотойгоор хүлээн авсан гомдлуудын ихэнхи нь нөхөн олговорт хамрагдах боломжтой эсэхийг тодруулах хүсэлтүүд байсан. Тэдгээрээс айл өрхүүд нөхөн олговор авах боломжтой өрхийн жагсаалтанд орох ёстой гэсэн шууд хүсэлтүүд илүү давтамжтай ирж байсан. Түүний дараагаар нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөлтэй холбоогүй, харин байгаль орчин, малд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай гомдол саналууд ирж байсан билээ.

Бүх гомдол, санал хүсэлтийг жил жилээр нь бүртгэж, хянаж, шийдвэрлэж байгаа ба 2013 онд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговортой холбоотой нийт 52 гомдол бүртгэгдсэний

наймаас бусдыг нь шийдвэрлэж, хаасан. Шийдвэрлээгүй байгаа найман гомдлоос дөрөв нь нөхөн олговорт хамрагдах өрхүүдийн ангилал хангалтгүй, сумын хэмжээнд хавсарсан нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговор олгох хэрэгтэй гэсэн байна. Эдгээр нь Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмэний газар/Гурван талт зөвлөлийн шийдэх асуудал ба Ханбогд сумын хэмжээнд өрхийн судалгааг (дээр дурсдсан Олон талт  шинжээчдийн судалгаа) явуулж дуусмагц шийдвэрлэгдэх боломжтой болно.

Үлдсэн дөрөв нь Эхэн, Дунд, Адаг, Халив орчмын худаг усгүй болсонтой холбоотой 2012 оны гомдол саналууд юм. Худаг гаргах, сэргээн засварлах гэсэн хэсэгт заасанаар ОТ компани 2013, 2014 оны хуурайшилтай улиралд айл өрхүүдийг зөөврийн усаар хангаж байсан ба худаг  шинээр гаргах,  сайжруулах ажлыг гүйцэтгэсэн билээ. Харин 2015 онд хур бороо элбэгтэй байснаар хөрсний усны ундрага сэргэсэн. Худаг устай болж, шинэ худаг байгуулсан хэдий ч урт хугацаанд асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэх хүртэл нөхцөл байдалд үргэлжлүүлэн хяналт шинжилгээ хийнэ.

2014 онд 23 санал хүсэлт хүлээн авсаны нэг нь дээр дурдсан Халивын худгийн асуудалтай холбоотой байсан ба хүсэлтүүдийг бүгдийг нь шийдвэрлэсэн. Барилга угсралтын ажил багассан, ОТ компанийн үйл ажиллагаа тогтворжиж байгаа, орон нутгийн иргэд нөхөн олговорт хамрагдах шалгуур, журмын талаар илүү ойлголттой болсонтой холбоотойгоор жилээс жилд гомдлын тоо буурсаар байна.

**Зураг 10. Бүртгэгдсэн гомдлын төрлүүд, шийдвэрлэгдсэн байдал: 2013-2015**




## 9. ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА

Нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөллийн хүрээнд  хувийн болон гэр бүлийн шалтгааны улмаас аливаа нөлөөллийг даван туулах чадвар бусадтай харьцуулбал харьцангуй багатай хүмүүсийг эмзэг бүлгийн иргэд гэж авч үздэг. Ханбогд сумын хөгжил (өнгөрсөн арван жилд гарсан Монгол улсын хөгжил) болон эдийн засгийн хурдацтай өсөлтэй уялдан инфляцийн өсөлт мөн түргэсэн нь өрхийн орлогоо нэмэгдүүлэх

чадваргүй хүн амд хүнд цохилт болсон. Дээрх нөлөөллийн аль аль нь Ханбогд суманд мэдрэгдэж байна. Нэг нь ОТ компаниас шууд шалтгаалах нүүлгэн шилжүүлэлтийн үр нөлөө ба нөгөөх нь шууд бусаар ОТ компаниас шалтгаалсан инфляцийн дарамт байдаг.

Амьдрал дээр дээрх хоёр нөлөөллийг ялгаж салгахад хэцүү учраас ОТ компани тодорхой хэмжээнд тэдгээр нөлөөллийг нийтэд нь удирдах, нөлөөллийг бууруулах үүрэг хүлээж байдаг. Аливаа нийгмийн хувьд амьжиргааны доод түвшинг тодорхойлж, түүнтэй уялдуулан дэмжлэгээ тодорхойлох зорилготой байдаг бөгөөд төрөөс санхүүжүүлж, зохицуулэхийг эрмэлздэг. Монгол улсын хувьд бусад орнуудтай харьцуулбал өөртөө болон өрх гэр бүлдээ анхаарал хандуулах чадваргүй иргэдийг олж тогтоож, хяналт тавьж, тусламж дэмжлэг үзүүлэх сайн тогтолцоотой бөгөөд энэ талаар хүлээсэн үүргээ төр хангалттай биелүүлж ирсэн. Иймд ОТ компаниас шалтгаалсан инфляцийн нөлөөнд илүүтэй өртөж буй эмзэг бүлгийн иргэдийг олж тогтоож, дэмжлэг үзүүлэхэд Монгол улсын Засгийн газартай хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн юм.

Төрөөс баримталдаг шалгуурын дагуу өрхүүд сумын эмзэг бүлгийн иргэдийн бүртгэлд орж, улмаар төрөөс үзүүлэх халамжид хамрагдах боломжтой. Төрөөс эмзэг бүлгийн иргэн гэдэг шалгуурт дараах үзүүлэлтийг хамааруулдаг. Үүнд:

- Өрх толгойлсон ганц бие иргэн,
- Гэр бүлийн гишүүн нь байнгын асаргаа шаарддаг;
- Олон хүүхэдтэй, орлого багатай өрх;
- Өрхийн бүх гишүүд ажилгүй
- Бага орлоготой өрх (нийт орлогыг гэр бүлийн гишүүдийн тоонд хуваасан дүнгээр) зэрэг орно.

2011 онд ОТ компани “эмзэг бүлгийн иргэд”-эд эмзэг бүлгийн иргэдийн бүртгэлд хамрагдсан Ханбогд сумын оршин суугчдыг хамруулах нь зүйтэй гэж үзсэн. Энэхүү тодорхойлолт нь хэдийгээр тохиромжтой боловч “шалтгаан, үр дагавар”-ын асуудлаас болоод ОТ компани яг аль өрхүүдэд тусламж үзүүлэх үүрэгтэй вэ гэдгийг тодорхойлоход амаргүй болсон. Тухайлбал төрөөс “эмзэг бүлгийн иргэд”-ийн тодорхойлолтыг өөрчилснөөс эмзэг бүлгийн иргэдийн бүртгэлд байгаа айл, өрхүүдийн амьдралын чанар сайжирсан эсэхээс үл хамааран бүртгэл өөрчлөгдсөн. Харин ОТ компанийн зорилтот бүлэг нь эмзэг бүлгийн иргэд дундаас нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд анхаарал хандуулахаар болсон.

2013 оны Ханбогд сумын хүн ам, орон сууцны тооллогоор (i) Ханбогд суманд төрсөн иргэд ерөнхийдөө эмзэг бүлэгт илүүтэй багтаж байна, (ii) ажил эрхлэлтийн хувьд эмэгтэйчүүд нь харьцангуй тааламжгүй нөхцөлтэй, (iii) боловсролын түвшин доогуур хүмүүс (бага, дунд сургууль төгссөн) ажилгүйчүүдийн ихэнхи хувийг эзэлж байна гэсэн үр дүн гарсан. 2014 онд сумын статистик үзүүлэлтээр 21 айл өрхийг эмзэг бүлгийн иргэд хэмээн тодорхойлсон байдаг. Эдгээрээс 76 хувь нь сумын төвд амьдардаг бөгөөд 71 хувь нь ажилгүй, 42 хувь нь 5 ба түүнээс дээш ам бүлтэй гэж гарсан.

## Эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих ОТ компанийн арга барил

ОТ компани сумын захиргаанаас хэрэгжүүлж буй эмзэг бүлгийг дэмжих хөтөлбөрт дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан хэвээр байна. Энэхүү ерөнхий хөтөлбөрийн хүрээнд 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн гэрээгээр хүлээсэн үүрэг дуусгавар болж, 2011 оны нүүлгэн шилжүүлэлтийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэж эхэлж буй энэ үед ОТ компани нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан, эдийн засгийн нөлөөлөлд өртсөн эмзэг бүлэгт бүртгэлтэй малчин өрхүүдийн хэрэгцээ, шаардлагыг нэг бүрчлэн авч үзэж тухайлсан тусламж дэмжлэг үзүүлж байна. Тухайлсан тусламж дэмжлэгт дараах зүйл орно. Үүнд:

- Сумын албан ёсны бүртгэлийг жил тутам хянаж, ОТ компанийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан, эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхүүдийн бүртгэлийг шинэчлэх,
- Сумын Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэстэй хамтран эмзэг бүлгийн айл өрхүүдээр явж, гэр бүлийн нөхцөл байдлыг нь баталгаажуулах,
- Гэр бүлийн гишүүдтэй ярилцаж, тухайн суманд тэдэнд тусалдаг эсхүл туслах боломжтой бусад ах дүү, хамаатан садан байгаа эсэхийг нь тодруулах,
- Тэдний зөвшөөрлөөр эмзэг бүлгийн иргэд, бусад ах дүү, хамаатан садантай сумын Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтсийн ажилтнуудын хамтаар уулзалт зохион байгуулж, олгогдож буй тусламж дэмжлэгийг хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар зөвлөлдөх,
- ОТ компанийн зүгээс тодорхой эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээг улам үр дүнтэй болгох талаар ах дүү, хамаатан садны хүмүүстэй нь уулзаж, хамтран ажиллах зэрэг орно.

Тусламж дэмжлэгт дараах арга хэмжээ багтана. Үүнд:

- Эмзэг бүлгийн өрхүүдийг зөвлөлдөх үйл ажиллагаанд байнга оролцуулах,
- Ах дүү, хамаатан садных нь тусламжтайгаар нөхөн олговор болон бусад нийтлэг дэмжлэг авах эрх үүссэн эсэхийг нь тодорхойлох,
- ОТ компанид эсхүл гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч компанид эсхүл өөр аль нэг байгууллагад ажилд ороход нь шаардлагатай байгаа сургалтад хамрагдахад нь туслах,
  Төрөөс олгох тусламж, тэтгэмжийн талаар ойлголт өгөх, мөн боломжуудын талаар мэдээлэл хүргэх, Гэр бүл, эрүүл мэнд, мөнгөтэй харьцах, амьжиргааг дэмжих талаар амьдрах ухааны сургалт, зөвлөгөө өгөх зэрэг хамаарна.

Оюу толгой компани эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламжийг Эмзэг бүлгийн өрхүүдийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө (Хавсралт IX)-дөө тусгаж, санхүүжилтийг Нийгмийн хариуцлагын жилийн үйл ажиллагааны төсөвтөө тусгадаг. ОТ компани эмзэг бүлгийн өрхүүдийн жагсаалтанд байгаа өрхүүдэд гэр, дулаалгын материалыг үргэлжлүүлэн олгох бөгөөд өрхийн гишүүдийг тохирох ажилд ороход нь тусалж ажиллана. Ханбогд сумтай хамтран хэрэгжүүлэх Эмзэг бүлгийн өрхүүдийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөгөө сумын Засаг даргатай харилцан тохиролцсон бөгөөд уг төлөвлөгөөг Хавсралт IX-д харуулав.

# 10. ЦААШИД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Ерөнхий тойм

Өмнөх болон энэхүү НШҮАТ-ний нийгмийн хяналт шинжилгээ, үнэлгээ дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд:

- Суурь судалгаа: Нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөл, нөхөн олговор олгох, амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийн үүрэг амлалт, элементүүдийн явцыг хянах, ОТ компанийн үйл ажиллагаанаас шалтгаалах нийгэм, эдийн засгийн хүндрэлүүдийг хянах зорилгоор ОТ компаниас зохион явуулна.
- Үр дүнгийн үнэлгээ: Нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговор олгох, амьжиргааг дэмжих үйл ажиллагааны явц, үр дүнг шууд үнэлэх зорилгоор бие даасан судалгааг зохион байгуулна.
- Гүйцэтгэлийн аудит: Барилгын үе шатны нөлөөлөлд өртсөн өрхүүдийн амьжиргааг тогтворжуулах, сайжруулах үүрэг амлалтууд биелэсэн эсэхийг эцсийн байдлаар шалгах хөндлөнгийн аудит.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын шат дамжлага, төлөв байдлыг Хүснэгт 11-т тоймлон харуулав.

**Хүснэгт 11: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын матриц**

| | Арга хэмжээ | Хамрах хүрээ | Тайлагнах давтамж | Хугацаа |
|---|---|---|---|---|
| Дотоод хяналт-шинжилгээ | Суурь судалгаа | Гэрээ, гомдол санал | Сар бүр | Өнгөрсөн таван жилийн үйл ажиллагааны стандарт, журмын дагуу хийгдсэн бөгөөд Уурхайн ашиглалтын хугацааны туршид, мөн Уурхайн хаалтын дараа хэвээр |
| | | Эмзэг бүлгийн иргэд, сургалт, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, мал | Улирал бүр | |
| | | Худгийн хяналт шинжилгээ, бэлчээрийн хөтөлбөрүүд, малчин өрхүүдэд зөвлөгөө өгөх | Хагас жил тутамд | |
| | | Боловсрол, бэлчээрийн | Хамтын ажиллагааны | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нөхцөл, малын эрүүл мэнд, хүний эрүүл мэнд, орон нутгийн иргэдийн сэтгэл ханамж | гэрээний Харилцааны хороотой харилцан тохиролцсоны дагуу | үргэлжилнэ |
| Хөндлөнгийн хяналт-шинжилгээ | Үр дүнгийн үнэлгээ | 2004 оны нүүлгэн шилжүүлэлт | Нэг удаа | 2014 онд дууссан |
| | | 2011-2012 оны Эдийн засгийн нөлөөлөл, нүүлгэн шилжүүлэх буюу амьжиргааг дэмжих хөтөлбөр | 2-оос 5 жил тутамд | Дотоод хяналт шинжилгээний үр дүнгээс хамаарч 2015 эсхүл 2017 он |
| | Гүйцэтгэлийн аудит | 2004 оны нүүлгэн шилжүүлэлт | Нэг удаа | 2014 онд дууссан |
| | | 2011-2012 оны нүүлгэн шилжүүлэлт | Амьжиргааг дэмжих хөтөлбөрүүд эцэслэгдэх үед нэг удаа | Үр дүнгийн үнэлгээнээс хамаарч 2015 эсхүл 2017 |

## Дотоод хяналт-шинжилгээ

НШҮАТ-ий хүрээнд хийх дотоод хяналт-шинжилгээ нь мэдээлэл цуглуулах, нөлөөллийг бууруулах болон хөгжилд чиглэсэн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зэрэг асуудлуудыг багтаасан ба тэдгээрийг энэхүү баримт бичигт заасан үйл ажиллагаа, нөхөн олговор, цаг хугацаатай харьцуулан дүгнэнэ. Үүнд ОТ компанийн Нийгмийн харилцааны хэлтсийн зохион байгуулах Ханбогд сумын өрхүүдийн жил бүрийн судалгаа хамаарна. Олон улсын конвенцид зааснаар бол Гүйцэтгэлийн аудит хийх хүртэл өрхийн хяналт шинжилгээг явуулахыг санал болгодог хэдий ч ОТ компанийн хувьд айл өрхүүд “хангалттай” гэж үзэх хүртэл өрхийн түвшний хяналт шинжилгээг үргэлжлүүлэн хийнэ.

*Ханбогд сумын малчин  өрхүүдийн жил бүрийн судалгаа*

ОТ компанийн Нийгмийн харилцааны хэлтсээс төслийн шууд нөлөөлөлд өртсөн өрхүүдийн дунд тогтмол судалгаа явуулдаг. Ханбогд сумын малчин өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын ерөнхий хяналт шинжилгээ нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдын нарийвчилсан хяналт шинжилгээгээнд шат дараалан шилжинэ. Энэ нь компанийн үйл ажиллагаа тогтворжсон, хавсарсан нөлөөллийн суурь судалгаа, шинжилгээг хийх болсонтой уялдана. ОТ компанийн хэд хэдэн хэлтсийг хамарсан нийгэм, эдийн засаг, бэлчээр, байгаль орчны хяналт шинжилгээний ажлуудыг Хүснэгт 12-т харуулав.

*Хяналт-шинжилгээний хагас жилийн тайлан*

Хяналт-шинжилгээний хагас жилийн тайланг боловсруулж, нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааг дэмжих ажил, амжилтуудыг тайлагнадаг. Урьд нь энэхүү тайлангаар Уурхайн лицензийн талбайн эргэн тойронд болон ОТ-оос Гашуун сухайт хүртэлх зам, Нисэх онгоцны буудал, Гүний хоолойн шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамтай холбоотой асуудлуудыг голлон тайлагнадаг байсан. Харин одоо энэхүү тайлангаар Ханбогд сумын өрхүүдийг нийтэд нь, тэр дундаа хавсарсан  нөлөөллүүдийг тусгах болсон ба улмаар бэлчээрийн ерөнхий нөхцөл, Ханбогд сумын хэмжээнд малчдын нүүдэл суудал, мал аж ахуйд гарч буй өөрчлөлт  малчин өрхүүдэд хэрхэн нөлөөлж байгаа талаар ерөнхийд нь хяналт-шинжилгээ хийх боломж бүрдсэн.

Уг тайланд малчдад тусах нөлөөлөл, тэдэнд үзүүлэх ерөнхий тусламжийг авч үзэх ба гомдол санал, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн ажлуудыг тоймлон тайлагнана. ОТ компанийн Нийгмийн харилцааны баг судалгааны үр дүнг Нийгмийн харилцаа хариуцсан ерөнхий менежер, ОТ компанийн удирдлагын баг, сумын удирдлагууд, Хамтын ажиллагааны гэрээний Харилцааны хороо, Гурван талт зөвлөлд тус тус танилцуулна. Зээлдэгч байгууллагууд, хөндлөнгийн аудиторууд энэхүү тайлантай эцсийн байдлаар нь танилцах боломжтой.

Гурван талт зөвлөлийн дор явагдах Олон талт шинжээчдийн багийн судалгаа (Хавсралт Х-т үзүүлсэн Ажлын удирдамжийг  харна уу) нь одоогийн явуулах малчин өрхийн хяналт шинжилгээний ерөнхий хүрээний  нэг хэсэг бөгөөд далд уурхайн өргөтгөлийн ажлыг эхлүүлэхэд дунд хугацаанд суурь мэдээлэл  болох боломжтой юм.

**Хүснэгт 12: Малчин өрхийн хяналт-шинжилгээ**

| | Сэдэв | Хяналт-шинжилгээний арга хэмжээ | Хугацаа | Байршил/Бүлэг |
|---|---|---|---|---|
| НША01 | 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүдийн асуудлыг эцэслэх | • Оюутны тэтгэлэгийг олгож дуусгах<br>• Зарим тэтгэлэгийг орлуулах<br>• Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүд хаалтын гэрээнд гарын үсэг зурах | Албан ёсоор хаах хүртэл тухай бүрд нь зохицуулна | Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүд |
| НША02 | Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөр | • Бэлчээрийн менежментийн хөтөлбөрийн хүрээнд нөлөөлөлд өртсөн малчдад зориулан тодорхойлсон, хэрэгжүүлсэн орон нутгийн төслүүд<br>• Бэлчээрийн нөхцөл байдлын | Хагас жил тутамд | Бүх сумын малчид |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хяналт-шинжилгээний үр дүн<br>• Хэрэгжүүлсэн, төлөвлөсөн бэлчээр, мал аж ахуйг дэмжих төслүүд<br>• Бэлчээрийн менежментийн хөтөлбөрт оролцож байгаа малчид<br>• Төслүүдээ хэрэгжүүлж байгаа хоршоодын тоо, төслүүдийн төрөл<br>• Тайлант хугацаанд Эргэлтийн сангаас зарцуулсан мөнгөн дүн | | |
| НША03 | Эмзэг бүлгийн иргдэд үзүүлэх тусламж | • эмзэг бүлгийн хүмүүсийн тоо<br>• Төрийн бүртгэлд байгаа эмзэг бүлгийн иргэдийн тоо<br>• Эмзэг бүлгийн иргэдийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | Жил бүр | Нөлөөлөлд өртсөн малчид дунд байгаа эмзэг бүлгийн иргэд |
| НША04 | Боловсролын дэмжлэг | • Олгосон тэтгэлгийн тоо, үлдэж байгаа тоо<br>• Сурагчийн дэмжлэг авсан хүүхдийн тоо, үлдэж байгаа тоо<br>• Тухайн хугацаанд олгосон тэтгэлэг, боловсролын дэмжлэгийн нийт зардал<br>• Гуравдахь шатлалын боловсрол эзэмшихээр сурч буй нөлөөлөлд өртсөн өрхүүдийн гишүүдийн тоо<br>• Гуравдахь шатлалын боловсрол эзэмшээд ажилд орсон оюутны тоо | Жил бүр | Хамрагдах эрх бүхий малчин өрх |
| НША05 | Богино хугацааны, Мэргэжлийн сургалт | • Тайлант хугацаанд сургалтад хамрагдсан хүний тоо<br>• Суусан сургалтын төрөл<br>• Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн суусан сургалтын хугацаа/цаг<br>• Тухайн хугацаанд гарсан сургалтын нийт зардал | Улирал бүр | Хамрагдах эрх бүхий малчин өрхүүд |
| НША06 | Хөдөлмөр | • Ажил эрхлэх боломжтой , | Улирал бүр | Хамрагдах эрх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эрхлэлт | ажил эрхлэх сонирхсон малчдад нээлттэй ажлын байрны тоо<br>• ОТ компанид ажилд орсон хүмүүсийн тоо<br>• Үндсэн ажилд шилжсэн нөлөөлөлд өртсөн малчдын тоо<br>• Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн орсон ажлын байрны төрөл<br>• ОТ компанид ажилд орсон нөлөөлөлд өртсөн хүмүүйн цалин хөлс, өөрчлөгдсөн эсэх<br>• Нөлөөлөлд өртсөн хүмүүст зориулан хэрэгжүүлсэн ажлын байранд бэлтгэх болон бусад дагалдан сургалтууд<br>• Тэтгэвэрт гарсан нөлөөлөлд өртсөн малчдын тоо | | бүхий нийт малчин өрхүүд |
| НША07 | Орон нутгийн бизнес, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр | • Хэрэгжүүлсэн бизнес хөгжүүлэх төслүүдийн тоо, төрөл<br>• Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдын хэрэгжүүлж байгаа бизнес хөгжүүлэх төслүүдийн тоо, төрөл<br>• Бизнес хөгжүүлэх санаачлагад оролцож буй нийт хүмүүсийн тоо<br>• Бизнес хөгжүүлэх санаачлагад оролцож буй Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүдийн нийт тоо | Улирал бүр | Хамрагдах эрх бүхий малчин өрхүүд |
| НША08 | Бэлчээрийн даац, бэлчээрийн нөхцөл байдлын хяналт шинжилгээ | • Ханбогд сумын бэлчээрийн даац (тухайлбал: Нутаг Түншлэлийн үнэлгээгээр), иргэдийн оролцоотойгоор цуглуулсан мэдээлэлтэй хийсэн харьцуулалт | Жил бүр | Нөлөөлөлд өртсөн нийт талбай |
| НША09 | Амьтан зориулсан нүхэн гарц, бэлчээрийн | • ОТ төслийн улмаас гарсан амьтантай холбоотой осол зөрчлийн тоо<br>• Амьтан гарах гарцын тоо, | Улирал бүр | Бэлчээрийг хуваах нөлөөлөлд өртсөн малчид |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хуваагдал | ажиллагаатай байгаа эсэх<br>• Замын тэмдэглэгээ, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бусад арга хэмжээний төрлүүд | | |
| НШҮА10 | Орон нутгийн гомдол санал, түүнийг удирдах журам | • ОТ компани нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ хэрэгжүүлж эхэлснээс хойш гарсан шийдэгдээгүй гомдол, тэдгээрийн явц<br>• Тухайн сард гарсан нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой шийдэгдээгүй гомдлын тоо<br>• Тухайн сард шийдвэрлэсэн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой гомдлын тоо | Сар бүр | Нөлөөлөлд өртсөн нийт малчин өрх |
| НШҮА11 | Малчдын худаг | • Ундны усгүй болсон эсвэл усны хүртээмж хязгаарлагдсан өрхүүдэд зориулж шинээр барьсан эсхүл сэргээн засварласан худгийн тоо<br>• Малчдын худагт зориулсан Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт оролцож буй нөлөөлөлд өртсөн малчдын тоо<br>• Худгийн усны чанар болон хүрэлцээ муудсан талаар хяналт-шинжилгээгээр тогтоогдсон тохиолдлын тоо | Хагас жил тутамд | Худгийн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүд |
| НШҮА12 | Нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдийн хөтөлбөрүүдтэй холбоотой сэтгэл ханамж | • Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн амьжиргааг дэмжих хөтөлбөр болон ОТ компанийн бусад тусламжийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа<br>• Орлогын түвшин, малын тоо, хөрөнгийн хэмжээ, тоног төхөөрөмж, бусад хөрөнгө эзэмшил, орлогын эх үүсвэр, ус хангамжийн байдал, эрүүл мэнд, боловсрол гэх зэрэг үзүүлэлтээр судалгаанд | Хаагдах хүртэл жил бүр | Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүд, нийт талбай |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хамрагдсан, нөлөөлөлд өртсөн өрхүүд | | |

**Хөндлөнгийн хяналт-шинжилгээ**

*Үр дүнгийн үнэлгээ*

Үнэлгээний гол зорилго нь урт хугацаанд малчдын амьжиргаа хэрхэн дээшилж байгааг тодорхой давтамжтайгаар хэмжих асуудал бөгөөд нүүлгэн шилжүүлэлт, бусад үйл ажиллагааны нөлөөллийг бууруулахад аль арга хэмжээ нь үр дүнтэй байсан, үр дүнгүй байсан бол шалтгааныг тодорхойлоход оршино.

*Үнэлгээний явц*

Үр дүнгийн үнэлгээнд тоогоор илэрхийлэгдэх шууд үзүүлэлтээс (Хавсралт V болон Хавсралт VI) гадна шууд бус үзүүлэлтийг мөн ашигладаг. Хүмүүс өөрсдийн бодит орлого, эд хөрөнгөтэй холбоотой мэдээллийг бүрэн зөв танилцуулах хүсэлгүй байгаа нөхцөлд дээрх үзүүлэлтүүдийг ашиглана. Уг мэдээлэлд хүнс тэжээлийн хангамж, сургуульд хамрагдалт, мотоцикл, цахилгаан үүсгүүр, телевизор гэх мэт зүйлсийг худалдан авсан тухай мэдээлэл хамаарч болно. Ирээдүйд хийгдэх үнэлгээнд судалгааны үнэн зөв байдал, үр ашгийн асуудалд анхаарна.

Үнэлгээг хийхэд ашиглах материалууд:

- Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны энэхүү төлөвлөгөө,
- БОННҮ-ний хүрээнд хийгдсэн Нийгэм, эдийн засгийн суурь судалгаа,
- Олон талт шинжээчдийн багийн судалгаа (Хавсралт X),
- Хавсралт II-т заасан Монгол улсын хууль тогтоомжууд,
- Газар чөлөөлөх, албадан нүүлгэх тухай ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 5 болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Гүйцэтгэлийн стандарт 5 зэрэг болно.

ОТ төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс, орон нутгийн ард иргэдийн оролцоог хангахын тулд дор дурдсан болон бусад олон механизмыг ашигладаг. Үүнд:

- Шууд болон хавсарсан байдлаар нөлөөлөлд өртсөн хүмүүсээс (жендэр, насаар нь ангилан) түүврийн аргаар ярилцлага авах, зорилтот бүлгийн уулзалт хийх,
- Орон нутгийн ахлагч нартай хамтран зорилтот бүлэг, гол оролцогч талуудтай ярилцлага хийх,
- Орон нутгийн ТББ, орон нутгийн байгууллагуудтай ярилцлага хийх, зорилтот бүлгийн уулзалт хийх.

*Үнэлгээний зорилго, үнэлгээний хүрээ*

Үр дүнгийн үнэлгээний зорилго нь хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд болон урт

хугацааны үр дүнг хэмжих явдал юм. Хяналт-шинжилгээ нь шинээр баригдсан худгийн тоо зэрэг мэдээллийг орцод тулгуурлан цуглуулах болovч үнэлгээний явц нь НШҮАТ-г хэрэгжүүлснээр хүссэн зорилго, үр дүндээ хүрч чадсан эсэхийг тогтооход чиглэдэг.

Өмнөх НШҮАТ-ний ерөнхий зорилго нь ОТ төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргаа, амьдралын түвшин нь нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнд “хэвийн байдалдаа орсон эсхүл дээшилсэн” байх тухай асуудал байсан. Ирээдүйд хийгдэх үр дүнгийн үнэлгээ нь дараах хамрах хүрээтэй байна. Үүнд:

- Нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлт, амьжиргаатай холбоотой нийтлэг хөтөлбөрүүдийг үнэлэх,
- Шууд болон хавсарсан байдлаар нөлөөлөлд өртсөн өрхүүдийн орлогын түвшин, амьдралдаа сэтгэл ханамжтай байгаа байдал зэрэг амьдралын стандартын үнэлгээ,
- ОТ компанийн одоогийн явуулж буй үйл ажиллагааны улмаас үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох, эрх зүйн хэрэгжилтийг хангах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зэрэг болно.

*Үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтүүд*

Үнэлгээ нь дээр тодорхойлсон хяналт-шинжилгээний явцад цуглуулсан мэдээлэл, тэр дундаа өрхүүдийн жил бүрийн судалгааны үр дүнд голчлон анхаарна. ОТ компани болон Ханбогд сумын захиргаанаас боловсруулсан үзүүлэлтүүдийг Хүснэгт 13-т харуулав.

**Хүснэгт 13**: Шууд болон хавсарсан нөлөөлөлд өртсөн өрхүүдийн гүйцэтгэлийн үзүүлэлт

| ID | Үр дүнгийн үзүүлэлт | Зорилтот салбар | Зорилт | Хяналт-шинжилгээний арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| НША-ын ГҮҮ1 | Боловсрол | Анхан, дунд, дээд шатлалын боловсролын сургуульд хамрагдсан хүүхдийн тоо, сургууль элссэн хүүхдийн тоо | • 2017 онд 100 хувь тухайн сургуульд хамруулах<br>• Сургуульд хамрагдах хүүхдийн тоог жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ2 | Эрүүл мэнд | 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдлийн түвшин, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн өвчлөл | • 2017 онд улсын түвшнээс 10 хувиар бага байлгах | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ3 | Орлого | Хүйсээр ялгасан өрхийн орлогийн түвшин, өрхийн ажилтай хүмүүсийн тоо, Төслийн зүгээс ажилд авсан хүний тоо (ажил эрхлэлтийн төрөл), орлогын шинэ эх үүсвэр, малын тоо толгой | • Орлогын түвшин ХҮИ (Инфляцийн түвшин)-ээс илүү хэмжээгээр өсөх<br>• Өрхийн орлогод эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жинг тэнцвэрт хэмжээнд хүртэл жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх<br>• Ажил эрхлэлтийн түвшинг аймаг, улсын хэмжээнээс дээгүүр байлгах<br>• 2017 он гэхэд бэлчээрийн нөхцөл байдал, сүргийн бүтэц зэргийг харгалзан малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барих (малын тоо буурах эсхүл нэмэгдэх, тархалтыг жигдрүүлэхгэх мэт)<br>• 2017 он хүртэл эхний таван | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | жил тутамд жижиг бизнесийг 50 хувиар нэмэгдүүлэх | |
| НША-ын ГҮҮ4 | Гэр ахуйн удаан эдэлгээт бараа | Радио, унадаг дугуй, мотоцикл, машинтай өрхийн тоо | • Жил бүр эзэмшлийн төрөл бүрээр эд хөрөнгийн эзэмшлийг 10 хувиар нэмэгдүүлж 2017 он гэхэд аймаг, улсын хэмжээнээс 20 хувь илүү байлгах | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ5 | Ус, хангамж | Найдвартай ундны усаар хангагдсан өрхий тоо, цахилгаанд холбогдсон өрхийн тоо | • 2017 он гэхэд Ханбогд сумын төвийн бүх айл, өрхийг цахилгаан, усаар хангах<br>• Барьсан гар худгийн тоо<br>• Сэргээн засварласан гар худгийн тоо | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ6 | Нийгмийн асуудал | Гэмт хэргийн тоо Гэр бүлийн хүчирхийллийн тоо | • Жил бүр гэмт хэрэг гаралтыг 10 хувиар бууруулж 2017 он гэхэд аймаг, улсын хэмжээнээс бага түвшинд байлгах | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ7 | Орон нутгийн эдийн засаг | Ханбогд суман дахь мах, сүү зэрэг малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний үнэ, сонгино, өргөст хэмх, сармис зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, байрны түрээс, мэргэжилгүй ажилчдын өдрийн цалин (ОТ компанийн бус), Ханбогд суманд шилжиж буй иргэдийн тоо | • Жил бүрийн амьжиргааны зардлын өсөлтийг ХҮИ (инфляци)-ээс хэтрүүлэхгүй байх<br>• Шилжин ирэгсдийн тоо жилд баригдах орон сууцны хэмжээнээс хэтрэхгүй байх | Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн жил бүрийн судалгаа, эдийн засгийн судалгаа |
| НША-ын ГҮҮ8 | Ажил эрхлэлт | ОТ компанид ажилладаг, нөлөөлөлд өртсөн мэргэжилгүй ажиллагсдын хувь хэмжээ ОТ компанид ажилладаг , | • Жилд ажилд орох нөлөөлөлд өртсөн хүний тоог 5 хувиар нэмэгдүүлэх<br>• 2017 он гэхэд Ханбогд сумын өндөр мэргэжилтэй ажиллагсдын тоог 5 хувиар нэмэгдүүлэх | Ажиллах хүчний мэдээллийн сан, ажил эрхлэлтийн бүртгэл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нөлөөлөлд өртсөн хагас болон бүрэн мэргэшсэн ажиллагсдын тоо, ОТ компаниас ангилал тус бүрт бий болгосон ажлын байрны тоо | | |
| НША-ын ГҮҮ9 | Гомдол, маргаан | Бүлэг тус бүрээс гаргасан гомдлын тоо, шийдэгдээгүй гомдлын тоо, гомдлыг барагдуулж буй дундаж хугацаа, хамтын гэрээгээр шийдвэрлэж буй гомдлын хувь хэмжээ | • 2017 оны эцэс гэхэд гомдлыг шийдвэрлэх хугацааг 30 хоногоос доош болгож бууруулах | Гомдлын бүртгэл, мэдээллийн сан |
| НША-ын ГҮҮ10 | Бэлчээрийн менежмент | Нэгж бэлчээр (га тутмын), нэгж малын бүтээмж, ашиг шимийг нэмэгдүүлэх | • Бэлчээрийн нөхцөл байдал, сүргийн бүтэц зэргийг харгалзан 2017 он гэхэд малын оновчтой тоо толгойг тогтоох (малын тоо буурах эсхүл нэмэгдэх, тархалтыг жигдрүүлэх гэх мэт) | Сумын засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн яамны жилийн тайлан, малын үнэ, бэлчээрийн үр шимийн хэмжүүр |

*Үр дүнгийн үнэлгээг тайлагнах*

ОТ компанийн Нийгмийн харилцааны баг судалгааны үр дүнг Нийгмийн харилцаа хариуцсан ерөнхий менежер, ОТ компанийн удирдлагын баг, сумын удирдлагууд, Хамтын ажиллагааны гэрээний Харилцааны хороо, Гурван талт зөвлөлд тус тус танилцуулна. Зээлдэгч байгууллагууд, хөндлөнгийн аудиторууд энэхүү тайлантай эцсийн байдлаар нь танилцах боломжтой.

## Гүйцэтгэлийн аудит

*Зорилго, цар хүрээ*

Гүйцэтгэлийн аудитын зорилго нь ОТ компанийн НШҮАТ-ний дагуу хүлээсэн үүрэг амлалтууд, үйл ажиллагааг зохих хэмжээнд авч хэрэгжүүлсэн, хүссэн үр дүндээ хүрсэн эсэхийг тогтоох, нөлөөлөлд өртсөн өрхүүдийн амьжиргааг дээшилж чадсан эсэхийг үнэлэхэд оршино. Тухайлбал, 2014 оны Нүүлгэн шилжүүлэлтэд хийсэн Гүйцэтгэлийн аудитаар цөөн тооны оюутны тэтгэлгээс (орлуулан олгохоор шийдсэн) бусад бүх нөхөн олговрыг олгосон гэж үзсэн ба 10 өрхөөс 9-ийнх нь аж амьдрал сайжирсан буюу тогтворжсон гэж дүгнэсэн. Үлдсэн нэг өрх нь хувийн шалтгааны улмаас амьжиргаа дээшлээгүй ба одоогоор эмзэг бүлгийн иргэдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тусламж хүртэж байгаа.

*2011 оны эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговорт хамрагдсан өрхүүдийн* хувьд ОТ компани Гүйцэтгэлийн аудитыг 2017 онд хийхээр төлөвлөөд байна. Гэхдээ Гүйцэтгэлийн аудитын өмнө Үр дүнгийн үнэлгээ явуулах юм. Үр дүнгийн үнэлгээ, Гүйцэтгэлийн аудитыг хөндлөнгийн байгууллага хийнэ.

*Гүйцэтгэлийн аудитын үзүүлэлтүүд*

Үр дүнгийн үнэлгээний үеэр авч үзсэн үзүүлэлтүүдээс гадна Гүйцэтгэлийн аудитад Хүснэгт 14-т заасан орц, гарцын үнэлгээний үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

**Хүснэгт 14: Гүйцэтгэлийн аудитын үеэр авч үзэх Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд**

| ID | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт | Зорилт | Баталгаажуулах арга хэрэгсэл |
|---|---|---|---|
| НША-ын ГҮҮ11 | Нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлж дууссан арга хэмжээнүүд | Нөхөн олговор, амьжиргааг дэмжих ажлыг хийж дуусгасан байх | • Нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй хийх ярилцлага<br>• Үр дүнгийн үнэлгээ, хяналт шинжилгээний тайлан<br>• Өрхүүдийн жил бүрийн судалгаа |
| НША-ын ГҮҮ12 | Үүрэг амлалт, Гүйцэтгэлийн стандарт, Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн байх | Бүх үүрэг амлалтын хэрэгжилт Гүйцэтгэлийн стандарт 5 болон Монгол улсын хуулийн дагуу байх | • Орон нутгийн засаг дарга, бусад албан хаагчидтай уулзах, ярилцах<br>• Өрхүүдийн жил бүрийн судалгаа |

| | | | |
|---|---|---|---|
| НША-ын ГҮҮ13 | Нөхөн олговор хүртсэн, тусламж авсан хүний тоо | Нөлөөлөлд өртсөн бүх хүмүүс | • Нөхөн олговор, тусламжийг бүртгэх<br>• Нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй хийх ярилцлага |
| НША-ын ГҮҮ14 | Амьжиргаа нь дээшилсэн өрхийн тоо | Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргааг сэргээх, орлогыг нэмэгдүүлэх | • Амьжиргааг дэмжих арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн бүртгэл<br>• Нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй хийх ярилцлага<br>• Үр дүнгийн үнэлгээ, хяналт шинжилгээний тайлан<br>• Өрхүүдийн жил бүрийн судалгаа |

# 11 МЭДЭЭЛЭЛ БА БАРИМТЫН УДИРДЛАГА

Оюу толгой компани нь малчид, өвөлжөө, худаг, бэлчээр, малтай холбоотой мэдээлэл, Ханбогд сумын талаарх бусад мэдээллийг бүртгэн шинэчлэн хадгалдаг. Оюу толгой нь нөлөөлөлд шууд өртсөн өрхүүдийн тухай нэгдсэн мэдээллийн сан (үүнд биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөлөлд өртсөн өрхүүд, тэдгээрийн эд хөрөнгө, бусад суурь мэдээлэл, нөхөн олговор авах эрх, нөхөн олговрын төлбөртэй холбоотой мэдээлэл)-г бүрдүүлж ажилладаг бөгөөд амьжиргааг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээнүүд, гомдол барагдуулалт, эмзэг бүлгийн иргэд зэрэг мэдээллийг мөн тусгадаг. Энэхүү мэдээлэл нь нөлөөлөлд өртсөн өрхүүдийн аж амьдрал, биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрын гэрээний хэрэгжилт, хавсарсан нөлөөллийн байдал, Ханбогд сумын нийгэм, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлын талаар урт хугацаад хяналт- шинжилгээ хийх үндэс болно.

# 12 АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ, ХАРИУЦЛАГА

Энэхүү *Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний* хэрэгжилтийг Оюу толгойн Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн ерөнхий менежер хариуцана. Тодруулбал, энэхүү төлөвлөгөөтэй холбоотой бүхий л асуудлыг Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал (Эрх зүйн хэрэгжилт, засаглал) эрхэлсэн менежер хариуцах ба тэрээр Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн Ерөнхий менежерт тайлагнана.

Нөхөн олговрын асуудал эрхэлсэн ерөнхий зөвлөх нь *Нүүлгэн шилжүүлэх үйл ажилллагааны төлөвлөгөөтэй* холбоотой ажлуудыг боловсруулахад арга зүйн

зааварчилгаа өгөх, нүүлгэн шилжүүлэлтийн хавсарсан нөлөө, нөхөн олговортой холбоотой арга хэмжээний өдөр тутмын хэрэгжилтийг хариуцна.

### Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн баг

Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн баг нь байнгын ажилтан, гэрээт гүйцэтгэгч, дадлагажигч оюутнуудаас бүрдэх бөгөөд нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөл, нөхөн олговор зэргийг оруулаад нийгэмд үзүүлэх бүхий л нөлөөлөл, холбогдох арга хэмжээнүүдийг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Тус баг нь малчидтай нүүр тулан уулзах ажилтнууд, орон нутгийн хөтөлбөр хариуцсан ажилтнууд, төслийн шууд болон хавсарсан нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд зориулсан газрын менежментийн хөтөлбөр хариуцсан ажилтнуудаас бүрддэг. Үүнд:

- Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн ерөнхий менежер
- Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежер (Эрх зүйн хэрэгжилт, засаглал хариуцсан)
- Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежер (Орон нутагт үзүүлэх тусламж, хамтын ажиллагаа хариуцсан)
- Нөхөн олговрын асуудал эрхэлсэн ерөнхий зөвлөх
- Эдийн засгийн оролцоо хариуцсан ахлах мэргэжилтэн
- Нийгмийн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн
- Орон нутагтай харилцах ажилтнууд багтана.

Тус баг нь Улаанбаатар хот дахь төв оффис, Ханбогд, Даланзадгад, Оюу толгойн уурхайн талбай дахь салбар оффисуудад үйл ажиллагаа явуулдаг.

*Хүснэгт 15-д* Оюу толгой төслийн багийн гол гишүүд, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлагыг харуулсан болно.

**Хүснэгт 15: Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлага**

| Хариуцах ажилтан | Үүрэг хариуцлага |
|---|---|
| Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн | • Үйл ажиллагааны хэлтэс болон Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн багийн хоорондох харилцаа холбоог шаардлага хангасан хэмжээнд байлгахын тулд зохих хяналтыг тавих.<br>• Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө болон төсвийг батлах.<br>• Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежерт нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой |

| | |
|---|---|
| ерөнхий менежер | байнга гардаг буюу ноцтой асуудлуудыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх. |
| Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежер (Эрх зүйн хэрэгжилт, засаглал хариуцсан) | • Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах<br>• Нөлөөлөлт өртөгсдийн хяналт шинжилгэ, амьжиргааг сэргээх болон бусад дэмжлэгүүд хангалттай түвшинд байгаа эсэхэд хяналт тавих<br>• Нөхөн олговрын матрицын дагуух ажлуудын гүйцэтгэлийг хянах, нөхөн олговрыг олгосон тухай баримтыг хадгалах<br>• Бэлчээрийн менежмент, амьжиргааг сэргээх болон бусад тусламжийн арга хэмжээг энэхүү төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих<br>• Шаардлагатай тайлангуудыг боловсруулж дотоод, гадаад хэрэглэгчдэд танилцуулах<br>• Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргааг сэргээх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн ерөнхий менежерт танилцуулах<br>• Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөтэй холбоотой амжилтуудыг хянаж, үнэлэх<br>• Шаардлагатай бол дүрэм журам, нөхөн олговрын арга хэмжээнд өөрчлөлт оруулах |
| Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежер (Орон нутагт үзүүлэх тусламж, хамтын ажиллагаа хариуцсан) | • Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний бүрэн хэрэгжилтийг хангах<br>• Бэлчээрийн менежмент, амьжиргааг дээшлүүлэх, бусад тусламж дэмжлэгийн арга хэмжээг бусад хөтөлбөр, хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах<br>• Гурван талт зөвлөлийн гишүүд зэрэг бүх оролцогч талуудтай малчдын асуудлаар байнгын харилцаатай байх |
| Нөхөн олговрын асуудал эрхэлсэн ерөнхий зөвлөх | • Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн нийгэм, эдийн засгийн болон бусад гол гол мэдээллүүдийг цуглуулах судалгаа, тандалтыг удирдан зохион байгуулах<br>• ОТ компанийн өмнөөс аливаа гомдол санал, маргааныг шийдвэрлэх<br>• Шууд нөлөөлөлд өртсөн өрхүүд, эд хөрөнгө, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбогдох “Орон нутаг, оролцогч талуудын оролцоог хянах системд” мэдээллийн санг байгуулж, хөтлөх<br>• Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, гадаад хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн (Эрх зүйн хэрэгжилт, засаглал хариуцсан) менежерт дэмжлэг үзүүлэх |

| | |
|---|---|
| | • Бэлчээрийн тогтвортой удирдлагын хөтөлбөр, амьжиргааг сэргээх хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг хангах |
| Эдийн засгийн хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн, Бэлчээрийн менежментийн хөтөлбөр хариуцсан ажилтан | • Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.<br>• Малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөрийг Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт тусгаж, үндсэн болон хавсарсан  нөлөөг бууруулахад туслалцаа үзүүлэх<br>• Оюу толгойн үйл ажиллагаа болон бэлчээрийн менежменттэй холбоотой арга хэмжээнүүдэд Бэлчээр ТББ болон Бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн зохицуулах.<br>• Ханбогд сумын малчдад нөлөө үзүүлж буй газрын менежменттэй холбоотой асуудлаар үйл ажиллагааны болон байгаль орчны багуудтай харилцаатай ажиллах. |
| Орон нутагтай харилцах мэргэжилтэн | • Нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд орон нутгийн Гомдол барагдуулах, маргаан таслах журмын талаар мэдээлж, уг журмыг хэрхэн ашиглах талаар тогтмол мэдээлэл өгөх.<br>• Шаардлагатай бол нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргааг дэмжих  үйл явцтай холбоотой санал, гомдол гаргахад нь туслалцаа үзүүлэх.<br>• Хялбар шийдвэрлэх боломжтой санал, гомдол, бичигт хариу өгөх.<br>• Биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговор, амьжиргааг сэргээх үйл явцын талаар оролцогч талуудын ойлголтод хяналт тавьж тайлагнах.<br>• Нөлөөлөлд өртсөн айл өрхүүд болон Орон нутагтай харилцах ахлах мэргэжилтнийг холбож ажиллах.<br>• Нөлөөлөлд өртсөн малчин айл өрхүүдтэй уулзалт хийх, материал танилцуулах болон бусад оролцооны асуудлыг зохицуулах. |

| | |
|---|---|
| Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн баг (ерөнхий ажил үүрэг) | • Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежер, Ерөнхий зөвлөхүүдэд Нүүлгэн шилжүүлэх ажлын батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллах.<br>• Малчдын бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, орон нутгийн ажилчдыг сургах, боловсролын туслалцаа үзүүлэх гэх мэт үйл үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх. |
| Гурван талт зөвлөл (Хамтын ажиллагааны гэрээний дагуу) | • Үндсэн болон хавсарсан нөлөөллийн үнэлгээг боловсруулах, мэдээлэх, хянах, нөхөн олговрын арга хэмжээг хангалттай хэмжээнд боловсруулахад дэмжлэг үзүүлэх<br>• Орон нутгийн санал, гомдол, маргааныг шийдвэрлэх журмыг зохистой хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах<br>• Малчдын анхаарлыг татсан аливаа нэхэмжлэл, бодит хавсарсанболон шууд нөлөөтэй холбоотойгоор ОТ компаниас авах арга хэмжээний талаар орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах |
| ОТ-н бүх ажилтнууд | • Хувь хүн буюу орон нутгийн иргэдээс аливаа асуудал, санал, гомдол, нэхэмжлэлийг хүлээн авч уг асуудлыг Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн баг руу шилжүүлэх.<br>• Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна ажиллахаар бол шууд удирдлагадаа энэ тухайгаа мэдэгдэх |
| Үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, менежерүүд | • Уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас гадна ажиллахаар бол Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежерт энэ тухайгаа мэдэгдэх.<br>• Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн менежерт төслийн талбайгаас гадуурх ажлын талаар өдөр бүр мэдээлэл өгч байх.<br>• Аливаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл, эсхүл нийгмийн асуудлыг хөндөх аливаа ажилд зөвшөөрөл авах. |

## Ханбогд сумын засаг захиргаа

Ханбогд сумын засаг захиргаа Оюу толгой компаниас хэрэгжүүлсэн нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанд чиглэл тус бүрээрээ оролцож ирсэн. Нөхөн олговор олгох, амьжиргааг дэмжих арга хэмжээг бэлтгэх, хэрэгжүүлэхэд сум болон багийн засаг дарга нартай зөвлөлдөж байсан ба цаашид ч зөвлөлдөж байх болно. Ялангуяа, Ханбогд сумаас дор дурдсан хүмүүс оролцсон. Үүнд:

• Ханбогд сумын Засаг дарга болон Засаг даргын орлогч;

• Жавхлант, Гавилууд, Баян, Номгон багийн Засаг дарга нар;

• Хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн;

• Газрын мэргэжилтэн;

• Суманд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх сумын бусад албан тушаалтнууд *(жишээ нь, Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийн хувьд Хөдөө аж ахуйн мэргэжилтэн) зэрэг байна.*

Баг болон сумын төлөөлөгч нар нөлөөлөлд өртсөн малчин айл өрхүүд болон Оюу толгой компанийн төлөөллийн хамт Гурван талт зөвлөлд багтдаг. Ханбогд сумын албан тушаалтнууд дор дурдсан үндсэн үүргийг хүлээдэг. Үүнд:

• Баг болон сумын засаг дарга нар: Оюу толгойтой хамтарч нөлөөлөлд өртсөн иргэдийг тодорхойлохын тулд малчин айл өрх болон орон нутгийн иргэдтэй зөвшилцөх, орон нутгийн иргэд болон Компанийн хооронд гарсан аливаа маргааныг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

• Газрын мэргэжилтэн: Бэлчээрийн тогтвортой менежментийн хөтөлбөрийг дэмжихэд шаардлагатай зөвшөөрлийг олгох процесс;

• Хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн: Эмзэг бүлгийн малчин өрхүүдийг тодорхойлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх, амьжиргааг нь дэмжихэд Оюу толгой компанитай хамтран ажиллах.

# 13 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ТӨСӨВ

2014 онд нүүлгэн шилжүүлэлт хийснээс хойш хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж ирсэн ба өнөөдөр хяналт-шинжилгээний ажил хэдийн тогтворжсон байна. ОТ компани жилийн төлөвлөгөөнийхөө хүрээнд энэхүү НШҮАТ-нд заасан шаардлагуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх дотоод хуваарь, төлөвлөгөөг цаг тухайд нь шинэчилж ажилладаг. Энэхүү НШҮАТ-г 2013 онд шинэчилж, улмаар ОТ-д гарсан өөрчлөлт, хөгжил, Хамтын ажиллагааны гэрээ, Эрх зүйн хэрэгжилт хариуцсан зөвлөх омбудсмены газрын зуучлалын үр дүнг тусгах зорилгоор 2015 онд бүрэн шинэчилж дахин боловсруулсан.

2014 онд лицензийн талбай болон хориотой бүсээс малчин өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхэд нийт 220,000 ам.доллар төсөвлөсөн (2004 оны үнээр). Уг төсвийг бүрэн зарцуулсан бөгөөд төлөгдөөгүй байгаа оюутны тэтгэлгийг эс тооцвол бүх нөхөн олговрыг төлж дууссан. Төлөгдөөгүй байгаа оюутны тэтгэлэг буюу харилцан тохиролцож орлуулсан нөхөн төлбөр нь харьцангуй бага хэмжээтэй бөгөөд Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын хэлтсийн үйл ажиллагааны төсөвт тусгасан болно.

2011 *эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговорт* зориулж 5 жилд 1.4 тэрбум төгрөгийг төсөвлөхөөр тооцоолсон (2011 оны үнээр). Эдийн засгийн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд төлөх нөхөн олговор болон амьжиргааг дэмжих арга хэмжээнүүдэд зарцуулах төсвийн ихэнх хувийг 2011-2015 онд зарцуулсан. Эдийн засгийн нөлөөллийн нөхөн

олговрын дараачийн үе шатанд (2016-2020 он) зарцуулах хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой зардлыг Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын хэлтсийн жилийн төсөвт тусгасан .

Хамтын ажиллагааны гэрээний дагуу 2016 онд Оюу толгой компани болон Өмнөговь аймагтай Хөгжлийг дэмжих санг (ХДС) байгуулснаар ОТ компанийн Нийгмийн хариуцлагын зардал, Ханбогд сумын малчид, ард иргэдийг дэмжих дараах хоёр чиглэл бий болно. Үүнд:

1. Эдийн засгийн нөлөөллийн хяналт-шинжилгээ хийх, амьжиргааг сэргээх зэрэг бизнесийн үүрэг хариуцлагуудыг хэрэгжүүлэхэд ОТ компанийн үйл ажиллагааны төсвөөс үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.
2. ОТ компанийн сонгон шалгаруулсан төслүүдэд олгох орон нутгийн хандив тусламжийг ХДС-аас санхүүжүүлэх бөгөөд ОТ компани жил бүр 5 сая ам.долларыг (худалдан авах чадварыг тогтвортой байлгах үүднээс валютын ханш, ХҮИ-тэй уясан) уг санд төвлөрүүлнэ. Иймд орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн төслүүдийг ХДС-гийн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлнэ. ОТ компани ХДС-гийн удирдах зөвлөлд 4 төлөөлөлтэй, Өмнөговийн удирдлагууд 3 төлөөлөлтэй байна. ХДС байгуулснаар орон нутгийг дэмжих хөрөнгийн хуваарилалт уян хатан байх боловч санал болгосон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхдээ өрсөлдөөнт, сонгон шалгаруулалтын зарчимд тулгуурлана. Эдийн засгийн нөлөөлөлд өртсөн болон нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан айл өрхүүдийн хэрэгцээ шаардлагыг ОТ компанийн бизнесийн үүрэг хариуцлагын хүрээнд баталгаажуулах ба бэлчээрийн менежмент, амьжиргааг сайжруулах төсөл зэрэгт ХДС-аас санхүүжилт авах хүсэлтийг хоршоо гэх мэтийн малчдын төлөөллийн байгууллагаас гаргаснаар дэмжинэ.

# 14. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭД БАРИМТЛАХ ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Одоогоор 6709А дугаартай уурхайн лицензийн талбайгаас гадна газар чөлөөлөх төлөвлөгөөгүй байгаа. Оюу толгойн Далд уурхайн бүтээн байгуулалт нь одоогийн үйл ажиллагаа, туслах үйл ажиллагаанаас үүссэн “газрын гадаргүй дээрх ул мөр”-ийг тийм ч ихээр нэмэгдүүлэхгүй. Гүний хоолойн худаг, шугам хоолой, Ханбумбатын нисэх буудал, ОТ-Гашуун сухайтын зам, одоогийн цахилгаан дамжуулах шугамын ямар нэгэн нөлөө төдийлөн мэдрэгдэхгүй боловч ашиглалтын эрчим нэмэгдэснээр замын хөдөлгөөн, нөөц ашиглалт эрчимжих сул талтай юм. Энэ нь нийтлэг нөлөөлөл бөгөөд нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөлтэй хамааралгүй юм. ОТ-Ханбогдын замын маршрутыг бага зэрэг өөрчлөх, хатуу хучилттай болгох ажлуудыг явуулж байгаа нь бэлчээрийн талбайд түр хугацаагаар нөлөөлөх боловч нэгэнт баригдсан байгууламж, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэхгүй. Үүний нэгэн адилаар эрчим хүчний дотоодын эх үүсвэрийг барьж байгуулах үед одоо байгаа эрчим хүчний зарим нэгэн шугамыг холбохын тулд багахан зайд цахилгаан дамжуулах шугам нэмж барих шаардлагатай ч үүнтэй холбоотойгоор малчид, малчдын эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй бөгөөд энэ талаар одоогоор тодорхой төлөвлөгөө гараагүй байна. Ханбогд сумын ойролцоо (<500 га газар) Үйлдвэрлэлийн бүс байгуулах асуудлыг хэлэлцэж байгаа ба хэрэв уг төслийг хэрэгжүүлбэл бага хэмжээний эдийн засгийн нөлөөлөл үүсэх ба эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэхгүй. Эдгээр тохиолдолд аливаа бүтээн байгуулалттай холбоотойгоор дагалдах буюу нэмэлт НШҮАТ-г боловсруулна.

ОТ компани аливаа нүүлгэн шилжүүлэлт хийхээр бол Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 5 (2012), Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 5 (2014) зэрэг стандартуудтай нийцүүлэн өмнө нь мөрдөж байсан зарчим, дүрэм журмаа бага зэрэг шинэчлэн мөрдөнө. (Жич: өмнөх 2014 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрын хөтөлбөрүүд нь Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 5 (2006), Гүйцэтгэлийн шаардлага 5 (2008) стандартуудтай нийцсэн болно). Ирээдүйд хийгдэх аливаа нүүлгэн шилжүүлэлттэй холбоотойгоор дараах зарчим, үүрэг амлалтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ОТ компани Монгол улсын хууль тогтоомж, Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт 5 (2012), Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 5-ын дагуу ОТ төслийн нөлөөлөлд өртсөн этгээдүүдийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох талаарх холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөнө.
- Биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөллийн аль алийг нь шийдвэрлэнэ.
- ОТ-н нөлөөллийн бүсэд газар ашигладаг эсхүл амьдардаг бүх хүмүүс амьжиргааг сайжруулах эсхүл нөлөөлөлд өртөхөөс өмнөх үеийн амьжиргааны түвшинг сэргээхэд хангалттай хэмжээний нөхөн олговор авах, амьжиргааг тогтворжуулах хөтөлбөрт хамрагдах эрхтэй.
- Нөхөн олговорт ажлын байраар хангах асуудал хамаарахгүй (өмнөх хөтөлбөрүүдийн хүрээнд ажлын байраар хангах баталгаа өгсөн нь асуудал үүсгэсэн бөгөөд урт хугацаанд үр дүн багатай байсан)
- Нөхөн олговрыг нөлөөлөлд өртсөн малчин айл өрх, хувь хүмүүст шууд олгоно.
- Нөлөөлөлд өртсөн өрхүүд (орон нутгийн иргэд)-ийг сургалтын тэтгэлэг, ЖДҮ-ийг дэмжих, бага хүүтэй зээл олгох, материаллаг тусламж үзүүлэх зэрэг газрын ашиг шимд тулгуурласан амьжиргааг тогтворжуулах хөтөлбөрт аль болох өргөнөөр хамруулна.
- ОТ компани нүүлгэн шилжүүлэлтэд өртөж байгаа эмзэг бүлгийн иргэдэд онцгой анхаарал хандуулж ажиллана. Эмзэг бүлгийн иргэд, айл өрхүүдийн хүсэлт, хэрэгцээ шаардлага, мөн ОТ компанийн эдийн засгийн нөлөөлөлтэй холбоотойгоор үүсэх үр дагаврыг харгалзан тусламжийг ямар ч хэлбэрээр үзүүлж болно.
- Мал маллагаанд түр хугацагаар эсхүл урт хугацаанд нөлөөлөх тохиолдолд Хамтын ажиллагааны гэрээний дагуу Гурван талт зөвлөл, Харилцааны хорооны харилцан тохиролцох үнэлгээний аргыг ашиглан ОТ компаниас нөхөн олговор олгоно.
- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үр дүнг нөлөөлөлд өртсөн айл өрхүүд, сумын удирдлага, Гурван талт зөвлөл, Харилцааны хороо, хөндлөнгийн этгээдүүдийн оролцоотойгоор ил тод байдлыг хангах зарчмаар хянаж, үнэлнэ.
- Нөлөөлөлд өртсөн айл өрх (мөн орон нутгийн бусад ард иргэд)-д ОТ компанийн Орон нутгийн иргэдийн гомдол, маргааныг шийдвэрлэх одоогийн журам үйлчлэх бөгөөд уг журмын хэрэгжилтэд хөндлөнгийн аудит тогтмол хийлгэдэг.
- Нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааг дэмжих төлөвлөгөөг шинээр боловсруулж, хэрэгжүүлж, үнэлэхдээ нөлөөлөлд өртөх айл өрхүүдэд мэдээлж, санал бодлыг нь тусгана.
- Өвөлжөө, худаг, зуны болон өвлийн бэлчээрийн газар нутагт нүүлгэх, шинэчлэх

бол гуравдагч талын зөвлөгөө, тусламжтайгаар шинэ газар нутгийг сонгоно. Үүнд: ОТ компани болон Өмнөговь аймгийн Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, Ханбогд сумын удирдлагууд, Ханбогд сумын байгаль орчин хариуцсан албан тушаалтнууд, газрын менежерүүд, хуулийн зөвлөх зэргийг оролцуулна.

Төслийн үйл ажиллагааны улмаас нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай болсон тохиолдолд Оюу толгой компанийн зүгээс шат дараатайгаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг Хүснэгт 16-д харуулав:

**Хүснэгт 16: Нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын үйл ажиллагааны алхмууд**

| Арга хэмжээ | Тайлбар | Хариуцах эзэн |
|---|---|---|
| 1. Нөлөөллийн газар нутгийг тодорхойлох | Төслийн үйл ажиллагааны ул мөр, дэлгэрэнгүй мэдээллийг аль болох эртнээс бэлтгэх. Хүлээгдэж буй нөлөөллийн төрөл, байршлыг газрын зураг дээр харуулах. | ОТ |
| 2. Орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх | Сум, багийн засаг дарга, багийн хурал, хөрш ард иргэдтэй уулзалт хийнэ. Нөлөөллийн газар нутгийн хил зааг, нөлөөллийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх. | ОТ |
| 3. Нөлөөлөлд өртөх айл өрхийг тодорхойлох | Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, орон нутгийн эрх баригчидтай зөвлөлдөх, өрхүүдээр явж уулзах | ОТ, ОТ компани болон Өмнөговь аймгийн хамтарсан Харилцааны хороо болон орон нутгийн засаг захиргаа |
| 4. Айл өрхийн байршил, зураглал | Өвөлжөө, худгуудын GPS-ийн байршлын тогтоох | ОТ |
| 5. Айл өрхийн бүртгэл | Гэр бүлийн гишүүд, мал сүргийг жагсаалтыг гаргах | ОТ |
| 6. Нөлөөлөлд өртсөн айл өрхийн бүртгэлийг гаргах | Хамрагдах өрхийг тодорхойлж, нөхөн олговрын багцын шаардлагыг судлах . | ОТ |
| 7. Нөхөн олговрын матрицын төслийг боловсруулах | Нөлөөллийг тайлбарлах, нөхөн олговор олгох боломжуудыг санал болгох, тайлбарлах | ОТ |
| 8. Нөхөн олговрын хүрээг боловсруулах | Харилцааны хороо, Гурван талт зөвлөл хамтраад нөхөн олговрын хөтөлбөрийн хүрээ, журмыг тодорхойлох | Нэг талаас ОТ компани, нөгөө талаас Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан орон |

| | | |
|---|---|---|
| | | нутгийн төлөөлөгчид |
| 9. Шууд нөлөөлөлд өртсөн айл өрхүүдтэй<br><br>нэмэлт тусламжийн бололцоот хувилбаруудыг хэлэлцэх | Нөхөн олговрын хэмжээг тодорхойлох зорилгоор шууд нөлөөлөлд өртсөн айл өрхүүдтэй дэлгэрэнгүй ярилцах | ОТ, нөлөөлөлд өртсөн өрхүүд |
| 10. Нөхөн олговрын матрицыг эцэслэх | Бие даасан шинжээч, Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, айл өрхүүдийг оролцуулан матрицыг эцэслэх | ОТ |
| 11. Айл өрхийн бүртгэл бүрэн гүйцэд эсэхийг нягтлах | Нөлөөлөлд өртсөн газруудаар яву, нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийн байршлыг шалгах | ОТ |
| 12. Ажлын хэсгээр хянуулах хурал | Хамрагдах өрх, олгох нөхөн олговрын багцыг эцэслэн баталгааажуулах . | Нэг талаас ОТ компани, нөгөө талаас Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан орон нутгийн төлөөлөгчид |
| 13. Нөхөн олговрын талаарх мэдээллийг нийтэд зарлах | Айл өрхүүдээр явж, нөхөн олговорт хамрагдах шаардлага, нөхөн олговрын матрицын талаар тайлбарлах, багийн хурлын үеэр танилцуулах | ОТ |
| 14. Нөхөн олговор олгох гэрээний төсөл боловсруулах | Нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй байгуулах Нөхөн олговрын гэрээний төслийг бэлтгэж, хуулийн хэлтсээр баталгаажуулах | ОТ |
| 15. Нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй гэрээ хэлэлцэж, байгуулах | Нөлөөлөлд өртсөн айл өрхүүдээр орж, тэдэнтэй байгуулах нөхөн олговрын гэрээний нөхцөлийг эцэслэн тохиролцож, гарын үсэн зурж, талуудад нэг хувийг тус бүр хадгалуулах | ОТ |
| 16. Нөхөн олговрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Сургалтад хамруулах, амьжиргааг дээшлүүлэх, тэтгэлэг олгох болон бусад үйл ажиллагаанд хамруулах | Нэг талаас ОТ компани, нөгөө талаас Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан орон нутгийн төлөөлөгчид |
| 17. Нөхөх олговрын хөтөлбөрийн | Хамгийн багадаа улиралд нэг удаа, нөлөөлөлд өртсөн бүх айл өрхөөр явж, хяналт шинжилгээ хийж, нөхөн | Нэг талаас ОТ компани, нөгөө талаас Харилцааны |

| | | |
|---|---|---|
| хэрэгжилтийг хянах | олговрын арга хэмжээний үр дүн, тулгарч буй бэрхшээлийн талаар тайлан гаргах. | хороо, Гурван талт зөвлөл, орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан орон нутгийн төлөөлөгчид |
| 18. Нөхөн олговрын хөтөлбөрийн үр дүнг үнэлэх. | Наад зах нь жилд нэг удаа хяналт-шинжилгээ хийж, Нөхөн олговрын арга хэмжээний хэрэгжилтийг үзүүлэлттэй харьцуулан хянах. | Хөндлөнгийн гуравдагч этгээд |
| 19. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд зарлах | Харилцааны хороо, Гурван талт зөвлөл, Ханбогд сум, багийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд хяналт-шинжилгээний тайланг хүргүүлэх. | ОТ |

# 15 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

| | |
|---|---|
| Файлын нэр | RD-10-PLN-0006-E-Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө |
| Тодорхойлолт | Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө |
| Зохиогчид | Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын баг |
| Үүсгэсэн огноо | 2015.05.09 |
| Баталсан | Ш.Байгальмаа, ОНХНХ-ын асуудал эрхэлсэн Ерөнхий менежер |
| Баталсан огноо | 2015.10.09 |
| Бүртгэлийн дугаарын өөрчлөлт | # |

| Эрсдлийн зэрэглэл | Үнэлгээний огноо | Эрсдэл тооцоологч | Хянаж үзэх хуваарь | Дараагийн хяналтын огноо |
|---|---|---|---|---|
| Өндөр | | Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын баг | Жил тутам | 2016.09.20 |

| Хувилбар | Дахин хянасан огноо | Зохиогчид | Баталсан | Хяналтын талаарх тэмдэглэл |
|---|---|---|---|---|
| 1.0 | 2013.09.13 | О.Энх-Ариунаа | Ш.Байгалмаа, ОНХНХ-ын асуудал эрхэлсэн ерөнхий | Баримт бичгийг баталсан. |
| 1.1 | 2013.11.21 | Л.Мөнхцацрал | Менежер | Холбогдох материалуудын дугаарыг засаж, баримт бичгийн хяналтын хэсгийг бөглөсөн. |
| 2.0 | 2015.09.20 | | Ш.Байгалмаа, ОНХНХ-ын асуудал эрхэлсэн ерөнхий | 2015 оны хяналтын үеэр шинэчлэл өөрчлөлтүүдийг тусгаж, шинэ мэдээллээр баяжуулсан<br><br>2015 оны 1-р сард гаргасан Өөрчлөлт оруулах мэдэглийн хүрээнд баталсан |

## Хавсралт 1: Ашигласан ном зүй болон анхдагч мэдээллийн эх үүсвэрийн тухай товч танилцуулга

***ОТ төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 3-р дэвтэр: Олборлох болон боловсруулах нь", Эко-Трэйд ХХК 2003.*** 2003 оны 6-р сард Монголын зөвлөх компани болох Эко-Трэйд ОТ-н уурхайгаас гадагш 20 км-ийн радиуст байгаа бүх айл өрхийг тоолсон. Газар ашиглалт, газрын эрх, өрхийн хөрөнгийн (гол төлөв мал) талаар тоо баримт цуглуулахаар айл өрхүүдэд явуулсан судалгаанд нийтдээ 15 айл өрх (91 хүн) хамрагдсан.

***ОТ Төсөл, Малчдыг нүүлгэн шилжүүлэх гэрээ, Айвенхоу Майнз, 2004 оны 9-р сар.*** Энэхүү баримт бичигт өвөлжөө болон холбогдох эд хөрөнгийг нь ОТ-н уурхайн лицензит талбайгаас нүүлгэн шилжүүлсэн 10 өрхийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын нөхцөл, хэрэгжилт, менежментийг тусгасан болно.

***Нөлөөнд өртсөн малчдын нэмэлт судалгаа, 2004-2005.*** 2004-2005 онд малчдыг нүүлгэн суурьшуулах багцад хамруулахаар 10 км-ийн Хамааралгүй бүсээс нүүлгэн суурьшуулах арван малчин өрхөөс нэмэлт тоо баримт цуглуулж авсан.

***Ханбогд суман дахь ОТ-н усны талаарх ойлголтын судалгаа, 2007.*** Нутгийн иргэд усны асуудлын талаар санаа зовж буй байдлыг үнэлж дүгнэх, хамтын оролцоотой усны менежментийн арга хэмжээг боловсруулахад энэ судалгааг ашигласан. Худаг, өвөлжөөний зураглал гаргаж, малын тоо толгой, бусад гол тоо баримтыг цуглуулсан. Нийт 280 малчин өрхтэй ярилцлага хийж, дөрвөн бүлэгт тулгуурлан өөр 51 хүнийг "Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг"-т хамруулсан. Монгол улсын Бодлогын судалгааны төв болон Хүн ам, сургалт судалгааны төв энэ ажлыг удирдсан.

***Ус ашиглалтын судалгаа, 2008.*** Гүний хоолойн орд газар орчим нутагладаг малчдаас мэдээлэл цуглуулахаар Баян багт ус ашиглалтын нэмэлт судалгаа хийсэн. Тус судалгаагаар 21 малчин өрхийг хамруулан усны уламжлалт зохицуулалтын талаарх жижиг хайгуулын хэмжилт судалгааг хийсэн.

***"Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны 2008 оны суурь судалгаа".*** ОТ-н санхүүжилтээр Монгол улсын Бодлогын судалгааны төв болон Хүн ам, сургалт судалгааны төвийн хийсэн энэ судалгаанд Ханбогд сумын төвийн нийт 70 өрх, 37 малчин өрх хамрагдсан.

***Бэлчээрийн газрын зураглал ба үнэлгээний хөтөлбөр, 2009-2010 он.*** Энэ хөтөлбөрийн ОТ-ын нөлөөллийн өөр өөр газруудын эргэн тойрны бэлчээрийг ашигладаг малчдыг тодорхойлохоор хийсэн. Тоо баримтыг Жавхлант, Гавилууд, Номгон, Баян багийн 79 малчин өрхөөс цуглуулсан. Үүний гол зорилго нь мал бэлчээрлэдэг газрын хил хязгаар, бэлчээрийн газрын менежментийн зохион байгуулалтыг ойлгох, нөлөөллийн талбаруудын болон ойр орчим дахь газрыг, мөн бусад хөрөнгийг ашигладаг малчин өрхүүдийг тодорхойлох байв. ОТ малчин өрх бүрээр орж бэлдсэн асуултын дагуу ярилцлага өрнүүлэн хариулт авч, улирлын малын бэлчээр газрын хил хязгаарыг малчидтай хамтран газрын зураг дээр тэмдэглэсэн.

***Оюу толгой төслөөс хэрэгжүүлж буй "Өмнөговь аймгийн соёлын өвийн хөтөлбөр боловсруулах" төслийн нэгдүгээр үе шатны тайлан***: 2010 оны 6-р сарын 17-нд "Сустэйнэбилити Ийст Эйжиа" (СИА) ХХК (Sustainability East Asia LLC) "Оюу толгой" ХХК-д зориулсан урт хугацааны соёлын өвийн хөтөлбөр боловсруулсан. Уг хөтөлбөр хоёр үе шаттай байсан. Нэгдүгээр үе шат соёлын өвийн суурь үзүүлэлт ба зөрүүний үнэлгээ бий болгох, хоёрдугаар үе шат нь нэгдүгээр үе шатанд цуглуулсан

мэдээллийг ашиглан соёлын өвийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах байсан. Энэ тайланд нэгдүгээр үе шатны ажлын үр дүнг хураангуйлсан байдаг.

***"Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны 2011 оны төлөвлөгөө"***: Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн талбайгаас 10 өрхийг 2004 онд биет нүүлгэн шилжүүлэлт хийж, зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас 89 айл өрхийг 2011 онд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэнтэй холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.

***Нөлөөллийн малчин өрхүүдийн судалгаа (2010- 2011 он).*** Нөлөөнд шууд өртсөн айл өрхийг тодорхойлох, тэдгээрийн талаар илүү нарийн тодорхой тоо баримт цуглуулахаар дээр дурдсан бэлчээрийн газрын зураглал, үнэлгээний хөтөлбөрийг өргөжүүлсэн бөгөөд уг судалгааг ОТ 2010 оны 9-р сараас 2011 оны 5-р сар хүртэл хийсэн. Энэ судалгаагаар нөлөөнд өртсөн бүх малчин өрхүүд, мөн Ханбогд суманд дахь бусад өрхөөр нэг бүрчилэн очиж, өрхийн бүтэц, ажил эрхлэлтийн түвшин, орлогын эх үүсвэр, мал сүрэг ба бусад хөрөнгө, бусад хүн ам зүйн тоо баримтыг цуглуулсан. Уг судалгаанд 101 айл өрх хамрагдсан. Ингээд нийтдээ энэ судалгаанд 393 хүнийг хамруулсан нь Ханбогд сумын малчдын 19%-тай тэнцэнэ).

***Бэлчээрийн газар ашиглалтын гэрээний талаарх нутгийн малчдын ойлголтын судалгаа, 2012***. Бодлого судалгааны төв, "Цэвэр эрчим хүч", "Алтан нутаг" гэх дотоодын ТББ-ууд сумын засаг захиргаатай байгуулах бэлчээрийн газар ашиглалтын гэрээний талаарх орон нутаг дахь хандлагыг бүртгэн тэмдэглэхээр Ханбогд сумын малчдын дунд хамтарсан шуурхай судалгааг хийсэн. Уг судалгаанд хамрагдсан 186 малчны 78 хувь нь бэлчээрийн газар ашиглалтын гэрээг дэмжиж буйгаа илэрхийлж, 72 хувь нь тийм гэрээг эцэслэн байгуулахад бэлэн буйгаа илэрхийлж байгаа үр дүн гарсан. Судалгааны дүнг өөр өөрсдийн харгалзах газрын бэлчээрийн менежментийг сайжруулахын тулд сумын удирдлага болон малчдын нэн тэргүүнд авах арга хэмжээг тодорхойлоход ашигласан.

***Ханбогд сумын хүн ам, орон сууцны тооллого, 2013***. ОТ-н санхүүжүүлсэн энэ тооллогоор засаг захиргааны хамгийн бага нэгжүүд буюу баг, сумын хүн амын тоог нас, хүйс, байршил, боловсрол, эдийн засгийн үйл ажиллагаа, нүүж суурьшсан байдал, орон сууцны нөхцөл зэргээр ангилсан мэдээллийг гаргасан байдаг. Уг тооллогыг Монгол улсын Засгийн газрын 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогод ашигласан аргачлалаар хийсэн бөгөөд энэ нь төр болон хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар Монголд анх удаа хийсэн хүн амын тооллого болсон.

***"Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар, 2013***. Оюу толгойн 2011 оны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар; Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн талбайгаас 10 өрхийг 2004 онд биет нүүлгэн шилжүүлэлт хийсэн болон зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэн 89 айл өрхийн 2013 оны төлөв байдалтай холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.

***Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө:*** *2013 оны 9-р сар.* Үйл ажиллагааны менежментийн энэ төлөвлөгөө бол Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий баримт бичгийн хэсэг юм. Энэ төлөвлөгөө нь менежментийн зохих харилцах хэсгийг томьёолох; албан тушаал, үүрэг хариуцлагыг тодорхойлох; менежментийн төлөвлөгөөнд хамааралтай төслийн холбогдох стандартыг тоймлон илэрхийлэх; менежментийн төлөвлөгөөтэй холбоотой төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журмыг

тодорхойлох; Гүйцэтгэлийн гол үзүүлэлт гэх мэт хяналт шинжилгээ ба тайлангын журмыг тодорхойлох; сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох; материал ба мэдээлэлд дэмжлэг болох лавлагааг томьёолох тус тус зорилготой юм.

***Зах зээлийн товч судалгаа, 2014 он*.** Энэ судалгааг Бодлого судалгааны төв Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдад хийсэн. Шууд нөлөөнд өртсөн 79 айл өрхийг хамруулсан 200 айл өрхтэй ярилцлага хийсэн. Мөн сумын засаг захиргааны төлөөлөл, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийсэн. Энэ судалгаа нь бизнес эрхлэх боломж, бизнесийн хөгжилд учрах саад тотгор болон сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг олж тогтоох зорилготой байсан.

***Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын малын эрүүл мэндийн байдлын үнэлгээ, 2014 он*.** Энэ үнэлгээг “Бизнесийн амжилтын түлхүүр” ТББ-ийн мэргэжилтнүүд хийсэн. Тэд Ханбогд сумын 161 айл өрхийг үнэлгээнд хамруулсан бөгөөд үүнээс 73 нь төслийн нөлөөллийн бүсийн, 88 нь төслийн нөлөөллийн бус бүсийн айлууд байв.

***“Өмнөговь аймгийн малчдын амьжиргааны түвшин ба эрүүл мэндийн байдлын судалгаа”, 2014 он*.** Ханбогдын малчдын амьжиргаа болон эрүүл мэндийн байдлыг үнэлж, зөвлөмж боловсруулахаар тус судалгааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төв хийсэн. Төслийн нөлөөнд өртсөн айл өрхүүдээс 9 айл уг судалгаанд хамрагдсан юм. Уг судалгааны хариуг хөдөө нутаг дахь хүмүүсийн амьжиргаа, эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн бодлогын суурь тоо баримт болгох зорилготой.

***“Хоршооны тэргүүлэх чухал төслүүд”-ийн судалгаа, 2014 он*.** Энэ судалгааг Монголын хоршооны сургалт мэдээллийн төв хоршоод болон тэдний тэргүүлэх чухал төслүүдийн өнөөгийн байдлын дүгнэсэн. Уг судалгаанд сумдын 18 хоршоог хамруулсан бөгөөд уг судалгаагаар Ханбогд сумын бүх малчин өрхийн 63.0 хувь нь хоршоонд нэгдсэн гэсэн дүн гарсан.

***“2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн хөндлөнгийн аудит, 2014 он”*.** 2014 оны 3-р сард бие даасан хоёр Монгол мэргэжилтэн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд аудит хийсэн. Тус хөндлөнгийн аудитаар 2004 онд нүүлгэн шилжүүлсэн 10 айл өрхийг хамруулж, компани тэдэнд гэрээгээр тохирсон бүх мөнгөн олговрыг олгосон бөгөөд их, дээд сургуулийн оюутны сургалтын төлбөр, сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэглэлд туслах гэх мэт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа “Нүүлгэн шилжүүлэх тухай гэрээ”-ний дагуу хэрэгжсэн эсэхэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргасан.

***“Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар, 2015”*.** Оюу толгойн нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны 2013 оны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар; Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн газраас 10 өрхийг 2004 онд нүүлгэсэн болон зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас 89 айл өрхийг 2011 онд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэнтэй холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.

***Нутаг Түншлэлийн хийж буй Ханбогд сумын Бэлчээрийн байдлын судалгаа, 2014 онд эхлээд одоогоор үргэлжилж байна.*** Энэ судалгааны зорилго нь Ханбогд сумын цөл, талын бэлчээрт гарч буй өөрчлөлтийг үнэлэхэд оршино. Богино ба урт хугацаанд бэлчээрийг тогтвортой ашиглах, дахин ургамалжуулах талаар төлөвлөлтийг хийхдээ оролцогч талууд (Ханбогд сумын малчид, сумын удирдлага болон засгийн газрын байгууллагууд) уг үнэлгээг ашиглах болно.

***Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн 1-р үе шатны тайлан, 2015***. ОУСК-ийн Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний газрын маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй ОТ болон Ханбогд сумын малчдын төлөөлөгчдөөс томилсон Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн (ХШБ) олж илрүүлсэн зүйлс. ОТ-гоос усны гурван чухал эх үүсвэрт – Ундай гол, Бор Овоогийн Задгай (Ундай голын үндсэн гольдрол) болон Халив-Дугатын гол (Ундай голын цутгалан) – учруулж буй нөлөөллийг үнэлж, тэдгээр нөлөөлөл нь бэлчээр, малчдын усны хүртээмж, чанарт яаж нөлөөлж буйд үнэлгээ хийх зорилготой. ХШБ-ийн ажил хоёр үе шаттай хийгдэхээс 1-р шатанд Ундай гол, Бор Овоогийн Задгайд төвлөрч байгаа болно.

# Хавсралт 2: ХУУЛЬ ЭРХЗҮЙН ТОГТОЛЦОО

## Монгол улсын холбогдох хууль тогтоомж

*Тойм*

Газар эзэмших, хуваарилах, хураан авах, бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулах талаар дараах хуулиуд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилдэг. Үүнд:

- Үндсэн хууль (1992 он);
- Газрын тухай хууль (2002 он);
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003 он) ;
- Иргэний хууль (2002 он) зэрэг орно.

*Үндсэн хууль*

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он) газрын менежментийн харилцаатай холбоотой дараах үндсэн зарчмыг агуулна.Үүнд:

- 6-р зүйлд Монгол Улсад газар, түүний хэвлий гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно гэж заажээ. Бэлчээр нь төрийн өмчийн газар тул хувиараа эзэмшиж болохгүй.
- Мөн "Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно" гэж заажээ. Гадаадын этгээд тодорхой нөхцлийн дагуу газрыг тодорхой хугацаагаар түрээслэж болно.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцүүлэн Үндсэн хуульд ( 16 дугаар зүйл) *хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно* хэмээн хувийн өмч эзэмших эрхийг баталгаажуулсан байна. Цааш нь *төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө* гэж заажээ.

***Газрын тухай хууль (2002 он)***

Монгол улсын Газрын тухай хуулийн 3-р зүйлд заасны дагуу өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн газрын эрхийн гурван үндсэн ангилал байдаг.

- *3.1.2 Хэсэгт* Монгол улсын иргэд хязгааргүй хугацаатай *газар өмчлөх* тухай заажээ. Газар олгох, талбайн хэмжээ зэрэг нь гэр бүлийн хэрэгцээ болон арилжааны зориулалтаар ашиглах гэсэн тодорхой хэрэглээтэй нягт холбоотой байна. Газар олгох шалгуур тухайн засаг захиргааны нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байх ёстой. Гэр бүлийн хэрэгцээнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй олгоно. Хэмжээ нь нийслэл хотод 0.07 га, аймаг орон нутагт[13] 0,35 га зэргээр засаг захиргааны нэгжийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг.

[13] Ялгавартай хэмжээгээр олгох тухай 2002 оны Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7.1-д заасан байна

- Бусад зориулалтаар ашиглах газрыг худалдаж эсвэл дуудлага худалдаагаар олгож болно. Өмчлөх эрхийг Эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон бусад холбогдох эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлсэн байх ёстой.

- *3.1.3. Хэсэгт* "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг гэж тодорхойлсон. Энэ нь түрээслэхтэй төстэй. Энэ тохиолдолд төр газрын өмчлөгч хэвээр үлддэг. Газар эзэмших эрхийг (15-60 жилээр) хязгаарлаж, мөн сунгаж болно. Айл өрх, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмшиж болох ба тодорхой хэрэглээнд хязгаарлалт бий. Газар эзэмших гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх ёстой.

- *4.1.3. Хэсэгт* "газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг гэж тодорхойлсон. Газар ашиглах эрхийг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээдэд 5 жилийн хугацаатай олгож, нэг удаад 5 жилээр сунгах боломжтой байдаг.

Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу суурин дэд бүтцийн зориулалтаар газрыг ашиглах эрхийг олгож, хураамж төлнө. Түр суурин байгуулах, зам гаргах, түүний дотор уул уурхайн зориулалтаар төслийн газар ашиглахдаа одоогоор сумын захиргаанаас жил тутам зөвшөөрөл авна. Гадаргын болон ашигт малтмал ашиглах эрхийн хоорондын ялгааны улмаас уул уурхайн лиценз дангаараа газар эзэмших эрхийг бүрдүүлэхгүй бөгөөд бэлчээр ашиглах зэрэг газрын гадаргуугийн хэрэглээг хориглодоггүй.

Тус хуульд (50-р зүйл) газар эзэмшигч, ашиглагч нь өөрийн зардлаар дараах арга хэмжээг авна гэж заажээ.Үүнд:

- газрын төлөв байдал, чанарыг хадгалах,
- хөрсний үржил шим буурахаас сэргийлэх,
- газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэхээс сэргийлэх,
- хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжихаас сэргийлэх,
- бохирдох, хордохоос сэргийлэх зэрэг болно.

Мөн дараах зүйлийг заасан байдаг. Энэ нь:

- ашигт малтмал олборлох болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаас эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулж байх;

- газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

- ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;

- бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх болно.

Энэ хууль нь төслийн үйл ажиллагаанд ашигласан газрыг нөхөн сэргээх, газарт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг ОТ төслөөс шаарддаг. Энэ газрыг малын бэлчээрийн зорилгоор ашиглахад чөлөөтэй хэвээр байна. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны улмаас бэлчээр болон

бусад этгээдийн ашиглаж буй газарт ямар нэгэн нөлөө үзүүлсэн тохиолдолд сумын Засаг дарга, одоогийн газар ашиглагчидтай хэлцэл хийнэ гэсэн үг. Энэ хуулинд мөн төсөл эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн байх тухай шаардлагыг тусгасан байдаг.

***Монгол Улсын Иргэний хууль***

Монгол Улсын Иргэний хууль нь (2002) гэрээ, шилжүүлэгтэй холбоотой асуудлыг зохицуулдаг тул Оюу толгой зэрэг аж ахуйн нэгжийн газар ашиглалтад мөн үйлчилнэ. Дээр дурдсанчлан газрыг хураан авч[14] болохгүй. Тиймээс газар эзэмшихэд төсөл хэрэгжүүлэгч, нөлөөлөлд өртсөн этгээд иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш, бие даасан хуулийн этгээд, оролцогчдын хувиар

хоорондоо (шууд ) харилцахыг шаарддаг.

Иргэний хуулийн 10-р бүлэгт өмч хөрөнгө, газар, үл хөдлөх хөрөнгийг тодорхойлжээ. Уг хуулийн

11-р бүлэгт хуулийн дагуу эзэмших, 12-р бүлэгт хувь хүн, хуулийн этгээд өмчлөх тухай заажээ. Иргэний хуулийн 101-р зүйлд (энэ хуулийн 109, 112-т дэлгэрэнгүй заасан) эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах тухай ерөнхий нөхцлийг заасан боловч газар өмчлөх, эзэмших талаар дараа нь батлагдсан Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар эзэмшүүлэх тухай хуульд дурджээ. Дундын өмч (108-р зүйл ), гэр бүлийн гишүүдийн дундын өмч (126, 128-р зүйл ) болон өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх (сервитут), (151-р зүйл ) зэрэг тусгай заалтыг төсөлд хэд хэдэн тодорхой тохиолдолд хэрэглэж болно. Газар шилжүүлэх тухай харилцан тохиролцохыг 15-р бүлэгт заасан гэрээний нөхцлөөр зохицуулна.

***Нөхөн олговор, үнэлгээ***

Газрыг хураан авах тохиолдолд төрийн байгууллагууд ерөнхийдөө газрын үнэлгээний тарифыг тогтоох тухай 2003 оны 4-р сарын 13-ны өдрийн Засгийн газрын 103-р тогтоолыг мөрдлөг болгодог. Одоогоор хот суурин газарт мөрдөгдөж буй нийтлэг жишгээр газрыг чөлөөлөхдөө хэлэлцээр хийсний үндсэн дээр аж ахуйн нэгж, нөлөөлөлд өртсөн эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээнд гарын үсэг зурсны дараа тохиролцсон нөхөн төлбөрийн 50%-ийг төлж, хашааг буулгаж, газрыг чөлөөлсний дараа үлдсэн хэсгийг төлдөг байна.

Орон нутгийн өмчийн харилцааны газар (ӨХГ) тухайн барилга, байгууламж, үйлчилгээний үнэлгээг зах зээлийн үнэлгээгээс элэгдлийн хэмжээг хасах замаар тогтоож, дахин нарийвчилсан үнэлгээ хийсний дараа төлөх нөхөн олговрыг тогтоодог. Газрын тухай хуулийн 27.4-д хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно гэж зааснаар гэрчилгээгүй оршин суугчдыг хууль бус газар ашиглагч гэж үзэж, газрыг нь чөлөөлүүлнэ.

***Тайлбар***

Одоо мөрдөж буй хуулиар өвөлжөө, хаваржааны зориулалтаар малчдад газар эзэмших гэрээг сумын Засаг дарга байгуулдаг хэдий ч эдгээр эрх холбогдох бэлчээрт хамаардаггүй. Бэлчээрийн энэ талын харилцааг зохицуулсан хуулийн заалтууд тодорхой бус бөгөөд бэлчээр нь Үндсэн хуулийн дагуу монголчуудын хувьд "нийтийн өмч" тул хувийн хэрэгцээнд зориулж хуваарилах боломжгүй төрийн баялагт тооцогдоно. Олон жилийн турш эдгээр хууль тогтоомжийн тайлбар, хэрэгжилтийн механизмыг судалсан бөгөөд хууль зөвхөн өвөлжөө, хаваржааны газрыг эзэмших гэрээ байгуулах талаар л зохицуулсан байна.

*2002 онд батлагдсан Газрын тухай хуульд суурин эсвэл хотхоноос ялгаатайгаар бэлчээрийг олгохыг зөвшөөрсөн эсвэл хориглосон заалт байхгүй байна. Энд мөн эзэмших гэрээ байгаа эсэхээс үл хамааран бэлчээрийг хамтран ашиглах шаардлагатайг онцолсон боловч бэлчээр,*

[14] зарим улс оронд “давуу эрх” гэж хураан авахыг хэлдэг.

*отрын улирлын бус үеэр бэлчээхээс өвөлжөө, намаржааг хамгаалахыг шаардсан нь хоорондоо зөрчилдөж байна*[15]

60 хүртэл жилийн хугацаагаар өвөлжөө, хаваржааны зориулалтаар "эзэмших" (эсвэл лизинг) гэдгийг орон нутгийн албан хаагчид, олон малчид ойлгож байгаа ч бүх малчид ийм гэрээ байгуулаагүй эсвэл хүсээгүй байна Олонхи малчид эзэмших гэрээ нь зөвхөн бэлчээр, өвөлжөө, хаваржаанд үйлчилнэ гэж үзэж байгаа бол сумын албаны хүмүүс гэрээ нь зөвхөн өвөлжөө бүхий 0.35 га газарт хамаатай гэж ойлгодог байна. Эзэмших гэрээг хэнтэй байгуулахыг шийдэх шалгуур нь уламжлалт бэлчээр ашиглах зарчим боловч "шинэ малчид" (төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг халж, хот суурин газар ажлын байргүй болсон үед бий болсон) өмнө нь олгоогүй нутагт хашаа хороо барьснаараа эзэмших эрхээ хангаж чадсан байдаг.

Хэдийгээр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж нь зөвхөн өвөлжөө, хаваржааны харилцааг зохицуулж байгаа боловч мал ахуйд зун эсвэл намрын бэлчээрийг хамгаалах нь мөн чухал юм. Иймд зун, намрын улиралд бэлчээрийг албан ёсоор хуваарилах боломжгүй бөгөөд нийтээрээ эзэмших эрхтэй хэвээр байна.

Монгол улсад газар эзэмших, өмчлөх тухай харилцаа хууль эрхзүйн хувьд шинэ харилцаа бөгөөд зарим оршин суугчдыг хараахан албан ёсоор эзэмшигч болон өмчлөгч гэж хүлээн зөвшөөрөөгүй байгаа бөгөөд тэд албан ёсоор өргөдөл хэрхэн гаргах талаар мэдлэггүйгээс гадна албан ёсоор эрхээ баталгаажуулах санхүүгийн боломжгүй ч байх талтай юм. Нөгөө талаар тэдний эзэмшиж байгаа газар аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уг эрхийг авах эрхтэй гэж тусгаагүй ч байх талтай юм. Зарчмын хувьд Засгийн газраас олгох газар гэж тодорхойлсон нөхцөлд тус хууль эдгээр хүмүүсийг өргөдөл гаргаж, өмчилж буюу эзэмшихийг зөвшөөрдөг.

Дүгнэвэл:

- Монгол Улсын хууль нь үнэгүй өмчлөх ("өмчлөх") эсвэл түрээслэх ("эзэмших") замаар газрыг хувиараа өмчлөх эрхийг зөвшөөрдөг. Бодит байдал дээр эдгээр газар эзэмшиж ашиглах эрх малчдын хувьд оршин суух газар, өөрөөр хэлбэл өвөлжөө, хаваржаагаар хязгаарлагддаг. Бэлчээр төрийн өмч хэвээр байна. Бэлчээрийг хувийн хэрэгцээнд ашиглах эрхийг онолын хувьд зөвшөөрөх боловч амьдрал дээр төдийлөн биелээ олохгүй байна.
- Хувь хүний эдэлж болох назартай холбоотой эрхийг бүртгүүлж, зохицуулсан байх ёстой боловч харьцангүй сүүлд баталсан хууль тогтоомж, газар хэрэглэгчдийн мэдлэг дутмаг байдлаас шалтгаалж цөөхөн газрыг (хот суурин газрын гаднах) бүртгүүлсэн байдаг.
- Үндсэн хуулийн ерөнхий зарчмаас гадна нь нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэх асуудлыг зохицуулсан хуулийн тодорхой заалтууд Монгол Улсын хуульд ерөнхийдөө байхгүй байна. Олон нийтийн хэрэгцээнд газрыг хураан авах тухай Монгол Улсын хуульд заасан байгаа боловч зөвхөн төр эсвэл төрийн байгууллага хураан авах эрхтэй юм. Зарим нэг түвшинд хэлэлцээ хийдэг бололтой мэт боловч (орлуулах үнэ бус элэгдэж хорогдсон үнээр) үнэлгээ хийх, албан бус хэрэглэгчдийн харилцааг зохицуулах үед мөрдөх (нөхөн олговор олгохгүйгээр хөөх) олон улсын шаардлагыг дагаж мөрддөх нь хангалтгүй мэт байна.

[15] Антон, С., "Газрынхаа баялгийг ашиглан амьдрах нь: Монгол Улс дахь байгаль орчин, нүүдэлчин хэв маяг', Geoforum, цуврал. 41, 2010, х 1450.

**Олон улсын стандарт, конвенцууд**

*ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандарт (2006), ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (2008)*

Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 5 ( ГС5-д), Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 5-д ( ГШ-5) газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэх тухай зөвлөмж, шаардлагыг тусгасан. Хоёр байгууллагын үндсэн шаардлагуудыг дараах байдлаар тоймлож болох юм. Үүнд:

- боломжтой бол төслийн өөр бусад хувилбарыг судлах замаар нүүлгэн шилжүүлэхээс аль болох зайлсхийж эсвэл багасгана;
- "Нүүлгэн шилжүүлэлт" (өвөлжөөгөө алдах), "эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт буюу нөлөөлөл " (амьжиргаагаа алдах) өртсөн иргэдийн аль алинд нь эдгээр шаардлагууд хамаарна. Нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөлөлд өртсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд авч үзэх ёстой.
- Төслийн зүгээс газар чөлөөлснөөс үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл, эдгээр нөлөөлөлд өртсөн хүмүүсийн газар ашиглалтад гарах хязгаарлалтыг дараах замаар бууруулах болно. Үүнд: (а) эд хөрөнгөө алдсаны хохирлыг орлуулах бүрэн дүнгээр нөхөн төлөх; б) нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохих ёсоор танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, өртсөн хүмүүст зохих мэдээлэл өгч оролцуулах зэрэг орно;
- Төслийн зүгээс нөлөөлөлд өртсөн хүмүүст (нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нөлөөлөл өртсөн аль аль нь) эд хөрөнгөө алдсаны нөхөн олговрыг бүрэн олгож, амьжиргаагаа сайжруулах, наад захнь амьжиргааны түвшингээ сэргээхэд нь туслах бусад туслалцааг үзүүлж, нүүж очсон газарт нь эзэмших зөвшөөрөлтэй орон сууцаар хангах болно.
- уугуул хүмүүс, мөн эмзэг бүлгийн иргэдийг тусгайлан авч үзнэ;
- нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргаа газраас хамааралтай эсхүл газрыг хамтран эзэмшдэг бол төслийн зүгээс газарт суурилсан нөхөн олговор олгох боломжийг судална;
- Төсөл нь "нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад тухайн орон нутгийн иргэдийн оролцуулан нөлөөлөлд өртсөн хүмүүс, олон нийтийн оролцоог хангаж зөвлөлдөнө. Зөвлөлдөх үйл явцыг хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үед үргэлжлүүлнэ”;
- Төсөл "нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс эсвэл тухайн орон нутгийн иргэдийн нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой гаргасан тодорхой асуудлуудыг хүлээн авч шийдвэрлэхийн тулд ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандарт 1 (эсвэл ЕСБХБ-ны ГШ 10 )-тай нийцсэн гомдол барагдуулах механизм, мөн маргааныг шударгаар шийдвэрлэх механизмыг тус тус бий болгоно".
- Төслийн зүгээс "төслийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс, хэн нөхөн олговор ба туслалцаа авах эрхтэй, хэн эрхгүй болохыг тодорхойлохын тулд нийгэм- эдийн засгийн суурь мэдээллийг цуглуулж, мэдээллийн баазыг бүрдүүлнэ. Засгийн газрын тодорхой журам байхгүй тохиолдолд үйлчлүүлэгч эрхээ баталгаажуулахын тулд тасалбар өдрийг тогтооно. Тасалбар өдрийн тухай мэдээллийг баримтжуулж олон нийтэд ил тод болгоно.

Гүйцэтгэлийн шаардлага 5-д дараах нэмэлт шаардлагыг агуулдаг. Үүнд:

- Төсөл нь "орон нутгийн иргэдийн хамтран эзэмшиж буй аливаа нөөц баялаг, алдагдлыг нөхөхүйц туслалцаа үзүүлэх шаардлагатай. Энэ нь олон нийтийн ашиглах боломжтой үлдсэн нөөц баялгийн үр өгөөжийг сайжруулах, ашиглах боломжгүй болгосны төлбөрт бараа материал эсвэл бэлэн мөнгө олгох эсвэл алдагдсан нөөц баялгийг өөр бусад эх үүсвэрээр орлуулах санаачлага хэлбэртэй байж болно”;

- “Төслийн зүгээс нийтийн үйлчилгээг тасалдуулахад хүргэвэл ГШ10 -д заасны дагуу

  үйлчлүүлэгч боломжтой бол нутгийн иргэд зохих өөр хувилбар дээр тохиролцож зөвшилцөх болно".

- Олон нийтэд ил тод болгох тухайд үйлчлүүлэгч "гомдлын жагсаалт, тэдгээрийн хураангуй, шийдвэрлэх арга хэмжээг тогтмол олон нийтэд мэдээлж, Амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийн арга хэмжээг ил тод болгосноор нөлөөлөлд өртсөн хүмүүс нөхөн олговор олгох журам, төслийн үе шат тус бүрт ямар үйл ажиллагаа хэрэгжих талаар бүрэн мэдээлэлтэй болсон байна ".

Гүйцэтгэлийн шаардлага 5-д Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө (НШҮАТ), Амьжиргааг дэмжих үйл ажиллагаа (АДҮА)-ны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэх талаар мөн тусгасан байдаг.

**Рио Тинто стандарт, бодлого**

Рио Тинто группийн "Орон нутгийн иргэдтэй харилцах стандартад" Рио Тинтогийн хайгуул, уул уурхайн төслүүд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах, мэдээлэл цуглуулах, нийгмийн нөлөөллийг зохицуулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах арга замыг тодорхойлсон байна. Рио Тинтогийн орон нутгийн иргэдтэй ажиллахдаа баримталдаг есөн стандарт байдаг бөгөөд гурван стандарт Газар чөлөөлөлт, бусад холбогдох нөлөөлөлтэй холбоотой. Эдгээрт:

- иргэдийг нүүлгэн шилжүүлэх,
- орон нутгийн иргэдтэй гэрээ байгуулах,
- нөхөн олговрыг санал болгох зэргийг тусгана.

Орон нутагтай ажиллах эдгээр стандартуудад Рио Тинтогийн бүх төсөлд баримтлах ёстой дараах шаардлагуудыг тусгадаг.Тухайлбал,

- Иргэдийг дараах зарчмаар нүүлгэн шилжүүлнэ:

  a) наад зах нь "Газар чөлөөлөх болон албадан нүүлгэн шилжүүлэх" тухай ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 5-ыг ашиглах;

  b) Рио Тинтогийн олон нийттэй харилцах болон гадаад харилцааны газраас зөвлөгөө авсны дараа хэрэгжүүлэх;

  c) уул уурхайн тухайн бүтээгдэхүүний салбарыг хариуцсан захирлын шууд дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх зэрэг болно.

- Заавал дагаж мөрдөх гэрээ байгуулахдаа:

  a) Рио Тинтогийн олон нийттэй харилцах болон гадаад харилцаа, бизнесийн эрх зүйн хэлтсээс зөвлөгөө авна,

  b) уул уурхайн тухайн бүтээгдэхүүний салбарыг хариуцсан захирлын шууд дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

- Санал болгосон нөхөн олговрыг олгохдоо:

  a) орон нутгийн тэргүүн туршлагатай нийцүүлэх,

b) Рио Тинтогийн олон нийттэй харилцах болон гадаад харилцааны газраас зөвлөгөө авсны дараа,

c) уул уурхайн тухайн бүтээгдэхүүний салбарыг хариуцсан захирлын шууд дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

**Олон улсын стандартыг Монгол улсын хууль тогтоомжтой харьцуулсан нь**

*Хүснэгт 1*-д газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, Газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэх тухай ОУСК-ийн ГС5 (2006), ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 5 (2008) зэрэг олон улсын үйл ажиллагааны стандартуудыг хангаагүй зүйлсийг харуулна.

**Хүснэгт 17: Олон улсын шаардлагыг Монгол улсын хууль тогтоомжтой харьцуулсан нь**

| Газар чөлөөлөхтэй холбоотой гол заалт/асуудал | Монгол Улсын хууль тогтоомж | ОУСК / ЕСБХБ-ны бодлогын шаардлагууд (ГС/ГШ5) | Зөрүү, шаардлагатай арга хэмжээ |
|---|---|---|---|
| Газрыг хураан авах | Зөвхөн төрийн байгууллагуудын ашиг тусын төлөө газрыг хураан авах боломжтой. ОТ хураан авах боломжгүй. | ГС/ГШ5-ын бүх шаардлагыг хангаж, зохих нөхцөлийг бүрдүүлсэн бол газрыг эзэмших арга болгож хураан авч болно. | Зөрүү байхгүй. |
| Зөвшилцлийн үндсэн дээр газрыг худалдан авах | Монгол Улсын Иргэний хуулиар газрын эрхийг шилжүүлэх хууль эрхзүйн үндсийг хангаж өгсөн. | Олон улсын шаардлагын дагуу зөвшилцлөөр шилжүүлэхийг | Зөрүү байхгүй. |
| Хамрагдах этгээд | Зөвхөн бүртгэлтэй өмчлөгч, газар эзэмшигч эсвэл ашиглагчдыг хүлээн зөвшөөрнө. Газрыг хувиараа өмчилж, эзэмшиж ашигладаг бол энэ эрхийг албан ёсоор бүртгүүлдэг бөгөөд газрыг гэрээний дагуу түүний өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас худалдан авч болно. Бодит байдал дээр энэ нь зөвхөн орон сууцны зориулалттай газарт үйлчилнэ. Жишээ нь, хувийн өмч гэж бүртгэгдсэн өвөлжөө, хаваржаа байрлаж байдаг малчдын хувьд бэлчээрийг улсын өмч гэж үздэг ба бэлчээр ашиглах эрхийг ихэвчлэн бүртгүүлдэггүй. | Төслийн нөлөөлөлд өртсөн хүн (ТНӨХ) газар эзэмших хууль ёсны эрхгүй байх нь саад болох зүйл биш. Үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрсөн газар эзэмших эрхтэй хүмүүс, эрхгүй ТНӨХ нэхэмжлэлээсээ хамаарч ялгаатай туслалцаа авах эрхтэй байдаг. | Компани эзэмших албажуулсан эрхтэй эсэхээс үл хамааран нөлөөнд өртсөн хууль ёсны эзэмшигчдэд газраа алдсаны нөхөн олговор олгоно. Компани нь тухайн барилга байгууламж байрлаж байгаа газрыг эзэмших эрхтэй эсэхээс үл хамааран хууль ёсны ашиглагчдад нөхөн олговор олгоно. |

| | | | |
|---|---|---|---|
| Нөхөн олговор | Нөхөн олговрыг ихэвчлэн зөвшилцлийн үр дүнд олгоно.<br>Нөхөн олговор олгохдоо газрын улсын үнэ тарифт суурилсан байж болно.<br>Нөхөн олговрыг барилга байгууламжийн зах зээлийн элэгдүүлсэн үнэ цэнээр олгоно. | Нөхөн олговрыг зах зээлийн дундаж үнэ, үйлчилгээний зардал, нөлөөлөлд өртсөн хөрөнгийг дүйцэхүйц хэмжээнд нөхөн сэргээх зардалд үндэслэн орлуулах үнээр олгоно. | Компани энэ НШҮАТ-д заасны дагуу ГС/ГШ5-д дурдсан тодорхойлолт дээр үндэслэн газар, барилга байгууламжийн төлбөрийг нөхөн олгох болно. Нөхөн олговор нь аль болох мөнгөн бус хэлбэртэй (нөлөөлөлд өртсөн барилга байгууламжийг сэргээн босгох) байх болно. |

| Газар чөлөөлөхтэй холбоотой гол заалт/асуудал | Монгол Улсын хууль тогтоомж | ОУСК / ЕСБХБ-ны бодлогын шаардлагууд (ГС/ГШ5) | Ялгаа, шаардлагатай арга хэмжээ |
|---|---|---|---|
| Олон нийтийн эзэмшлийн нөөц баялаг устах | Тодорхой заалт байхгүй | Нөлөөлөлд өртсөн нийтийн нөөц баялгийн төлбөр болгож нөхөн олговор олгоно. | Компаниас нөлөөнд өртсөн нийтийн эзэмшлийн хөрөнгө нөөцөд нөхөн олговор олгох асуудлыг холбогдох олон нийтийн байгууллагатай хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ. |
| Орлого, амьжиргааг нөхөн сэргээх | Тодорхой заалт байхгүй | Амьжиргааг нөхөн сэргээх, газар нутаг, бусад эд хөрөнгө, ажил, орлого, амьжиргаа алдагдсанаас шалтгаалсан нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх. | НШҮАТ-д тодорхойлсны дагуу төслийн нөлөөлөлд өртсөн амьжиргааны тухайд компани амьжиргааг нөхөн сэргээх тусламж үзүүлнэ. |
| Эмзэг бүлгийн хүмүүс | Эмзэг бүлгийн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхэд гарах өөр бусад нөлөөллийн талаар тодорхой заалт байхгүй. | Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн эмзэг бүлгийн хүмүүст зориулан тусгайлан тусламж үзүүлнэ. | Компани эмзэг бүлгийн хүмүүсийг тодорхойлж, энэхүү НШҮАТ-нд заасанаар тусгайлан тусламж үзүүлнэ. |
| Санал гомдол барагдуулах журам | Газрын тухай хуулиар Засаг дарга, эцэст нь шүүхээр (60 дугаар зүйл) маргааныг хянан шийдвэрлэнэ. Иргэний хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд янз бүрийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх тухай заасан байдаг. | Нөлөөлөлд өртсөн хүмүүст зориулсан гомдол барагдуулах зохистой механизм шаардлагатай. | Компани энэ НШҮАТ-нд тодорхойлсноор нөлөөлөлд өртсөн хүмүүс хялбар ашиглах Боломжтой гомдол барагдуулж шийдвэрлэх механизмыг бүрдүүлнэ. |
| Мэдээллийн ил тод болгох, олон нийтийн хэлэлцүүлэг | Олон нийтийн хэлэлцүүлэг,мэдээллийн ил тод болгох талаар тодорхой заалт байхгүй бөгөөд эв зүйгээр гэрээний үндсэн дээр газрыг чөлөөлнө гэж заажээ. | Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст бүрэн мэдээлэл өгч, нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтийн хувилбаруудын талаар зөвлөлдөнө. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг танилцуулж, мөн зөвшилцөнө. | Компани нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлгээний нэг хэсэг хэмээн үзэж энэ ажлын үеэр НШҮАТ-г нийтэд танилцуулж, олон нийтээр хэлэлцүүлнэ. |

| Газар чөлөөлөхтэй холбоотой гол заалт/ асуудал | Монгол Улсын хууль тогтоомж | ОУСК / ЕСБХБ-ны бодлогын шаардлагууд (ГС/ГШ5) | Ялгаа, шаардлагатай арга хэмжээ |
|---|---|---|---|
| Хяналт шинжилгээ үнэлгээ | Орон нутгийн засаг захиргаа, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үүрэг хариуцлага. | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх журмыг бий болгох. | НШҮАТ-д тодорхойлсноор тус компани хяналт-шинжилгээ, үнэлгээний явцыг боловсруулсан. |

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2014-07-03

## Хавсралт 3: Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөө, нөлөөллийн бүс

| Төслийн талбай/ Байгууламж/ Талбай | Нөлөөллийн эх үүсвэр | Болзошгүй нөлөөлөл | Нөлөөллийн бүс |
|---|---|---|---|
| А.Уурхайн лицензийн талбай[21] | • Уурхайн лицензит талбайд ил уурхай, далд уурхай, барилгын түр кемп, захиргааны албаны өрөө тасалгаа байгуулах шаардлагатай ба байнгын хашаатай байлгаж, аюулгүй байдлыг хангахын тулд малчдад малаа бэлчээхийг хориглох болно.<br>• Үүнээс гадна уурхайн лицензит талбайн эргэн тойронд 10 км хориотой бүсэд өвөлжихийг хориглох боловч малаа бэлчээж, зусахыг зөвшөөрсөн хэвээр байна. | **Нүүлгэн шилжүүлэх (А1):**<br>• Уурхайн талбайдээр өвөлжөө бүхий бүх малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх.<br>• Уурхайн лицензит талбайн хашаан дотор байрлах 8.625 га бэлчээрийн талбай устах . | **А1** Албан ёсоор тасалбар болгосон 2004 оны 1-р сарын 28-ны өдрийн байдлаар уурхайн лицензит талбай дотор өвөлжөөтэй бүх малчин өрх. |

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ ХУУДАСНААС ХАРНА УУ

| | | | |
|---|---|---|---|
| Б. Нисэх онгоцны буудлын талбай | • Газар шорооны ажил болон холбогдох үйл ажиллагаа нь дуу чимээ, шороо тоос үүсгэнэ.<br>• Нисэх онгоцны буудлын талбайд нисэх зурвас, холбогдох байгууламжууд барьж хашаалах бөгөөд аюулгүй байдлыг хангах үүднээс малчдад малаа бэлчээхийг хориглоно.<br>• Агаарын тээвэр үйл ажиллагааны явцад дуу чимээ үүсгэж болзошгүй. | **Эдийн засгийн хохирол, зуны бэлчээр (Б1, Б2)-ийн талбай устах:**<br>• Түр зуурын нисэх онгоцны буудал барихад бэлчээрийн 46 га талбайг түр зуур хөндөж, дараа нь нөхөн сэргээнэ.<br>• Байнгын нисэх буудлын талбайн хашаан дотор байрлах бэлчээрийн 230 га талбай устана.<br>• Зуны бэлчээрээ ашиглах боломжоо алдсаны улмаас эдийн засгийн хохирол үүснэ.<br>• Нисэх буудлын үйл ажиллагаанаас бага зэргийн дуу чимээний нөлөөлөл үүсэх. | **Б1** Нисэх буудлын талбайгаас 5 км-ийн дотор газар эзэмших эрхтэй болон малаа бэлчээх уламжлалт харилцаатай[22] бүх малчин өрх.<br>**Б2** Нисэх буудлын талбайгаас 5-11 км-ийн дотор газар эзэмших эрхтэй болон малаа бэлчээх уламжлалт харилцаатай бүх малчин өрх. |
| **Төслийн талбай /Байгууламж/Талбай** | **Нөлөөллийн эх үүсвэр** | **Болзошгүй нөлөөлөл** | **Нөлөөллийн бүс** |

[21] Уурхайн талбайд УЛТ, 10 км оршин суух хориотой бүс орно.

[22] Өвөлжөө, хаваржаа аль аль нь газрын гэрчилгээ авах хууль эрх зүйн үндэс болдог. Ихэнх малчид өвөлжөөтэй, цөөн хэд нь хаваржааны гэрчилгээтэй байна. Уурхайн барилгын үйл ажиллагааны улмаас ямар ч орон сууцанд нөлөөлөл үүсээгүй, мөн хаваржааг орлуулах ямар ч шалтгаан байхгүй тул нөхөн олговор олгох Ажлын хэсэг болон нөлөөлөлд өртсөн малчид өвөлжөөг нөхөн олговор авах ангилалд хамрагдах үндсэн шалгуур болгон ашиглана гэж тохиролцсон байна.

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ ХУУДАСНААС ХАРНА УУ

| | | | |
|---|---|---|---|
| ОТ-ГС зам | • Шимт хөрс хуулалт, хүмүүс, тоног төхөөрөмж бэлчээрийг сүйтгэнэ.<br>• Газар шорооны ажил болон холбогдох үйл ажиллагаа нь дуу чимээ, шороо тоос үүсгэнэ.<br>• Хүнд даацын тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөн мал амьтан, хүнд зам хөндлөн гарахад хүндрэл учруулна.<br>• Зам болон хажуугийн зурвас зам хөндлөн гарч буй амьтдад саад болно. | **Бэлчээр хуваагдах (В1):**<br>• Зам барилгын ажил/шинэчлэлтэд ойролцоогоор 220 га бэлчээр сүйтгэгдэх<br>• Барилгын ажлын үеэр их хэмжээний дуу чимээ, тоос шороо үүсэх, тоног төхөөрөмж, хүмүүсээс үүсэх аюул.<br>• Зам (хөдөлгөөн нэмэгдэх) ашиглах үйл ажиллагааны үр дүнд бэлчээр хуваагдах.<br>• Замын их хөдөлгөөн урсгал, холбогдох аюулаас шалтгаалж их хэмжээний саад тотгор учруулах. | **В2** Оюу Толгойн - Гашуун Сухайтын замын хоёр талд **500 м-ийн дотор** өвөлжөөтэй бүх малчин өрхүүд. |
| | | **Мал аж ахуйн үйл ажиллагаанд саад учруулах (В2):**<br>Замаас холдохын тулд нүүдлийн хэв маягт өөрчлөлт орох; хөршүүдтэйгээ зөрчилдөх, зарим газар бэлчээр талхлагдах.<br>Барилгын ажлын явцад дуу чимээ, шороо тоосны багаас дунд зэргийн нөлөөлөл.<br>Хөдөлгөөний улмаас зам ашиглах явцад байнгын дуу чимээ, аюулгүй ажиллагааны асуудлууд үүсэх. | **В2** Оюу толгойн - Гашуун Сухайтын замын хоёр талд **500 м-6.5 км-ийн дотор** өвөлжөөтэй бүх малчин өрхүүд. |
| Г. Гүний Хоолойн усны шугам хоолой, БНХАУ-аас цахилгаан дамжуулах шугам* | • Шимт хөрс хуулалт, шугам хоолой / усны цооногийн ил шуудуу, хүмүүс, тоног төхөөрөмж бэлчээрийг сүйтгэнэ.<br>• Цахилгаан дамжуулах шугам барихаар өнгөн хөрс хуулах, хүмүүс болон тоног төхөөрөмж дэргэд нь ажилласнаас бэлчээрт сөрөг нөлөө учруулах.<br>• Газар шорооны ажил болон холбогдох үйл ажиллагаа нь дуу чимээ, шороо тоос үүсгэнэ.<br>• Цооног/насос, дамжуулах шонгийн суурь, байгууламж тус бүрийн дагуу нэг эгнээ бүхий ойролцоогоор 3.5 м өргөнтэй замын засвар. | **Байнгын бэлчээр хуваагдах (Г1):**<br>• Шимт хөрс хуулах, бусад холбогдох барилгын үйл ажиллагаанаас бэлчээрийг түр хугацаагаар хөндөх.<br>• Ил суваг шуудуу гаргах, хүнд тоног төхөөрөмж ажиллуулснаар бэлчээр хуваагдах.<br>• Барилгын ажлын үеэр их хэмжээний дуу чимээ, тоос шороо үүсэх, тоног төхөөрөмж, хүмүүсээс үүсэх аюул. | **Г1** Дараах зайд өвөлжөө нь байрлах бүх малчин өрхүүд:<br>• 1-р үе шатны Усны шугам хоолой ЭСВЭЛ дамжуулах шугамын хоёр талд **1 км**.<br>• 2-р үе шатны Усны шугам хоолойн хоёр талд 3 км.# |

| Төслийн талбай/ Байгууламж/Талбай | Нөлөөллийн эх үүсвэр | Болзошгүй нөлөөлөл | Нөлөөллийн бүс |
|---|---|---|---|
| | | **Мал аж ахуйн үйл ажиллагаанд саад учруулах (Г2):**<br>• Мал аж ахуйн үйл ажиллагаанд саад учруулах, аюул ослоос сэргийлэх үүднээс малаа хариулахад их цаг зарцуулах.<br>• Барилгын ажлын явцад дуу чимээ, шороо тоосны багаас дунд зэргийн нөлөөлөл. | **Г2** Дараах зайд өвөлжөө нь байрлах бүх малчин өрхүүд:<br>• 1-р үе шатны Усны шугам хоолой ЭСВЭЛ дамжуулах шугамын хоёр талд 1-2 км.<br>• 2-р үе шатны Усны шугам хоолойн хоёр талд 3-7 км. |
| Д. Ханбогд суман дахь зуны бэлчээр | • Уурхайн лицензит талбай, онгоцны буудлын талбайг хаших.<br>• Оюу Толгой-Гашуун Сухайтын зам, Гүний Хоолойн усны шугам, цооногийн талбай, цахилгаан дамжуулах шугам барих. | **Нийтийн бэлчээрийн газар үгүй болох (Д1):**<br>• Барилгын ажлын үед газар хөндөгдөхийг оруулаад Оюу Толгой төслийн барилга байгууламжийн хувьд ойролцоогоор 10,500 га алдагдахаар байна.<br>• Орон нутгийн малчид цаашид энэ нутаг руу нүүх боломжгүй тул бэлчээр ашиглалтын үед зөрчил үүсэх, бэлчээрийн талхагдал нэмэгдэж болно. | **Д1** Ханбогд сумын нутагт бэлчээр ашиглах уламжлалт эрх бүхий бүх малчин өрх. |
| Е. Эзэнгүй өвөлжөө (бүх нөлөөллийн бүсэд) | • Барилгын үйл ажиллагаа түр зуур эзэнгүй өвөлжөөг ашиглах боломжгүй болгож болно (тухайлбал тухайн өрх сумын төвд оршин суудаг байж болно). | **Хуримтлагдсан нөлөөлөлд өртөх (Е1)**<br>• Цагаан хадны ачааны автомашины зогсоолоос үүссэн хуримтлагдах нөлөөллөөс шалтгаалж нөлөөллийн бүсээс нүүсэн оршин суугч боловч тухайн өвөлжөөг эзэмшигч хэвээр байна.<br>**Мал аж ахуйн үйл ажиллагаанд саад учруулах (Е2):**<br>• Эзэнгүй өвөлжөө нь шууд нөлөөлөлд өртөх магадлал багатай боловч эд хөрөнгийг эзэмшигч хэвээр байдаг. | **Е1** Цагаан Хад орчмын ОТ-Гашуун Сухайтын замын нөлөөллийн бүс.<br>**Е2** тохиролцсон нөлөөллийн бүсэд эзэнгүй өвөлжөөтэй бүх малчин айл. |

| Төслийн талбай/ Байгууламж/Талбай | Нөлөөллийн эх үүсвэр | Боломжит нөлөөлөл | Нөлөөллийн бүс |
|---|---|---|---|
| Нэмэлт нөлөөлөл ** (бүх нөлөөллийн бүсэд) | • Барилгын үйл ажиллагаа, байнгын барилга байгууламжтай болох мал аж ахуй, тхуайлбал худаг уснаасаа холдоно.<br>• Давхар нөлөөлөл (давхацсан нөлөөллийн бүсүүдэд байрлаж буй өрхүүд). | **Нөлөөлөлд өртсөн малчдад үзүүлэх нэмэлт нөлөөлөл:**<br>• Барилгын ажил эсвэл үйл ажиллагааны явцад худаг ашиглах боломжгүй болох буюу хязгаарлагдах.<br>• Долоон өрх нэгээс олон нөлөөллийн буюу давхар нөлөөлөлд өртөж байгаа тул нэмэлт нөхөн олговор авна. | Худаг/усны нөлөөлөлд өртсөн улирлын шинж чанартай бүх малчин өрх.<br>Бүх өрхүүд нэгээс олон нөлөөллийн ангилалд хамрагдана. |

*# Тайлбар: Гүний Хоолойн усны шугам, цооногийн талбайн 1-р шат нь уурхайн талбайгаас усны цооногийн талбай хүртэлх шугамыг илэрхийлдэг. 2-р шат (Зураг 15.2-ийг үзнэ үү) нь үндсэн шугам хоолойгоос цооног бүрт холбогдох нэмэлт дамжуулах хоолой, усны цооногийн талбайг илэрхийлдэг.*

*Эдгээр тодорхойлолтуудыг (барилгын ажлын явцтай ямар нэг байдлаар холбоогүй) 2011 онд шугам хоолой, усны цооногийн талбайн ойр орчмын малчидтай ярилцаж гаргаж авсан. Хэлэлцүүлгийн үеэр Усны цооногийн талбай (2-р шат)-д ус дамжуулах шугам хоолой, худаг/насос станц/усан сан зэрэг шугаман ус дамжуулах шугам хоолойн (1-р шат) барилгын ажил малчдад газартай холбоотой янз бүрийн саад тотгорыг бий болгох нь тодорхой болсон юм. Тийм учраас малчдад үзүүлэх нөлөөллийг бодитоор харуулахын тулд эдгээр нөлөөллийн бүсүүдийг ялгаатайгаар тогтоосон юм.*

** Дамжуулах шугам, усны шугам хоолой, усны цооногийн талбайн өрхүүд төстэй байдлаар нөлөөлөлд өртсөн тул нэг бүлэгт оруулсан. (ө.х. барилгын ажлын сөрөг нөлөө, газар дээрх байнгын жижиг байгууламж)*

*** Айл өрхүүд нь нөлөөллийн өөр ангилалд тоологдсон байна.*

## Хавсралт 4: Оюу Толгой төслийн нөхөн олговрын багц, 2011

| Нөлөөллийн төрөл | Нөлөөллийн эх үүсвэр (ба Ангилал) | Хамрагдах нөхцлүүд | Нөхөн олговрын багц |
|---|---|---|---|
| Нүүлгэн шилжүүлэлт | Уурхайн талбайд байгаа ил уурхай болон бусад уурхайн барилга байгууламжийг өргөжүүлэх, 10 км-ийн зайнд нөлөөллийн бүсийг тогтоох[23] (Нөлөөллийн ангилал А1) | Тохиролцсон нөлөөллийн бүс дэхь өвөлжөө | **Нүүлгэн шилжүүлэлтийн багц:** Үүнд:<br>• Шинэ өвөлжөө, малын хашаа, хороо, газрын гэрчилгээ<br>• Нэг гэр бүлийн гишүүнд дээд боловсрол олгох тэтгэлгийг нэг байнгын ажлын байрыг<br>• Шинэ худаг, 15 ямаа, 15 хонь, 2 тэмээ, 2 дээд боловсролын тэтгэлэг, малын тэжээл<br>• Сургалтын хөтөлбөр, ж.нь. бэлчээрийн менежмент, бизнесийн хөгжил г.м. |
| Эдийн засгийн нөхөн олговор (зуны бэлчээрийн алдагдал) | Онгоцны буудлын барилгын ажил үйл ажиллагаа (Нөлөөллийн ангилал В1, В2) | Тохиролцсон нөлөөллийн бүс дэхь өвөлжөө[24] | **Байнгын ажлын байр** (нэг өрхийн нэг хүнд): (мал аж ахуйн үйл ажиллагаанаасаа хөндийрөхгүйгээр гүйцэтгэх боломжтой ажил үүргийг малчидтай зөвшилцсөний үндсэн дээр олгох (байгаль орчин, бэлчээрийн мониторинг хийх).<br>БА<br>**Амьжиргааг дэмжих нөхөх олговрын багц**: бизнесийг бусад хүмүүстэй хамтран эхлүүлэх, өргөжүүлэх, тухайлбал, хөрөнгө худалдан авах, сайн үүлдрийн мал худалан авах, бизнесийг өргөжүүлэх,, сургалт, г.м.<br>БА<br>Хэрэв ТОДОРХОЙ ШАЛГУУРЫГ ХАНГАВАЛ [#]<br>**Боловсролын дэмжлэг:** Оюутны (нэг сургалтын хөтөлбөр)-ийн дээд боловсролын сургалтын тэтгэлэг; сургуулийн сурагчдад зориулсан дэмжлэг (жилд нэг удаа бүх сурагчдад).<br>**Богино хугацааны сургалт:** (1 удаа, Монголд 45 хоногийн богино хугацааны). |
| Бэлчээрийг хуваах | Гашуун Сухайтын зам болон Гүний Хоолойн | Тохиролцсон нөлөөллийн | **Байнгын ажлын байр** (нэг өрхийн нэг хүнд): ( мал аж ахуйн үйл ажиллагаанаасаа хөндийрөхгүйгээр гүйцэтгэх боломжтой ажил үүргийг малчидтай зөвшилцсөний |

[23] Уурхайн талбай гэдэгт Уурхайн лицензийн талбай болон 10 км-ийн радиустай оршин суухыг үл зөвшөөрөх талбай багтана

[24] Өвөлжөө болон хаваржаа нь эзэмших бололцоотой юм. Бүх айлд өвөлжөө байх ч цөөн айлд хаваржаа байдаг учраас хэлэлцэн тохирсны үндсэн дээр өвөлжөөг нөхөн олговор олгох эсэхийг тодорхойлох гол шалгуур болгосон.

| | | | |
|---|---|---|---|
| | цооногийн талбай, усны цооногийн талбай, цахилгаан дамжуулах шугам (Нөлөөллийн ангилал С1, D1) Барилга, Оюу Толгой төслийн үйл ажиллагаа | бусэд өвөлжөө | үндсэн дээр олгох (байгаль орчин, бэлчээрийн мониторинг хийх).<br>БА<br>**Амьжиргааг дэмжих нөхөх олговрын багц**: бизнесийг бусад хүмүүстэй хамтран эхлүүлэх, өргөжүүлэх, тухайлбал, хөрөнгө худалдан авах, сайн үүлдрийн мал худалан авах, бизнесийг өргөжүүлэх,, сургалт, г.м.<br>БА<br>**Боловсролын дэмжлэг:** Оюутны (нэг сургалтын хөтөлбөр)-ийн дээд боловсролын сургалтын тэтгэлэг; сургуулийн сурагчдад зориулсан дэмжлэг (жилд нэг удаа бүх сурагчдад)[25].<br>Хэрэв ТОДОРХОЙ ШАЛГУУРЫГ ХАНГАВАЛ[#]<br>**Богино хугацааны сургалт:** (1 удаа, Монголд 45 хоногийн богино хугацааны). |
